

# **Монголын Бурханы Шашинтнуудын Байгаль Хамгаалах Үйл Ажиллагаа**

ШАШИН, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨГЖЛИЙН ТУХАЙ ГАРЫН АВЛАГА

Номыг бүтээгчид: Чимэдсэнгээгийн Уртнасан, Амбер Криппс, Виктория Финлэй, Батчулууны Мөнхбаатар, Да лам Хөнхөрийн Бямбажав

Энэхүү гарын авлагыг Шашин ба Байгаль Хамгаалах Холбооноос (ARC) Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийд, Монголын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам болон Трибьютери Сантай хамтран бүтээв. Монголын Байгаль Орчны Яамны дэмжлэгээр МБШТөв Гандантэгчэнлин хийдээс эл номыг Монгол хэлрүү хөрвүүлэн, хэвлүүлсэн бол Дэлхийн Банкны NEMO (Нидерланд Монголын Хамтарсан Байгаль Орчны Итгэмжлэлийн Сан II) сангоос санхүүжүүлсэн болно.

Улаанбаатар хот

2009 он

DDC  
294.337  
B-435

Энэхүү материал нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул зөвшөөрөлгүй хувилах, ашиглахыг хуулиар хориглоно. Уг номны аль нэг хэсгийг хувилах, олшруулахыг хүсвэл, Шашин ба Байгаль Хамгаалах Холбоонд доорх хаягаар хандана уу.

The Alliance of Religions and Conservation, The House, Kelston Park, Bath BA1 9AE, UK, or email to [info@arcworld.org](mailto:info@arcworld.org)

Орчуулагч: Батчулууны Мөнхбаатар  
Монгол орчуулгыг хянан тохиолдуулсан: Да лам Хөнхөрийн Бямбажав  
Хавтасны зургийг н. Дөлгөөн.  
Улаанбаатар хот  
Монгол улс

**ISBN: 978-99929-962-0**

## **АГУУЛГА**

|  |           |
|--|-----------|
| <b>Өмнөх үг: Бурханы шашинтнууд ба Байгаль орчин</b> .....   | <b>4</b>  |
| <b>Тэргүүн бүлэг: Түүх, жишээ, чадамж ба итгэл үнэмшил</b> .....   | <b>7</b>  |
| <b>1: Монголын бурханы шашин</b> .....   | <b>9</b>  |
| <b>2: Байгаль орчныг хамгаалах талаар бурханы шашинтнууд юу гэж сургадаг вэ</b> .....                      | <b>14</b> |
| <b>3: Сүүлийн жилүүдэд бурханы шашинтнууд байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрхэн ажилласан нь</b> ..... | <b>22</b> |
| <b>4: Ирээдүйн боломж</b> .....  | <b>25</b> |
| <b>5: Лам хуврагуудтай хэрхэн хамтран ажиллах вэ</b> .....   | <b>27</b> |
| <b>Дэд бүлэг: Баримтын судалгаа</b> .....  | <b>31</b> |
| <b>Гутгаар бүлэг: Байгууллагууд</b> .....  | <b>42</b> |
| <b>Дөтгөөр бүлэг: Хавсралтууд</b> .....  | <b>58</b> |
| <b>1. Нэрсийн тайлбар ба товчилсон нэрсийн тодруулга</b> .....   | <b>58</b> |
| <b>2. Монгол дахь шашнуудын тухай</b> .....  | <b>61</b> |
| <b>3. Бурханы шашны лидерүүд</b> .....   | <b>62</b> |
| <b>4. Онгон дагшин шүтлэгт уулсын нэрсийн жагсаалт</b> .....   | <b>64</b> |
| <b>5. Найман жилийн төлөвлөгөөний танилцуулга</b> .....  | <b>69</b> |
| <b>Ном зүй</b> .....   | <b>82</b> |

## **ӨМНӨХ ҮГ: Бурханы шашинтнууд ба байгаль орчин**

*“Бид Бурханы гэгээний сургасанчилан байгальтайгаа эв зохицолтой, амар жимэр амьдрах хэрэгтэй. Үүнийг хүмүүс бид л хийх ёстой. Энэ гарагийг аврахын тулд экологийн шинэ урсгалыг эрж хайх хэрэгтэй бөгөөд бид өөрсдийн туулж ирсэн амьдралаа эргэн цэгнэж үзэх хэрэгтэй болов уу. Нийтийн сайн сайхны төлөө хамтдаа хичээн хөдөлмөрлөх хэрэгтэй эс бөгөөс бид зөв шийдэлд хүрч чадахгүй. Аминч үзлийг гэж баялгаа тэгш зөв хуваан, хариуцлагаа ч хамт үүрч, илүү энгийнээр амьдрах аваас бид энэ ертөнцийн зовлон зүдгүүрийг бууруулж чадах билээ.” Экологийн сэдэвт хурал дээр бурханы шашинтнуудын хийсэн мэдэгдэл. 1996 он<sup>1</sup>*

*“Би бээр шашин шүтлэгээс ангид, ой гутам муйхар стратегийг сонгосон тэр л залгамж үеийнхний нэг нь байлаа.” хэмээн 1.3 сая гишүүнтэй Америкийн хамгийн анхны, хамгийн том байгаль хамгаалах Сиерра Клубын гүйцэтгэх захирал Карл Попе өгүүлжээ.*

1990 оноос эдүгээг хүртэл Монгол оронд байгаль орчныг хамгаалах салбарт олон байгууллага бий болж байгалийн бохирдлыг бууруулах, сүйрлийн ирмэгт хүрээд байгаа ойжуулах асуудалд анхаарал хандуулах, экологийн жуулчлалыг хөгжүүлэх болон ан амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн хэдий ч эдгээр байгууллагуудаас цөөн хэд нь Монголын нийгмийн түүхэн хэсэг, нөлөө бүхий, өргөн цар хүрээтэй байгууллага болох бурханы шашны сүм хийдүүдтэй харилцаа тогтоосон байдаг. Энэхүү гарын авлага эдгээр байгууллагуудаас сүм хийдүүдтэй хамтран явуулсан үйл ажиллагаануудынх нь тухай дэлгэрэнгүй өгүүлэхийн зэрэгцээ Монголын лам хуврагуудын тухай ойлголтыг уншигч таньд өгөх юм.

Энэхүү гарын авлага нь лам хуврагуудтай хэрхэн хамтран ажиллахын тухайтад бичигдсэн хамгийн анхны лавлагаа ихтэй удирдамж ном билээ. Бурханы шашны уламжлалт байгаль хамгаалах арга зам нь байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоодын байгаль орчны байгууллагуудын хувьд чухал судлагдахуун болж байна.

Энэхүү гарын авлага нь нийт дөрвөн бүлгээс бүрдэнэ. Тэргүүн бүлэгт итгэл үнэмшил, сургаал номлол, бүтцээрээ дамжуулан байгаль орчныг хамгаалбал бурханы шашны сүм хийдүүдэд ямар их бололцоо байгааг түүх, жишээгээр харуулахын зэрэгцээ ирээдүйд байгаль орчныг хамгаалах салбарт лам хуврагуудын оруулах чадамжийг тодорхойлон гаргасан юм. Түүнчлэн лам хуврагуудтай хэрхэн харилцаа тогтоох, тэдэнтэй уулзахдаа болон сүм хийдээр нь зочилохдоо юуг анхаарах ёстой зэрэгт тустай зөвлөгөөг ч өгөх болно.

Дэд бүлэгт байгаль орчны чиглэлээр дорвитой үйл ажиллагаа явуулж байгаа Монголын сүм хийдүүдийн талаарх баримтын судалгааг оруулсан бол гутгаар бүлэгт Монголд энэ салбарт үйл ажиллагаагаа явуулж буй гол сүм хийдүүд,

---

<sup>1</sup> Палмер ба Финлэй, Шашинтнууд байгаль хамгаалах үйлст, Дэлхийн Банк 2002 (xx77-82)

байгууллагуудын талаарх мэдээлэл, харилцах хаягийг оруулсан. Монголын бурханы шашныг сонирхогчдод зориулсан нэрсийн тайлбарыг хавсаргав.

Төгсгөлд нь бурханы шашинтнууд болон тэдэнтэй хамтран ажиллагсдад Монголын бурханы шашны байгаль хамгаалах ухааныг өнөө цагийн байгаль хамгаалах аргатай хослуулбаас хэтийн ирээдүй байгааг харуулсан Найман жилийн төлөвлөгөөг хавсаргасан болно. Эл төлөвлөгөө нь НҮБ/ARC-аас хэрэгжүүлж буй Үе дамжсан өөрчлөлтийн төлөвлөгөөг зохиох хөтөлбөртэй харилцан уялдаатай.

Энэ гарын авлагыг ARC-аас санаачилан Дэлхийн Банк, ТТФ-ийн дэмжлэгээр байгаль орчны байгууллага, бурханы шашны сүм хийд, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудыг нэгдсэн үйл ажиллагаагаар Монгол орны байгаль орчныг өнөө, хойчид хадгалан хамгаалахад нь дэмжлэг болгох үүднээс тэдгээр байгууллагуудын уншигчдад зориулан бүтээв. Эл номыг бүтээхэд лам хуврагуудын дэмжлэг их байсныг дурьдах нь зүйтэй. Дэлхийн Банк, МБШТөв Гандантэгчэнлин хийд зэрэг байгууллагууд хамтран оролцсон бол Нидерланд Монголын Хамтарсан Байгаль Орчны Реформын Итгэмжлэлийн Сан (NEMO)-гаас санхүүжүүлсэн юм.



## ТЭРГҮҮН БҮЛЭГ

---

Монгол улс нь өнө эртний байгаль хамгаалах ёс уламжлалынхаа нөлөөгөөр хадгалан авч үлдсэн чухалчилан хамгаалах байгаль экологитой орон юм. Тэдгээр нандин ёс уламжлалуудыг орчин үеийн үймцээт цаг үед дахин сурвалжлан тогтоож байна.

Багануурын нүүрсний уурхай нь Улаанбаатар хотоос зүүн зүгт 140 километрын зайтай орших бөгөөд жилдээ 2.5 сая тонн нүүрс олборлодог. Олборлолтын үр дагавараар тухайн газарт агаарын бохирдол, уушигны өвчин болон эвдэгдэн сүйдсэн байгаль үлджээ. 2005 онд орон нутгийн Онцар Ешэи Лин хийд нь Дэлхийн Банкны NEMO сан болон Япон улсын мэргэжлийн багийн тусламжтайгаар уурхайгаас байгаль орчин болон хүний эрүүл мэндэд учруулж байгаа сөрөг нөлөөг баримтжуулах төсөл хэрэгжүүлсэн байна. Төслийн хүрээнд уурхайчид болон тэдний гэр бүлийг эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүчин зүйлүүдийн хор нөлөөг хэрхэн бууруулж болох тухай сургалтанд хамруулжээ. Уурхайн удирдлагаас ард иргэдийн зүй ёсны шаардлагад буулт хийн орчныг хоргүйжүүлэх асуудлыг анхааралдаа авсан бол орон нутгийн сургуулиудын сургалтын хөтөлбөрт бурханы шашны уламжлалт байгаль хамгаалах ойлголтыг оруулсан байна.

ARC, Английн Элчин Сайдын Яам, Монгол улсын засгийн газар хамтран хамгаалалттай бүсээс мод хулгайгаар огтлон орон нутгийн хоолны газарт борлуулж байсан ядуу хүүхдүүдэд зориулсан экологийн хөтөлбөрийг (Чингис хааны үеийн нийслэл Хар Хорин) Эрдэнэзуу хийд дээр явуулсан нь цагаа олсон үр дүнтэй ажиллагаа болж чаджээ. Тус хийдийн лам хуврагууд тэдгээр хүүхдүүдийг ар гэрийнх нь хамтаар амьдрах ухааны сургалтанд хамруулсан нь хүмүүсийн сэтгэлд хүрч чадсан юм. 2005 онд 50 хүүхэд амьдрах ухааны сургалтанд нийт 40 цаг хамрагдан уламжлалт байгаль хамгаалах ухаан болон бурханы шашны сургаалтай танилцаж өөрийгөө болон бусдыг хүндлэх, бие даан шийдвэр гаргах, бүтээлчээр сэтгэх ухаанд суралцжээ. Олны танил болсон уг үйл ажиллагаа нь 2006 онд дараагийн 50 хүүхдийг хамруулсаны дээр эцэг, эхийг нь ч бас өөрсдийнх нь хүсэлтээр тухайн хөтөлбөрт хамруулсан байна. Лам хуврагуудын явуулсан энэ үйл ажиллагаа нь зарим хурцадмал асуудлыг тодорхой хэмжээгээр бууруулж чадсан юм. Сургалтын дараа хүүхдүүд Монгол орныхоо ой мод баялагийн талаар илүү их мэдлэгтэй болж завсардаад байсан сургуульдаа эргэж орцгоожээ. Үр дүнд нь зарим хоолны газар түлшний өөр хувилбарыг сонгож эхэлсэн.

Улаанбаатар хотод байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг дэмжих зорилготой “Бурханы шашны холбоо” байгуулагдсан аж. “Манай холбооноос цар хүрээгээр том биш ч гэлээ хүмүүсийн сэтгэхүйд нөлөөлөхүйц үйл ажиллагааг явуулдаг.” хэмээн тус холбоог үүсгэн байгуулагчдын нэг Б.Элбэгзаяа өгүүлсэн юм. Байгуулагдсан цагаасаа эхлэн хүмүүст байгаль хамгаалахын ач холбогдлыг онцлон таниулж ирсний зэрэгцээ лам хуврагууд, Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн оюутнуудтай хамтран орчны цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэх, Гандан хийдийн хүрээнд мод суулгах, лам хуврагуудад зориулсан байгаль орчны цахим хуудсыг хөгжүүлэх, тэднийг олон нийттэй харилцах урлагт суралцахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллаж байлаа. Ялангуяа орчны цэвэрлэгээний ажилд лам хуврагуудыг оролцуулсан нь энгийн

хүмүүст сайхан сэтгэгдэл төрүүлсэн төдийгүй байгаль орчныг хамгаалах нь ямар их ач холбогдолтой болох мөн түүний төлөө лам хуврагууд бохир заваан гэлтгүй ажилладгыг харуулсан явдал болсон юм. Монголын бурханы шашны байгууллагууд үр бүтээлтэй, олон түмэнд хүрсэн үйл ажиллагаа явуулж байгаль орчноо бодитоор хамгаалж байгаа тухай гурван жишээг энд дурьдав. Түүнчлэн өөр олон жишээг уншигч танд хүргэх болно.

Мөн энэ гарын авлагаараа өөр илүү олон сүм хийд, шашны байгууллагууд энэ чиглэлээр ажиллаж болох талаар боломжийн санаа өгөхийн зэрэгцээ Монголын бурханы шашны түүх ба Монголчууд байгаль орчны талаар ямар итгэл үнэмшилтэй байдаг тухай өгүүлэх юм.

Тэргүүн бүлгийн нэгдүгээр хэсэгт Монголын бурханы шашны статистик тоо баримт, түүх, нөлөө болон Монголчуудын нийтлэг итгэл үнэмшлийн тухай өгүүлэх бөгөөд хоёрдугаар хэсэгт овоо тахилга ба онгон дагшин газар орны ач холбогдол зэргийг тухайлан өгүүлсэн. Гуравдугаар хэсэгт Монголын бурханы шашинтнуудын байгаль хамгаалах чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааг, дөрөвдүгээр хэсэгт лам хуврагууд ирээдүйд үйл ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэх боломжтойг, тавдугаар хэсэгт лам хуврагуудтай хэрхэн харилцаа тогтоох, байгаль орчны асуудлаар хэнтэй харилцах, мөн сүм хийдийн газар биеэ хэрхэн зөв зохистой авч явах талаар удирдамж өгнө.

Дэд бүлэгт сүм хийдүүдийн талаарх чухал баримтын судалгаа, хэрэгтэй мэдээллийг багтаасан бол гутгаар бүлэгт байгаль орчны салбарт ажиллаж байгаа байгууллагуудын мэдээллийг оруулав.

Дөтгөөр бүлэгт холбогдох нэрсийн тайлбарыг Монголын бурханы шашинтнуудын “Үе дамжсан өөрчлөлтийн найман жилийн төлөвлөгөө”-г зохиох удирдамжийн хамт хавсаргав.

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: МОНГОЛЫН БУРХАНЫ ШАШИН



Монгол орны хувьд XIII зуунаас XX зууны эхэн үе хүртэл бурханы шашин гол шашин байв. Харин XI зуун буюу Чингис хааны сэргэн мандалтаас багаар бодвол 2 зууны өмнө Монгол оронд бурханы шашин дэлгэрч байсныг археологийн олдворууд баталдаг. 1920 оноос 1990 он хүртэлх коммунист дэглэм тогтсон 70 жилийн хугацаанд шашингүй үзлээр замнасан бөгөөд 1930-аад оны сүүлээр улс төрийн бодлогоор бурханы шашныг хориглож, лам хуврагуудыг аймшигтайгаар хэлмэгдүүлэн сүм хийдийг нь сүйтгэсэн байна. Ингэхдээ эрдэм номтой дээд лам нарыг устган, дунд лам нарыг шорон гянданд хорьж, бага залуу лам нарыг хүчээр энгийн ард болгож байжээ.

1992 онд баталсан үндсэн хуулиар иргэний шашин шүтэх эрх, эрх чөлөөг баталгаажуулснаар лам хувраг, сүм хийдүүд Монголчуудын өдөр тутмын амьдралд эргэн ирсэн. Гурван сая шахам хүн амын 1.5 сая нь бурханы шашныг шүтдэг тул энэ шашин нь Монгол улсын гол шашин мөн. Хүн амын 40 хувь нь шашингүй үзэлтэн байхад 4/10 орчим хувь нь лалын шашинтан бөгөөд үлдсэн 6 хувийг нь христэд итгэгчид, бөө мөргөлчид болон өөр бусад шашинтнууд эзэлдэг байна.

Бурханы шашныг дахин сэргэхтэй зэрэгцэн Улаанбаатар хотод христийн шашны сүм хийдүүд олноор байгуулагдаж байгаа бөгөөд Казах угсаатны амьдарч байгаа Монгол орны баруун хэсэгт лалын шашны сүмүүд ч байгуулагдаж байна.

2005 онд хийсэн статистикийн судалгаагаар бурханы шашны 157 сүм хийд, христийн шашны 70 сүм, лалын шашны 7 сүм, өөр бусад шашны 6 сүм тоологдсон бол 2'349 бурханы шашны лам хувраг, 223 христийн шашны номлогч, 349 лалын шашны номлогч өөр бусад шашны 6 номлогч бүртгэгдсэн байна. Христийн шашны ихэнх сүм Улаанбаатар хотод байршилтай байх бөгөөд лалын шашны 1 сүм Улаанбаатар хотод бусад нь нутгийн баруун бүсэд байдаг аж. Нийт шашин судлалын чиглэлээр 5'000 гаруй их сургуулийн насны оюутан, 2'400 орчим насанд хүрсэн оюутан суралцдаг бол тэдгээрийн тал орчим хувь нь бурханы шашны чиглэлээр сонгон суралцдаг. Лам хуврагуудын талаас илүү хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байна. Нийслэл хотод бурханы шашны 27 сүм хийд байдаг бол үлдсэн 150 сүм хийд нь аймаг, сумдад тархсан байдаг.

Мөн Монголын бурханы шашны түүхэнд шинээр гарсан зүйл бол эмэгтэй санваартнууд бөгөөд өдгөө Улаанбаатар хотод хэд хэдэн эмэгтэй хуврагуудын хийд хурал номын үйл ажиллагаа явуулж байна.

## **Бөө мөргөл болон өөр бусад шашнууд зэрэгцэн оршиж байгаа нь**

Эртний бөө мөргөлийн зан үйл нь өнөө хүртэл хадгалагдсаар ирсэн бөгөөд тус улсын нийт хүн амын 4 хувь нь бөө мөргөлтөн ажээ. Бөө мөргөлийн итгэл үнэмшил нь мөнх тэнгэрийг шүтэн дээд тэнгэртэй холбогдох юм. Бөө нь засал, жатга хийх ба онгодоо буулган эгэл ертөнцийг тэнгэртэй холбох зэргээр хүмүүст үйлчилдэг. Бурханы шашинтнууд болон лалын шашинтнууд нь бөө мөргөлийн зан үйлээс заримыг нь авсан бол эргээд энэ шашнуудаас бөө мөргөлийн зан үйлд ихээхэн нөлөө оржээ.

Монголын түүхэнд өөр өөр шашин оршиж байсан тухай баримт байдаг. Хэдийгээр Чингис хаан (1162-1227) бөө мөргөлтөн байж мөнх тэнгэрийг шүтдэг байсан боловч тэрээр өөр бусад шашнуудыг зэрэгцэн оршихыг хүлээн зөвшөөрсөн хамгийн анхны улсыг байгуулсан байдаг. XIII зууны эхэн үеэс Монголд шашин хоорондын уулзалт хийн шашин шүтлэгтэй холбоотой асуудлуудыг хэлэлцдэг байжээ. Тэр үед аливаа зүйлийг хийхээсээ өмнө бурханы шашны лам хувраг, христийн католик урсгалын номлогч, лалын шашны номлогч, Хятадаас гаралтай зүүний сургаал номлогчдоос зөвлөгөө авдаг байсан байна.

Өнөөдөр Монголд 100'000 гаруй лалын шашны сүннит урсгалыг дагагчид байдаг бөгөөд тэдний олонх нь баруун хязгаарт амьдардаг. Харин христийн шашны 120'000 орчим итгэгчид байдаг байна. Америкийн нэгдсэн улсаас гаргасан судалгаагаар Улаанбаатар хотын 1'000'000 орчим иргэнээс 30'000 орчим нь христэд итгэгчид байдаг гэжээ.

## **Монголын бурханы шашинтнууд юунд итгэдэг вэ**

Монголын бурханы шашин урт удаан түүхэн замналыг туулахдаа Монгол орны зан заншил, ёс уламжлалтай салшгүй сүлэлджээ. Бурханы шашин МЭӨ VI зууны үеэс эхтэй. Бурхан Будда болох Гуатама Сидхарта нь гэгээрэл буюу билиг билгүүн, агуу их энэрэн нигүүлсэхүйн дээд хутгийг олж, зовлонгийн шалтгааныг олсон сургаал номлолоо айлдаж эхэлсэн бөгөөд зовлон хийгээд түүний шалтгаанаас хэрхэн гэтлэх арга замыг хүн төрөлхтөнд номлох зорилго тавьжээ. Хожим бурханы шашин өөр олон оронд дэлгэрэхдээ тухайн орны соёлд нийцэн өөрчлөгдсөн байна. Буддын сургаалыг дэлгэрүүлэгчид Энэтхэгээс Төвд, Хятад, Солонгос, Япон, Төв Ази болон зүүн зүгт Шри Ланка зэрэг урд зүгийн орнуудад бурханы сургаалыг түгээсэн байна. Явцын дунд их, бага хөлгөний ёс бий болсон бөгөөд Монгол оронд их хөлгөний шашин дэлгэрсэн юм. Эл их, бага хоёр хөлгөний ёсны үндсэн ялгаа нь зовлонгоос гэтлэн нирваанд орох зам мөрийн үзэлд байдаг. Бага хөлгөний ёс нь Зүүн Азид дэлгэрсэн байх агаад энэ ёсны үзлээр хүн зөвхөн өөрийн тусын тулд нирваанд орно гэж үздэг. Харин их хөлгөний ёсоор хүн хамаг амьтны тусын тулд гэгээрлийн хутгийг олно гэж үздэг. Их хөлгөний ёс Энэтхэгээс зүүн болон хойд зүгт Хятад, Төвд, Солонгос, Вьетнам, Тайвань, Монгол зэрэг орнуудад дэлгэрчээ. Монголд дэлгэрсэн бурханы шашны их хөлгөний ёс нь бурханы шашны үндсэн уламжлалт чигийг барьдаг ч үүнд Төвдийн бурханы шашны нөлөө ихээхэн шингэсэн байдаг.

### **Хутагтын найман гишүүн**

Бурханы шашны үндсэн сургаалиар бол амьтан бүхэнд гэгээрэлд хүрэх чадамж бий гэж үздэг. Иймээс ч хамаг амьтныг хүндлэх тухай сургадаг. Түүнчлэн энэрэн нигүүлсэхүйн сургаал буюу хамаг амьтныг зовлонгоос гэтлээсэй хэмээн бусдыг энэрэн нигүүлсэх бодь сэтгэл хийгээд зовлонгийн шалтгааныг бодьгалсын өөрийнх нь урьд үйлдсэн муу үйлийн үр дагавар гэдгийг танин барих билиг оюун болно. Зовлонгоос гэтлэхийн аньсанд Хутагтын найман гишүүнийг өөрт дадуулдаг. Энэ нь зөв үзэл, зөв онол, зөв үг, зөв үйлсийн хязгаар, зөв тэжээл, зөв хичээл, зөв дурьдахуй, зөв самади болно. Хутагтын найман гишүүнийг лам хувраг, сүсэгтэн олон байгаль орчныг хамгаалах, шударга ёсыг хөхүүлэх, боловсролыг дэмжих зэрэг үйлст дадуулдаг билээ.

### **Бодьсадва**

Энэрэн нигүүлсэхүйн бодит жишээ бол Бодьсадва юм. Бодьсадва нь гэгээрлийн зэрэгт хүрсэн хэдий ч өөрт нь аврал одуулсан амьтан бүгдийг гэгээрэлд хөтлөхийн тулд өөрөө нирваанд оролгүй үлдэн дахин төрөл авч амьтны тусыг үйлдэгч бодьгал билээ. Монголчуудын шүтдэг бодьсадва нь Жанрайсиг юм. Бодьсадвагийн энэрэн нигүүлсэхүйн сургаал номлол нь нийт Монголын бурханы шашинтнуудын хувьд байгаль орчныг хамгаалах үндсэн цөм ухагдахуун нь болдог байна.

### **Монголын бурханы шашин**

Монгол оронд бурханы шашин дэлгэрэхдээ номлол, бүтээл, сүсэг бишрэлийн систем нь Монголын ахуй нөхцөлд зохицон дэлгэрсэн байдаг. Жишээлбэл: лам хүний өмсгөл болох дээлийг туйлын хүйтэн уур амьсгалд тохируулан дулаан, зузаан хийсний зэрэгцээ хурал уншлагын зан үйлээ Төвд лам нарын уншлага ая дангаас өөрөөр дэглэжээ. Гадны гийчдэд хамгийн түрүүнд ажиглагддаг онцгой зүйл бол цэнхэр хадаг. Ёслолын үед Төвдүүд цагаан, шар өнгийн хадаг хэрэглэдэг бол Монголчууд цэнхэр өнгийн хадаг хэрэглэдэг. Энэ нь мөнх тэнгэрийг шүтдэг бөө мөргөлийн эртний зан үйлтэй холбоотой бөгөөд яахын аргагүй Монголын бурханы шашны онцлог мөн билээ.

Түүнчлэн онгон дагшин уулс, гол ус ба тэдгээрийн эзэд болох лус савдагийн тухай зан үйлийг орхиогүйгээр үл барам харин ч өөрийн уламжлалдаа тохируулан авч хэрэглэсэн байна. Онгон дагшин газрыг бурханы шашны лус савдаг буюу уул, усны эзэд эрхшээдэг гэж үздэг сүсэг бишрэлийн систем нь байгаль орчныг хамгаалах ухамсарыг бий болгодог. Овоо болон чулуун хөшөө босгох нь бөө мөргөлийн зан үйл байсан боловч хожим аливаа баяр наадмын өмнө бурханы шашны зан үйлээр тахидаг болгожээ.

## **XX зуун**

XX зууны эхэн үед Монгол оронд 1'000 гаруй бурханы шашны сүм хийд байжээ. Өнөөгийн Улаанбаатар хотыг том гэсэн утгаар Их хүрээ хэмээн нэрийдэж байв. Их хүрээнд Төвд, Монголын бурханы шашинтнуудын оройн дээд Далай лам, Ванчин богд нарын удаа орох гэгээнтэн Богд хаан Жавзандамба хутагт суурин заларч байв. Манжийн дарангуйллыг түлхэн унагасны дараа 1921 онд Зөвлөлт холбоот улсаар дэмжүүлсэн коммунист засгийн газар байгуулагдаж бурханы шашин болоод бөө мөргөлийг хориглон хурал ном, зан үйлийг нь хааж олон арван мянган лам хувраг болон бөө нарыг егүүтгэсэн хэлмэгдүүлэлтийг эхэлжээ. 1937 оноос 1944 оны хооронд явуулсан хэлмэгдүүлэлтийн шуургаар бурханы шашныг бүрэн үгүй хийсэн байна. Зөвлөлт холбоот улсын Буриад зоныг ч хэлмэгдүүлэлтийн хар шуурга дайрсан гэдэг. 40'000 орчим лам нарыг баривчилан эрдэм номтой дээд лам нарыг егүүтгэн дунд лам нарыг 10 жилийн хугацаатайгаар шоронд хорьсон бол бага залуу лам нарыг хүчээр энгийн ард болгон үйлдвэрт ажиллуулах, цэрэгт дайчлах зэргээр номын мөрөөс холдуулсан байна. Энэ хугацаанд бүх сүм хийдүүдийг хааж, ихэнхийг нь бүрмөсөн устгасан байдаг. 1944 онд Гандантэгчэнлин хийд дахин сэргэсэн ч төрөөс тавих хатуу хяналтын дор хурал номын үйл ажиллагаагаа явуулж байв. Тэр үед бурханы шашны зан үйлийг төрийн бодлогоор хориглосны улмаас бурханы шашин ард түмний амьдралаас ихэд хөндийрсэн ажээ. Бурханы шашны судар номуудыг ихээр шатааж устгасан бол бас цөөнгүйг нууцаар хадгалан авч үлдэж чадсан байдаг. 1960 онд үндсэн хуулиар иргэний шашин шүтэх эрх, эрх чөлөөг тунхагласан боловч шашин номын үйл ажиллагааг төрөөс хязгаарласан байдлыг хэвээр үлдээсэн байна. 1970 онд Монголын бурханы шашны их сургууль байгуулагдаж бурханы шашныг системтэй гүнзгий судлах боломж нээгдсэн байдаг. Энэ сургуулийг төгссөн лам хуврагууд 1990 оноос эдүгээг хүртэл Монголд төдийгүй хөрш зэргэлдээ Буриадад бурханы шашныг дахин сэргээх үйлст манлайлан ажиллаж байна. Энэ хугацаанд 200 орчим сүм хийд дахин сэргээгдэж сүсэгтэн олны сэтгэл зүрхэнд орон зайгаа дахин эзэлжээ. Өнөөгийн байдлаар Монголчуудын олонх нь эцэг өвгөдөөс шүтэж ирсэн бурханы шашны зан үйл, хурал номын үйл ажиллагаанд оролцон амьдралын чухал мөчлөгүүдээ лам хуврагуудад айлтган даатгадаг хэвээрээ байна.

## **XXI зуун**

Өнөөдөр Монголын бурханы шашинд шинэ хандлага ажиглагдаж байна. Орчин үеийн хотжилт нь шинэ боломжуудыг бий болгодог хэдий ч бас олон сөрөг үр дагаварыг араасаа дагуулдаг. Рационалист үзэл нь хүмүүсийг шашныг зүгээр нэг мұхраар дагахын оронд судалж ухаарахыг зүгээр нэг хүндэтгэхийн оронд үнэн учир шалтгааныг нь олохыг эрмэлзүүлдэг болгожээ. Энгийн сүсэгтэн олны сэтгэлгээнд ихээхэн өөрчлөлт гарсан бол лам хуврагуудын сэтгэлгээнд ч өөрчлөлт гарсан байна. Ихэнх лам хуврагууд хот орон газар сууршихыг илүүд үзэх болсон тул хөдөө орон нутагт сүм хийд барьж байгуулах тал дээр хүндрэл гарах болов. Өөр нэг асуудал бол лам хуврагууд сүм хийддээ бус харин тус тусынхаа гэрт ар гэрийхэнтэйгээ амьдарч байгаа явдал юм. Энэхүү эгэл ертөнцийн үймээнт амьдрал нь тэдэнд өөр сонирхол болоод өөр хандлага төрүүлэх магадлалтай. Харилцаа холбоо хөгжсөнөөр лам хуврагуудад дэлхийн өөр бусад орны бурханы

шашинтнуудтай харилцаа тогтоох боломж бий болжээ. Мөн лам хуврагуудад гадаадад суралцах боломж нээгдэв. Эдүгээ олон залуу лам нар Энэтхэг улсад үйл ажиллагаагаа явуулж буй Төвдийн бурханы шашны чанга дэг жаягтай сүм хийдүүд, дацан сургуулиудад суралцаж байна. Гадаадад суралцагсад болон дотоодод суралцсан лам нарын хоорондын харилцаа холбоо цаашид ямар байдлаар явахыг цаг хугацаа харуулах бизээ.

Англи улсад төвтэй Төвдийн сан, Асрал ТББ, Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах төв (Төвдийн хувилгааны дүр болох Балбын их ламтны удирддаг) зэрэг Төвдийн бурханы шашны байгууллагууд өнөөгийн байдлаар Монголын бурханы шашныг дахин сэргэхэд дэмжлэг туслалцаа үзүүлж байна. Эдгээр байгууллагууд Монгол лам хуврагуудыг дотоодод болон Энэтхэг улсад суралцахад тэтгэлэг олгодог бөгөөд бурханы номыг энгийн сүсэгтэн олонд хүртээмжтэй болгох үүднээс бурханы шашны ном сургаалыг хэвлэн нийтлэж ном буяны үйл ажиллагаа явуулж байна.

### **Бурханы шашинд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь**

1990 оноос өмнө Монголд эмэгтэйчүүд сахил санваар хүртэх нь их ховор байжээ. Иймээс өнөөгийн эмэгтэй санваартнууд Монголын эмэгтэй хуврагуудын анхдагч үе нь болж байна. Эмэгтэй санваартнуудын сахил нь дотроо хоёр хуваагдана.

1. Гэцүлмаа. Энэ нь 36 сахил сахина.
2. Гэнэнмаа. Энэ нь үндсэн таван сахил болох амьтны амь таслах, эс өгснийг авах, худал өгүүлэх, буруу хурьцал үйлдэх, архи уух зэргийг цээрлэнэ. Энэ таван сахилыг эрэгтэй, эмэгтэй ялгаагүй авч сахиж болдог онцлогтой. Гэнэнмаа нь өдрийн цагт хурал номдоо хураад оройн цагт гэртээ харьдаг тул гэр бүлийн амьдрал үүсгэж болдог аж. Төрөх тохиолдолд хүүхдээ асрахаар хийд орноосоо жилийн чөлөө авдаг байна. Хувцаслалтын хувьд лам хувцас өмсөхөөсөө илүү улаан хүрэн өнгийн дээл өмсөнө. Зарим тохиолдолд шар дээл ч өмсдөг. Харин үсээ авахуулах шаардлагагүй.

Улаанбаатар хотод Н. Гантөмөрийн 1990 онд (тэрээр мөн онд санваар хүртсэн) үүсгэн байгуулсан Төгс Баясгалант хийд, Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Төвийн харьяа Дулмаалин хийд болон Нар Хажид зэрэг эмэгтэй санваартнуудын хийд байдаг. Төгс Баясгалант хийдэд 21 эмэгтэй санваартан суудаг ба ихэнх нь Өндөр гэгээний нэрэмжит бурханы шашны дээд сургуульд суралцдаг. Эдгээр эмэгтэй санваартнууд энэ дээд сургуулиас бурханы шашны чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгсөх анхны эмэгтэй оюутнууд болж байна. Эдгээр эмэгтэй санваартнуудын хийдүүд нь бусад сүм хийдүүдийн адил үйл ажиллагаагаа явуулдаг юм.

Дулмаалин хийд нь Монголын анхны дотуур байртай эмэгтэйчүүдийн хийд бөгөөд 2001 онд хуучин Дарь эхийн сүмийн туурин дээр нээгдсэн аж. 14 хуврагтай. Төвд хэл дээр бурханы шашны номыг судалдаг. Байгаль орчныг хамгаалах үйл ажилд оролцдог.

## **ХОЁРДУГААР ХЭСЭГ: БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААР БУРХАНЫ ШАШИНТНУУД ЮУ ГЭЖ СУРГАДАГ ВЭ**



*“Эх дэлхийтэйгээ эелдэг зөөлөн харьцвал эргээд чамд ч бас зөөлөн хандана.”  
Дээрхийн гэгээнтэн XIV Далай лам*

Монгол оронд бурханы шашин дэлгэрэхээс өмнө уул ус, сүрлэг байгалийг онгон дагшин хэмээн хүндэтгэн дээдэлж, тахин хамгаалдаг зан үйл байсан байна. Эдгээр онгон дагшин газар нутагт ан ав хийх, газар ухах, хөндөх зэрэг үйлүүдийг чандлан хориглодог байв. Төвд, Монголын бурханы шашинд энэхүү сүсэг бишрэлтэй холбоотой зан үйлүүд өнөөг хүртэл хадгалагдан иржээ. “Уул, усны сахиусыг хүндлэх, түүнээс эмээх, шүтэх нь байгаль орчныг хамгаалахад хүчирхэг арга болдог. Хүмүүний хувь заяа байгалийн хувь заяанаас ихээхэн хамааралтай гэдэгт Монголчууд итгэдэг.” гэж эрдэмтэн О. Сүхбаатар 2002 онд Дэлхийн Банкнаас ARC-тай хамтран гаргасан Монгол орны ариун дагшин газрууд хэмээх номондоо өгүүлжээ. Тэрээр цааш өгүүлэхдээ “Энэ номыг зөвхөн байгаль хамгаалахын тулд гаргаагүй билээ. Бодитойгоор сахиус оршсон олон газар байдаг гэдэгт хүн ард үнэнхүү итгэдэг болохоор гаргасан юм.” хэмээжээ.

Эдгээр байгаль хамгаалах ёс уламжлалууд бол өнгөрсөн ба өнөө цагийн Монголчуудад тохиосон хамгийн агуу бэлэг мөнөөс мөн.

Монголчуудын домог, мөргөлийн судруудад хүмүүс эрт цагт байгаль эхтэйгээ хэрхэн зүй зохистой харьцаж байсан тухай гардаг. Байгалийн элемент бүрийг нэгдмэл бүтцийн нэг хэсэг нь гэж үздэг байжээ. Иймээс хөх тэнгэрийг эцэг, хөрст дэлхийг эхээ хэмээн хүндэлдэг байсан байна. Байгалийн бүхий л цогцолборууд нь өөрийн гэсэн эзэн лус савдагтай бөгөөд тэдгээр лус савдагуудтай эвтэй оршихын тухайд тэдэнд зориулсан тусгай өргөл үйлдэн, заасан дэгийг хүндэтгэн үздэг байв. Үүнд газарт нүх ухах буюу хөндөх, гол усыг бохирдуулах, мод огтлох, ургамлын үндэс сүйтгэх, амьтны үүр эвдэх ба шалтгаангүйгээр амьтны амь таслахыг ихэд цээрлэх зэрэг байгаль экологид ээлтэй зүйлүүд багтана. Хэрэв аливаа хүн тухайн цээрүүдийг зөрчих аваас өөрт нь болон өөрийн өрх гэр түүнчлэн тухайн нутаг хошуунд цөвүүн үзэгдэл тохионо хэмээн үздэг байв. Эдгээр олон зан үйл нь бурханы шашинтай хамт уламжлагдан ирсэн бөгөөд бурханы шашны ёсоор дээрх газар орны эздүүдийг лус савдаг хэмээдэг.

“Урьдын лам нар, одоогийнх ч мөн адил, шавьж амьтадыг гишгэчих вий хэмээн ихэд болгоомжтой алхдаг байсан гэдэг. Агаарын орон зайд тоо томшгүй олон амьтан төрлөө олж амжаагүй оршиж байх тул хэн хүн гараа хүчтэй даялахад л тэдгээр олон амьтан үүнд өртөн амиа алддаг.” гэж Дашчойлин хийдийн лам Н. Батсайхан хэлсэн байна.


Буддизм нь Монгол орны экологид ээлтэй шашин байснаар үл барам өөрийн гэсэн шинж чанартай болсон байна. Лам хуврагууд уламжлал ёсоор онгон зэрлэг байгалийг хайрлах, хамгаалах ухаанд суралцаж, улмаар сурсан зүйлээ үйл хэрэг болгож байсан байдаг. Хэдийгээр байгаль хамгаалах асуудлыг өдөр тутмын хурал номын үйл шигээ эрчимтэй авч үзэж байгаагүй ч тодорхой хэмжээгээр анхааран дадуулга хийж байжээ. Их хөлгөний ёсоор хамаг амьтныг хүндэтгэхээс гадна тэдгээрийн амьдрах орчныг мөн хүндэтгэн үзэх учиртай. Бурханы шашны дахин төрөл авах тухай номлолд: Хүн ямар ч амьтны төрлийг авч болох тул мод, усанд орших шавьжны төрөлд ч төрж болох юм. Иймээс бид тэдгээр амьд элементүүдийг бохирдуулах зэрэг хорлол үйлдэх ёсгүй. “Бид энэ насны төрлийг авахаас өмнө дээр дурьдсан төрлүүдэд төрж эдэлсэн зовлонг нь мөн адил эдэлж байсан байх магадлалтай. Иймд тэдгээр амьтанд хор учруулбал эргээд бид дараа төрөлдөө тухайн төрөлд нь төрөн өөрийн үйлдсэн зовлонгоо эдлэх аюултай.” гэж Н. Батсайхан өгүүлсэн юм. Хэрэв тэргүүлэшгүй олон цагт тоолшгүй олон төрөл авч явахад минь энэ олон амьтад магадтай бидний эх болж явсан хэмээн бодвоос аливаа амьтныг хорлох сэтгэл бидэнд төдийлөн төрөхгүй болов уу. Ертөнц нэг хүмхийн тоосноос ч бүтдэг болохоор тоосыг ч гэсэн хүндэтгэх учиртай. Иймээс бурханы шашинтнуудын үйл, бүтээл нь амьдралд ойрхон байдаг билээ.

Хөдөө нутагт мах, сүү, цагаан идээ үндсэн хоолны бүтээгдэхүүн тул сүм хийдийн хүнсний хэрэглээнд элбэг хэрэглэгддэг ажээ.

Монголын бурханы шашин нь нүдэнд үзэгдэх хийгээд үл үзэгдэх ертөнцийн олон элемент хоорондоо харилцан шүтэлцээтэй оршдог гэж онцлон номлодог. Гандантэгчэнлин хийдийн Да лам Бямбажав хэлэхдээ “Бурханы шашны гүн ухаан нь сав, шим ертөнц болоод тэдгээрийн шүтэлцээг тодорхой гаргаж өгсөн байдаг” гэв. Сав ертөнц хийгээд хүмүүсийн үйл ажиллагааны хооронд нарийн уялдаа бий. Сэтгэлийн ариусал нь гадаад ертөнцийн ариусалтай мөн л нарийн уялдаа холбоотой. Сав ертөнц дэх байгаль орчны болон өөр бусад ээдрээтэй асуудлууд нь дотоод ертөнцийн бүртгээс үүдэлтэй. Хүний шунал хүсэлд хязгаар үгүй бол харин байгалийн баялаг хязгаарлагдмал юм. Бурханы шашин чухам энэ хоёрын хоорондын зохилдолгоог нарийн тайлбарладаг. Мөн хүний шунал хүслийг хязгаарлах тухай сургадаг. Сургаал номлолд нь нялх зулзаган амьтны эхийг хөнөөх ба залуу модыг огтлох зэргийг хатуу цээрлэсэн байдаг. Үүгээрээ байгаль орчны талаасаа амьдралд ойрхон сургаалтай бөгөөд үйлийн үрийн логик сургаалаараа хүний үйлдсэн буруу үйл байгаль орчинд ямар их сөрөг нөлөө үзүүлдэг тухай тайлбарладаг юм. Жишээлбэл: бурханы шашны Асрал ТББ байгууллагын тэргүүн Ванчин Одбрүл Ринбүчэгийн үзлээр бол нийтээр үйлдсэн сайн, мүү үйл нь сайхан, мүүхэй цаг агаарыг ч нөхцөлдүүлдэх шалтгаан болдог аж. Тэрээр өгүүлэхдээ “Шунал хүсэл хийгээд өөр бусад нисваансын хорт сэтгэл нь эцэстээ зовлон зүдгүүрийг л бий болгох тул хүн аливаа үйлийг хийхдээ түүнийг байгаль орчинд хортой болохыг мэдэж эс чадвал эргээд олон янзын зовлон зүдгүүрт унадаг. Тэрчлэн хүмүүст эргээд экологийн гай гамшиг нүүрлэдэг учир бодолтой байх хэрэгтэй.” гэж айлдсан байна<sup>2</sup>.

---

<sup>2</sup> Байгаль, Экологи, Хөгжил сэдэвт хойд бүсийн бурханы шашинтнуудын бага хурал (хх 64-8), Мартин Палмер (хх 81-2)



### **Онгон дагшин газар**

Газар нутагт бурхад, сахиус оршсон ба эсвэл тэдгээр уул ус нь өөрөө бурхад, сахиусны дүр төрхийг хадгалсан онгон дагшин уул ус, байгалийн цогцолборууд байдаг бөгөөд эдгээр онгон дагшин газруудыг түүхийн явцад ихэд хүндлэн цээрлэх цээр гарган хамгаалсаар иржээ. Жишээлбэл: тухайн онгон дагшин газар нутагт мод огтлох болоод ан ав хийхийг хориглоно. Зарим онгон дагшин газарт тухайн уулын шинж төрхийг өөрийн биедээ хадгалсан лус савдаг ч оршдог аж. Ар хормойг Улаанбаатар хот дэрлэн орших шувууны шинж төрхтэй Богд Хаан уулын савдагийг гарьд шувууны дүртэй гэх бөгөөд баруун талд нь орших уулын савдагийг хөх царайтай хөгшин хүний дүр төрхтэй гэдэг. Зарим лус савдаг нь тухайн онгон дагшин газрын цээрийг эвдсэн хүнийг шийтгэдэг хилэнтэй догшин дүртэй байхад зарим нь байгалийн гамшгаас хүн зоньг хамгаалах буяны сэтгэлтэй байх ба үүнийхээ хариуд хүнээс талархал горилдог ч бас байдаг ажээ. Мөн эм савдаг гэж бий.



### **Шувууд ба амьтад**

Уулыг амьтадын нэрээр нэрлэдэг ёс нь экологийн хувьд ихээхэн ач холбогдолтой байдаг байна. Тухайлсан амьтны нэрээр нэрлэсэн тэр газарт уг амьтныг агнах ба хавх тавихыг цээрлэдэг. Харин өнөөдөр эдгээр зан үйл бараг мартагдсан байна. Лам хуврагуудтай хамтран орон нутгийн хүмүүсийн энэхүү эртний уламжлалт сүсэг бишрэлийн системийг дахин сэргээвэл ихээхэн үр дүнтэй болох билээ. Зарим төрлийн ан амьтадыг тусгайлан дархалсан байдаг. Чоно, буга зэрэг амьтад нь тодорхой жишээнүүд болно. Монголчууд могой, загас зэрэг амьтадыг лусын амьтан хэмээн үздэг. Түүнчлэн гөрөөс, аргал, янгир, нүүдлийн шувууд болон бусад ховор амьтадыг агнах, хор учруулах, хавхаар барихыг нүгэл хэмээн ихэд цээрлэдэг байжээ. Мөн шувууны үүрийг сүйтгэх нь бүү хэл өндгөнд нь ч сүүдрээ тусгахыг хүртэл цээрлэдэг эртний ёс байх бөгөөд энэ цээрийг эвдэх аваас тэнгэр хилэгнэдэг хэмээн үздэг байв. Хэдийгээр энэ олон уламжлалыг байгаагаар нь хадгалан үлдэж чадаагүй ч гэлээ тэрхүү сүсэг бишрэлийн улбаагаар Монгол орон нь олон улсын хэмжээнд мөхөх аюултай байгаа шувуудад харьцангуй ээлтэй орнуудын тоонд ордог байна<sup>3</sup>.

<sup>3</sup> Сүхбаатар (х 27-30)



### **Овоо тахих ёс**

Хэдийгээр та Монгол хүн биш байлаа ч онгон дагшин тахилгат уулсыг байгалийн сүрлэг өндөр тогтоц, тунгалаг гол горхи, онгон дүр төрхөөр нь амархан ялган таниж болно. Ийм газруудыг олон зуун дамжин тахин шүтэж ирсэн байдаг. Эдгээр газруудын өндөрлөг хэсэгт чулуун овоо заавал босгоотой байдаг. Нэг талаасаа овоо нь тухайн газрыг онгон дагшин болохыг илэрхийлдэг бөгөөд тахилгат уул, толгодын орой, гол ус, нуурын хажууд олонтаа тааралдана. Хүмүүс овооны хажуугаар өнгөрөхдөө нар зөв гурван удаа тойрч “Овооны их нь таньд, олзны их нь маньд” хэмээн шившдэг. Тэгээд аян замдаа учрах саадыг арилгахын тулд овоонд боломжоороо өргөл өргөх тул тухайн газрын лус савдаг түүнд нь талархан аян замыг нь саадгүй, ажил үйлсийг амжилттай бүтэхэд нь туслаж ая таатай цаг агаараар ивээн, ад мөрийн хорлолоос хамгаалдаг гэдэг. Нөгөө талаасаа овоо нь газар нутгийн дээс буюу таних тэмдэг болдог тул их ач холбогдолтой зүйл билээ. Овоо тахих ёс Монголчуудын хувьд түгээмэл ёс уламжлал тул лам хуврагууд, энгийн сүсэгтнүүд зан үйлийг нь сайтар мэддэг. Овоо тахих ёс нь шашин номынхоо хувьд ч тэр байгаль орчныг хамгаалах талаасаа ч тэр сүм хийдүүдийн хувьд хурал номынх нь үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болдог. Жишээлбэл: байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог Гандантэгчэнлин, Дашчойлин хийдүүд Отгон Тэнгэр Хайрхан, Бурхан Халдун уул, Алтан Хөхий, Богд Хаан уулын Цэцээ гүний оргил, Алтан овоо зэрэг төрийн тахилгат их таван уулсын тахилгын ёсыг үйлддэг байна.

Н. Батсайханы хэлснээр эдгээр төрийн тахилгат таван уулсыг тахих нь хамгийн чухал үйл явдал бөгөөд уламжлал ёсоор ард олон энэ ёслолд оролцдог ба улсын ерөнхийлөгч болон ерөнхий сайд зэрэг төрийн өндөр албаныхан ч оролцдог уламжлалтай ажээ.

## **Уул овооны тахилгын судар**

Уул овооны тахилгын судрууд бол Монголын бурханы шашны бас нэгээхэн чухал хэсэг бөгөөд байгаль орчны чиглэлээр бурханы шашны байгууллагатай хамтран ажиллахыг хүсэгч хэн хүнд чухал анхаарууштай сэдэв мөн билээ. XIII зуунд бурханы шашин Монголын төрийн шашнаар өргөмжлөгдсөний дараа Монголын мэргэд бурханы шашнаас өмнө Монгол оронд оршиж байсан зарим ёс уламжлалуудыг бурханы шашны зарим уламжлалуудтай нэгтгэн, онгон дагшин газруудыг тахилгат болгох шинэ ёсыг тогтоон 600 гаруй уулыг тахилгатай болгосон бөгөөд 280 гаруйг нь тухайлсан тахилгын судартай болгосон байна. Тахилгын судар бүр нь тухайн тахилгат уулын талаарх мэдээллийг агуулж байсан гэдэг. Харин коммунист хэлмэгдүүлэлтийн үед ихэнх судрууд нь устаж үгүй болжээ. Олон зууны турш тэдгээр тахилгын судрууд Монгол орныг экологийн сүйрлээс хамгаалж, уншлага урилгаараа лус савдагийг баясган, өлзий буяныг тогтоож, байгаль орчинд хортой муу үйлийг ариусган, бурхад болоод сахиусыг урин залж, ад мөрийн хорлол, ган зудны аюул зэрэг барцад саадыг амирлуулах ба ховор амьтад болох цасны ирвэс зэрэг зэрлэг амьтадын тоо толгойг өсгөх зэргээр шашны цээр тогтоож, тухайн цээрийг уландаа гишгэсэн гэмтэнд тохирсон шийтгэлийг оноох зэргээр байгаль экологийг онгон байдлаар нь хадгалахад үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн байдаг<sup>4</sup>. Жишээлбэл: нэгэн сударт хүмүүс уулнаас мод огтолсонд лус савдаг нь хилэгнэн тэдний сууринг үерт автуулж байгаа тухай гардаг.

“Монголчуудын хувьд уул хангайг шүтэн дээдлэх нь уламжлалт байгаль хамгаалах ёсны хамгийн нийтлэг арга билээ. Уул хангайн тахилгын судар бол дан ганц шашны ном, зан үйлийн тухайтад бичигдсэн бус харин ч Монголын соёлоос урган гарсан агуу их мэргэн ухааны сан мөн.”<sup>5</sup>

## **Цагаан өвгөн ба Урт наст зургаа**

Цагаан Өвгөнийг урт насны билэгдэл болох тоорын мод, дун хэлбэрт хад, тогоруу, болор эрх, уулнаас урсах рашаан болон бодь гөрөөсийн хамтаар бүтээдэг. Эдгээрийг төрөлхтөн хийгээд элдэв чуулганы дотроос үхэшгүй мөнхийн үрийг олсон зургаан төрөл зүйл хэмээн үздэг. Төвд хэлээр Цагаан өвгөнийг урт насны бодьсадва Амитаюуш гэж нэрлэдэг бол Хятад хэлэнд Шоу-Лао гэж дууддаг. Харин Монголчууд Цагаан өвгөн хэмээн нэрийддэг билээ. Хэдийгээр орон оронд өөр өөр нэрээр нэрлэгддэг хэдий ч тэрээр байгаль орчинтой зохилдлоготой сайхан амьдрахын тод томруун жишээ юм. Зохилдлогот сайхан орчинд амьдрахгүй аваас урт насны хэрэг юу билээ. 2008 онд Гандантэгчэнлин хийдээс төв болон хойд Азид ихээхэн түгээмэл энэхүү зургийг хүмүүс байгаль орчныг хамгаалах үйлст нэгдвэл өөрсдөд нь ямар их нөөц бололцоо буйг санан дурьдуулах үүднээс бурханч Дөлгөөнөөр бүтээлгэсэн юм. Энэ зургийн төв хэсэгт Цагаан өвгөн байх бөгөөд түүний эргэн тойронд гөрөөс, рашаан ус болон бусад урт насны билэгдлүүд бүтээгджээ. Мөн тэдгээрийн эргэн тойронд лам хуврагууд болон сүсэгтэн олон байгаль орчноо

---

<sup>4</sup> Жишээ нь: Өндөр Гэгээн Занабазарын хүсэлтээр IV Ванчэн Богд хур борооны судрыг Монгол орныг элдэв барцад, өвчин зовлонгоос хамгаалахын тухайтад лам, бурхан сахиус болон лус савдагт өргөл өргөж буй утгатайгаар зохиосон байдаг.

<sup>5</sup> О. Сүхбаатар (хх 24-5)



хэвээр нь хадгалах, хамгаалах үйлсийг хийж байгаа дүр зургуудыг зохиомжлон оруулсан байна. Жишээлбэл гол усанд дүлцэнгийн шороо өргөх, уул овоо тахих, мод огтолсоны гэмээ наминчилан лам хуврагуудаар ном уншуулж лус аргадах болон мал сэтэрлэх зэрэг үйл явдлуудыг дүрсэлсэн байна.

Урт наст зургаа нь<sup>6</sup>:

1. Өнө мөнхийн амьдралыг тэтгэгч эрдэнийн жимс (Үүгээр байгаль дэлхийн баялагийг илэрхийлсэн байна.)
2. Үхэшгүй мөнх ногооны билэгдэл тоорын мод (Дан ганц урт насны билэгдэл төдийгүй ургамлын аймгийн ач холбогдлыг харуулсан.)

<sup>6</sup> Байгаль, Экологи, Хөгжил сэдэвт хойд бүсийн бурханы шашинтнуудын бага хурал (хх 59-64, х72)

3. Дун хэлбэрт хаднаас ундрах урт насыг тэтгэж, элдэв өвчнийг амирлуулагч цэвэр тунгалаг, сэрүүн, сайхан үнэрт, тайвшруулагч, анагаагч, амтат, хөнгөн, зөөлөн зэрэг найман эрдэнийн чанар бүрдсэн рашаан ус (Энэ нь зөвхөн цэвэр ус, ундны хэрэглээ гэсэн утгаар бус харин эх дэлхийн хамаг амьтныг тэтгэдэг гэсэн утгаар оржээ.)

4. Бат бөхийн билэгдэл дун хэлбэрт хад (Монголчууд болон Төвдүүд уул овоог энэ дун хадаар төлөөлүүлэн хүндэтгэн шүтдэг. Энэ нь байгалийн сүр хүчийг илэрхийлэхийн зэрэгцээ хүмүүн биднийг асар том агуу зүйлийн өчүүхэн нэг хэсэг л болохыг харуулжээ.)

5. Хамгийн урт насладаг шувуу болох тогоруу

6. Цэвэр ариун явдлын билэгдэл бодь гөрөөс (Гөрөөс нь ариун явдалт амьтан бөгөөд шөнө бүр өөр өөр газарт хоноглодог аж.) Энэ зурагт бодь гөрөөс тогоруу хоёр нь хүмүүн бидэнд сав шим ертөнцийн зохилдлогоог хангах үүднээс амьтныг хайрлах, хүндлэх хэрэгтэйг харуулжээ. Хэрэв хүмүүс бид бусад амьтныг хөнөөж хорлолгүйгээр өөрсдийн дураар амьдрах орчныг нь бүрдүүлэх аваас тэд сая л өөрсдийн зөнгөөр тайван амьдрах билээ.

“Урт наст зургаа нь сав ертөнцөд оршиж байгаа бүх л амьд амьтадыг хайрлан энэрэх ухааныг илэрхийлж байгаа юм.” хэмээн Гандантэгчэнлин хийдийн тэргүүн их хамба лам Д. Чойжамц гуай өгүүлсэн бол “Энэ зурагт зохиомжлон үзүүлсэн үйлүүд нь байгаль орчин ба газар дэлхийгээ хамгаалах нь нэн чухал болохыг санан дурьдуулж байна.” хэмээн Да лам Бямбажав хэлсэн юм.

### **Байгаль орчныг хамгаалах уламжлалт хуулиас**

Эрт болоод эдүгээг хүртэл байгаль орчныг хамгаалах дүрэм, журмыг бурханы шашны сургаал, домогт оруулжээ. 1240 оны үед бичигдсэн (Чингис хааны түүх) Монголын нууц товчоонд амьтад болоод зэрлэг амьтадыг хамгаалах журмын тухай өгүүлсэн байдаг байна. XVIII зууны үед уул усыг албан ёсоор дархалсан хууль журам гарч байв. Мөн газар дэлхий, гол усыг бохирдуулах болон ан амьтныг үржлийнх нь үеэр агнахыг хууль журмаар хориглож байжээ. Бурханы шашны домог, сургаал номлолоос байгаль орчныг хамгаалах хууль журамд хэр их зүйлийг ишлэл болгон оруулсан нь тодорхойгүй байдаг. Ямартаа ч Монголчууд төр, шашны тэдгээр хууль журмыг чин сэтгэлээсээ хүндэтгэн дагаж ирсэн байна<sup>7</sup>.

Өнгөрсөн хугацаанд Монголын онгон дагшин газар нутгуудыг хамгаалах чиглэлээр ихээхэн ажил хийгдэж байна. 1996 онд Соёлын ямнаас 16 их уулс болон олон тооны бага уулсаас 3-ыг нь UNESCO-гийн дэлхийн өвийн жагсаалтанд оруулжээ<sup>8</sup>. Энэ жагсаалтанд дэлхийн хамгийн анхны албан ёсны дархан цаазат уул болох Богд Хаан уул багтдаг байна. Энэ уулыг 1778 онд Манжийн хааны зарлигаар анх дархалсан байдаг. Ар хормойг нь Улаанбаатар хот дэрлэн оршдог энэ уулнаас 3'000 жилийн өмнөх хадны сүг зураг болон бусад археологийн ховор олдвор олдож байжээ. Эл дархан цаазат уулын энгэрт 1750 онд байгуулагдсан Манзуширийн хийдийг дахин барих ажлыг лам хуврагууд эхлүүлээд байна.

---

<sup>7</sup> <http://whc.unesco.org/en/tentativelists/936/>

<sup>8</sup> Байгаль, Экологи, Хөгжил сэдэвт хойд бүсийн бурханы шашинтнуудын бага хурал (xx 51-3)

Оросын хилтэй залгаа Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт 1.2 сая га газрыг эзлэн орших Чингис хаантай холбоотой Бурхан Халдун уулын дархан цаазат бүс нь уг жагсаалтанд багтдаг бөгөөд Монгол орны нутгийн төв хэсэгт 95'500 га газрыг эзлэн орших Отгон Тэнгэр уул нь энэ жагсаалтанд орсон 3 дах уул юм. Отгон Тэнгэр уулыг анх Халх журамд дархалж эл газрыг хөндөх ба орчин тойронд нь ан ав хийхийг засаглан хориглосон байна.

### **Бурханы шашинтнууд ба хөгжил**

Уламжлал ёсоор орон байр барих, суурших газар сонгох, сүм хийд барих, нас барагсдыг нутаглуулах газар сонгох, нүүдэллэн бүүх газар зэргийг сайтар шинждэг байжээ. Ус, түлшний нөөц зэрэг ойр зуурын хэрэгцээгээ харахын сацуу Төвд, Монгол судраар тухайн газар нутгийн зохилдлогыг нь шинжиж таарах, таарахгүйг нь тодорхойлдог байв. Шинжээний сударт уг газарт бүүж болох ба болохгүй хийгээд хөрс, ой мод, ургамлын чанар бүгд гардаг байжээ. Өнөөдөр олборлолтын төсөл хэрэгжүүлж байгаа олон компани байгаа боловч шашин номын ёсыг хайхралгүй газраа сонгон үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээр компаниудын 80 хувь нь сүм хийдээс тухайн өдрийн барилдлагын үрийг асуудаггүй ба шинэ төсөл эхлэхдээ хурал номд даатгадаггүй аж.<sup>9</sup> Дашчойлин хийдийн лам Н.Батсайхан хэлэхдээ саяхнаас сүм хийдэд хандах компаниудын тоо нэмэгдэж байгаа бөгөөд үүний цаад шалтгаан нь ашиг орлого нь буурч, ойр орчмын хүн, амьтан бохирдлоос болж хүнд хэцүү нөхцөлд орсонтой холбоотой аж. Лус савдагийг хилэгнүүлбэл өлзий бус үзэгдлүүд тохиох тул тухайн газрын лус савдагийг аргадан өргөл өргөх хэрэгтэй гэж үздэг.

Бурханы шашны үзлээр бол газар дэлхийг хөндөх, ялангуяа олборлолтын үйл эрхлэх нь нүгэлд тооцогддог. Гэвч олборлолтын дараа тухайн газарт нөхөн сэргээлт хийх нь юу юунаас илүү чухал зүйл бөгөөд энэ нь олборлолтын компаниудын зайлшгүй хариуцлага мөн. Ашигт малтмалын компаниуд олборлолт хийснийхээ дараа тухайн газрыг дахин сэргээж уул усанд нь өргөл өргөн ойролцоох уул овоог аргадан тахиж хэрэгтэй гэж Н. Батсайхан өгүүлсэн юм.

Товчхондоо аливаа газар шорооны ажил гүйцэтгэхдээ зөвхөн байгаль орчинд нөлөөлөх үр дагаварыг нь тооцох нь чухал биш харин эртний уламжлалаа даган тахилгат онгон дагшин газар нутгийн овоо болоод түүний орчин тойрныг нь сүйтгэхээс сэргэмжлэн зайлсхийх нь чухал.

Газар шорооны ажил хийхдээ сүм хийдэд хандан болзошгүй аюулыг зайлуулах хурал ном хуруулбал өлзийтэй. Бурханы шашны үзлээр бүх зүйлс хоорондоо харилцан уялдаатай тул сайн компаний үйл ажиллагаа ашиг орлого болон сайныг дагуулахад харин муу компаний үйл ажиллагаа зовлон зүдгүүр дагуулдаг байна. Үйлийн үрийн сургаалаар бол байгаль орчин хийгээд амьд ертөнцөд учруулах хор хөнөөлөө багасгах нь тухайн компаний зайлшгүй хариуцах ёстой үүрэг мөн юм.

---

<sup>9</sup> Д.Мөнхсайхан. (pp 44-8); Байгаль, Экологи, Хөгжил сэдэвт хойд бүсийн бурханы шашинтнуудын бага хурал (pp 55-8)

## ГУРАВДУГААР ХЭСЭГ: СҮҮЛИЙН ЖИЛУУДЭД БУРХАНЫ ШАШИНТНУУД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРХЭН АЖИЛЛАСАН НЬ



### Боломж

Хуучны коммунист нийгэмтэй харьцуулбал өнөөдөр сүм хийд, лам хуврагуудад байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах бүрэн бололцоо бий. Сүм хийдүүд анхлан зайлшгүй бүтээн байгуулалт, боловсон хүчнээ сайжруулах асуудлуудыг голлон анхаарч байв. Өнгөрсөн 20 гаран жил дан ганц энэ салбарт ажиллаж ирсэн байна. Харин одоо байгаль орчин, нийгмийн сайн сайхны салбарт хүч тавин ажиллавал өнөө хийгээд ирээдүйд их хэрэгтэй билээ. “Коммунистууд 70 гаран жил ноёрхихдоо Монголын бурханы шашныг үндсэнд нь мөхөөсөн. Өнөөгийн байдлаар лам хуврагууд бид устгагдсан сүм хийдүүдийг дахин босгохоор ажиллаж байна. Гандантэгчэнлин хийдээс сэргээн босголт, хүний нөөц хоёрыг голлон анхаарч байлаа. Бид одоо шинэ зорилготой боллоо. Энэ бол байгаль орчин болон нийгэм рүү чиглэсэн ажиллагаанууд юм. Ирээдүйд бид энэ салбаруудад түлхүү ажиллах болно.” хэмээн Гандантэгчэнлин хийдийн Да лам Бямбажав хэлсэн. 1999 онд Дэлхийн Банк, Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-аас Монголын Бурханы Шашинтны Төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран коммунист хэлмэгдүүлэлтийн үед нууцаар хадгалан авч үлдсэн хуучны уул овооны тахилгын судруудыг орчин цагийн Монгол хэл рүү хөрвүүлэх төсөл хэрэгжүүлсэн юм. Тухайн судар номнууд нь Төвд хэл дээр бичигдсэн тул энгийн хүмүүст төдийлэн хүрдэггүй байв. Төслийн үр дүнд Монголын байгаль хамгаалах ёс уламжлал, тахилгат уул усны тухай мэдээллээс алслагдсан суурин газрын хүмүүс болон лам хуврагуудад мартагдсан ёс уламжлалыг эргүүлэн авчирсан билээ. Энэ төслийн хүрээнд усны эх сурвалж болсон ойн бүсийн биологийн олон төрөл чухал газруудыг сурвалжлан тогтоосон юм. 1999 оноос хойш Улаанбаатар хотын орчимд зургаан газарт чулуун хөшөө босгож орон нутгийн хүмүүст тэдгээр газруудыг тахилгатай болохыг таниулсан.

WWF-ийн харилцааны асуудлыг хариуцан ажиллаж байгаад эдүгээ Катманду хотод “Уулсын Хөгжил” олон улсын байгууллагад ажиллаж буй Элбэгзаяа “Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулбал өөрсдөд нь ямар их бололцоо байгааг эхэндээ лам хуврагууд төдийлэн сайн анзаардаггүй байлаа.” Хэдийгээр уламжлалт байгаль хамгаалах зан үйлүүдийг мэддэг байсан ч үүнийгээ зөвхөн шашны зан үйлтэй холбоотой зүйл гэж төсөөлдөг байжээ. Жишээлбэл: шашингүй

нийгмийн үед хүн ард овоо хүндэтгэх, ойр орчимд нь урьдын сахиж байсан цээрийг мөрдөх зэргээр байгаль экологит ээлтэй зан үйлүүдийг хадгалсаар байсан. Бидний энэ ажил тэдэнд урьд цагт лам хуврагууд байгаль хамгаалах чиглэлээр ажиллаж байсныг санан дурьдуулах зүйл болсон юм. “WWF ARC хоёр анхлан лам хуврагуудтай ажиллалаа. Ингэж ажиллаж болдогыг бид харлаа.” гэж тэрээр нэмж өгүүлсэн юм. Эдгээр төслүүдийн талаар дэд бүлэгт дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Хамтран ажилласны бас өөр нэг хэлбэр бол зурхайн ёсны цаг тооны бичгийг гаргасан явдал юм. Энэ цаг тооны бичигт лусын буулттай өдрүүдийг тусгайлан тэмдэглэсэн бөгөөд эл өдрүүдэд ан агнах, газар шороо ухааж хөндөх зэрэг үйлүүд нь эргээд байгалийн гамшиг тохиох шалтгаан болдог тухай тайлбарласан байдаг. Хэлмэгдүүлэлтийн хар шуурганд энэхүү уламжлалт ухаан гээгдсэн тул ард олны хүсэлтийг харгалзан үзэж Гандантэгчэнлин хийдийн лам нараас Дэлхийн Банктай хамтран уг өвөрмөц цаг тооны бичгийг бүтээсэн билээ. Төвд, Монголын цаг тооны бичигт лусын буулттай өдрүүд нь зөрүүтэй тохиодог. Хүмүүс аливаа үйлийг эхлэхдээ лусын буулттай өдрүүдийг анхааран ажигладаг. Тухайлсан өдөр болон дүйчэн өдрүүдэд мод огтлох, ан ав хийхийг цээрлэсэн байдаг нь байгаль экологид эерэг нөлөөтэй байдаг.<sup>10</sup>

Гандантэгчэнлин хийдээс байгаль хамгаалах асуудалд анхаарал тавьж эхэлснээр Эрдэнэзуу хийд бас байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцох болсон юм. Тухайлбал зэргэлдээх уулын ой модыг сүйдэхээс хамгаалан хөтөлбөр хэрэгжүүлэн орон нутгийн хүүхдүүдийг амьдрах ухаанд сургах, ядуу өрх айлуудыг модноос өөр амьжиргааны хэлбэрийг сонгоход нь дэмжлэг үзүүлэх, бясалгалын ногоон цэцэрлэг барих зэргээр байгаль хамгаалах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Дэд бүлгээс үзнэ үү.

Түүнчлэн Дорноговь аймгийн Хамарын хийдийн моджуулах төсөл, Багануур дүүргийн Онцар Ешэи Лин хийдээс уурхайчдад зориулсан байгаль орчныг хамгаалах сургалт ба ашигт малтмалын сөрөг нөлөөг баримтжуулах төсөл зэрэг ажлууд хийгдсэн билээ. Мөн Сэлэнгэ аймгийн Амарбаясгалант хийд болон идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа Баянхонгор аймгийн Лувсанданзанжанцан Судлалын Төв зэргийг дурьдаж болно.

### **Үндсэн хурлууд**

Байгаль хамгаалах чиглэлээр Монголын бурханы шашинтнуудын оролцсон гол уулзалт нь 2005 онд Гандантэгчэнлин хийд болон Чингис Хаан зочид буудалд зохиогдсон Байгаль экологи, хөгжил сэдэвт хойд бүсийн бурханы шашинтнуудын бага хурал юм. Энэ хурал нь анх удаа зохион байгуулагдснаараа онцлог бөгөөд нийт 250 лам хувраг, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл хуран цуглаж дөрвөн өдрийн түрш байгаль орчин, хөгжлийн салбарт өөрсдийн санал бодлоо илэрхийлжээсэн юм. Энэ хуралд Монгол, Орос, Хятад, Солонгос, Камбожийн бурханы шашны тэргүүлэгчид, Дэлхийн Банк, Нидерландын засгийн газар, WWF, ARC зэрэг олон улсын байгууллагууд оролцсон билээ. Эдгээр

---

<sup>10</sup> [http://www.arcworld.org/downloads/UB\\_conference.pdf](http://www.arcworld.org/downloads/UB_conference.pdf)

байгууллагуудын талаарх мэдээллийг дэд бүлгээс үзнэ үү.

Энэ бага хурлыг ARC-аас санаачлан Монгол улсын ерөнхийлөгч бөгөөд ARC-ийн олон улсын ерөнхийлөгч Н. Энхбаяр зохион байгуулсан бол Дэлхийн Банк, Нидерландын засгийн газраас голлон санхүүжүүлсэн юм. ARC-ийн цахим хуудаснаас уг бага хурлын талаарх мэдээллийг үзэж болно. [www.buddhistecology.org](http://www.buddhistecology.org)<sup>11</sup>

2008 онд дараагийн уулзалтыг Гандантэгчэнлин хийд ТТФ-тай хамтран зохион байгуулсан. ТТФ нь Хөвсгөл аймагт мөхөх аюулд ороод байгаа тул загас хамгаалах ажлыг 2004 оноос өнөөг хүртэл явуулж байгаа байгууллага юм. Энэ хуралд Монголын 21 аймгийн төлөөлөл болсон 50 орчим лам хуврагууд оролцож, байгаль орчныг хамгаалах талаар хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн ажлынхаа тухай хэлэлцсэн байна. Зарим мэдээллийг нь дэд бүлэгт тусгасан. Түүнчлэн Монголын бурханы шашинтнуудын Найман жилийн төлөвлөгөө болон өөр бусад хөтөлбөрийн хүрээнд Монгол орны онгон дагшин байгалийг хэрхэн хамгаалах тухай хэлэлцүүлэг хийсэн юм. (Найман жилийн төлөвлөгөөг хавсралтаас бүрэн эхээр нь үзнэ үү.)

---

<sup>11</sup> [http://www.arcworld.org/downloads/UB\\_conference.pdf](http://www.arcworld.org/downloads/UB_conference.pdf)

## **ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: ИРЭЭДҮЙН БОЛОМЖ**



### **а. Лам хуврагуудыг экологийн сургалтанд хамруулах:**

Онцар Ешэи Лин хийдээс орон нутгийн нүүрсний уурхай нь эрүүл мэндэд ямар сөрөг нөлөө үзүүлж байгааг баримтжуулах төслийг амжилттай хэрэгжүүлсэндээ уг хийдийн тэргүүн лам сэтгэл хангалуун байдаг бөгөөд цаашид ч NEMO сангийн санхүүжүүлэлтээр өөрсдийн үйл ажиллагаагаа өргөтгөх хүсэлтэй байдаг аж. Лам хуврагуудын байгаль хамгаалах мэдлэгийг дээшлүүлснээр Монголын нийт сүм хийдүүд байгаль хамгаалах тал дээр хамтран ажиллаж дорвитой ахиц гаргах боломжтой гэж тэрээр үзэж байна.

### **б. Экологийн сүм**

2007 онд Хар Хорины Эрдэнэзуу хийдээс хуучин сүмийн туурин дээр багахан сүм босгосон бөгөөд энэ сүмийн үйл ажиллагаа нь Монгол орны лус савдагуудад уншлага урилгаа зориулдаг. Сүмийн дотор загас тэргүүтэй олон амьтны зураг байх бөгөөд байгаль хамгаалах удирдамж, заавар хананд нь өлгөөстэй байдаг ба энэ нь сүсэг бишрэлээр дамжуулан орон нутгийнханд байгаль хамгаалах мэдлэг олгох энгийн хирнээ үр дүнтэй хэлбэр юм. Бүх сүм хийдүүдэд энэ санааг дэлгэрүүлүүштэй. Энэхүү экологийн сүм нь Монголын онгон дагшин байгалийн салшгүй нэг хэсэг болвол сүм нь ямар байх, түүнчлэн зориулга, агуулга, барилгын материал зэрэгт нь жишиг бий болох нь дамжиггүй.

2009 онд Гандантэгчэнлин хийдээс ARC-тай хамтран уул усны эзэн Цагаан өвгөний шинэ танка зургийг бүтээлгэсэн бөгөөд эл зурагт овоо тайлга, мал сэтэрлэх ёс, гол усанд дүлцэнгийн элс өргөх уламжлал, модны эзнийг аргадах зэрэг үйл явдлыг тусгасныг энэхүү гарын авлагад ашигласан юм. Энэ зургийг хэвлэн сүм хийдүүдэд түгээх ба лусын сүмд байрлуулбал зохистой.

### **в. Байгаль орчны асуудлыг ажлын төлөвлөгөөнд оруулах**

2008 онд Гандантэгчэнлин хийд дээр зохиогдсон хурлын үеэр 2005 онд болсон бага хурлаас хойш нилээдгүй хугацаа өнгөрсөн ч сүм хийдүүд байгаль орчны талаар төдийлэн асуудал тавьж уулзалдаагүйг цөөн бус лам нар тэмдэглэн хэлж байв. Иймд 6 сар тутамд зохиогдох ээлжит хурлаар байгаль орчны асуудлыг зайлшгүй гүйцэтгэх ёстой ажлын төлөвлөгөөнд оруулан үйл ажиллагаа, үлгэр дуурайлаараа бие биенээ уриалан ажиллавал тустай байх болов уу.

### **г. Бурханы шашинтнуудын Байгаль орчин ба хөгжлийн сүлжээ**

Гандантэгчэнлин хийдээс Байгаль орчин ба хөгжлийн сүлжээ байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд одоогоор уг ажил хэлэлцүүлгийнхээ шатанд явагдаж байна. Монголын бурханы шашинтнуудын хувьд энэхүү сүлжээ нь Найман жилийн төлөвлөгөөний эхлэл ч байж болох билээ.

#### **д. Байгаль орчинд халтай хадагны асуудал**

Хуучны уламжлалаар бол хадагыг уул хангайд өргөдөг байсан. Харин одоо шинэ үеийн мяндсан хадагийг хүмүүс дуртай газраа уядаг болсон нь байгаль орчинд муугаар нөлөөлөхөд хүрэхийн зэрэгцээ хадагны үнэ цэнийг бууруулж байгаа явдал бөгөөд аливаа зүйлийг хийхдээ хожим гарах үр дагаварыг нь сайтар анхаарах хэрэгтэйг хүмүүст ойлгуулах хэрэгтэй байна хэмээн зарим лам хуврагууд дурьдаж байлаа.

#### **е. Шүтлэгт уулын тахилгын судрын хэрэгцээ**

Монголын онгон дагшин газруудын оршин байгаа гол шалтгаан нь тэдгээрийн тахилгын судруудтай холбоотой. Тэдгээр судраар дамжуулан тухайн газар нутгийн тухай түүнчлэн яагаад тахилгатай болсон шалтгааныг мэдэж болох юм. Шашингүй үзэлт коммунист засаглалын үед ихэнх судар устаж үгүй болсон. Гандантэгчэнлин хийдээс Улаанбаатар хот орчмын газруудаас уул усны тахилгын судруудыг сурвалжлан цуглуулах ажлыг хийсэн ажээ. Орон нутгийн төв хийдүүд харъяат сумдаас уул усны тахилгын судруудыг сурвалжлан тогтоож, олшруулан тахилгат уул усыг ард олонд таниулах хэрэгтэй. Одоо цагт ч гэсэн хуучин цагаас үлдсэн судар номууд алга болох буюу устаж болзошгүй тул анхааралдаа авах хэрэгтэй. Монголд ном хэвлэхэд өртөг өндөр биш ч төслийн шугамаар унаа тэрэг хөлслөх, шатахууныг нь хийж өгөх зэрэг нь төсөл хэрэгжүүлэхэд гардаг гол хүндрэлүүдийн нэг билээ.

#### **ё. Найман жилийн төлөвлөгөө**

Монголын бурханы шашны сүм хийдүүдэд зориулсан Найман жилийн төлөвлөгөөг хөгжүүлэх санаа 2008 оны 10 сард төрсөн юм. Анх энэ санааг илэрхийлэхэд хүмүүс сэтгэл хангалуун хүлээн авсан билээ. Үндсэн санаа нь ирэх найман жилд байгаль хамгаалах шинэ уламжлал, зан үйлийг төлөвлөн хэрэгжүүлэхэд орших бөгөөд шашны бүлгүүдийг үл хөдлөх хөрөнгө (үүнд газар, байшин, санхүүгийн хөрөнгө оруулалт зэргийг хамруулна), боловсрол, халамж, амьдралын хэв маягийг сайжруулах бололцоо, хэвлэл мэдээлэл ба сурталчилгаа, нөхөрлөл, тэмдэглэлт баяр ёслол зэрэг үндсэн долоон салбарт өөрсдийн чадвар, нөөц бололцоогоо ашиглахад нь ARC/НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс дэмжлэг үзүүлэх юм. Холбогдох мэдээллийг [www.arcworld.org](http://www.arcworld.org) гэсэн хаягаар орж үзэх боломжтой. 2009 оны 11 дүгээр сард дэлхийн бусад шашинтнууд тус тусынхаа Найман жилийнхээ төлөвлөгөөний нээлтийг зарлах тэр үед Монголын бурханы шашны лам хуврагууд ч мөн адил өөрсдийн нээлтээ зарлана гэдэгт итгэлтэй байна. Үүгээр Монголын бурханы шашинтнууд хойч үедээ бүдгэршгүй өөрчлөлтийг өвлүүлж чадах билээ.

## **ТАВДУГААР ХЭСЭГ: ЛАМ ХУВРАГУУДАЙ ХЭРХЭН ХАМТРАН АЖИЛЛАХ ВЭ**



### **Анхлан харилцаа тогтоох**

Хоёрдугаар хэсэгт Монгол орны бүх аймгийн голлох сүм хийдүүдийн жагсаалтыг байгаль хамгаалах хүрээнд явуулсан үйл ажиллагааны тайлбар, харилцах хаяг болон түүхэн сурвалжийнх нь хамт оруулав. Хэрэв энэ жагсаалтанд ороогүй сүм хийд, байгууллага байвал Гандантэгчэнлин хийдэд энэ талаар хандах юмуу эсвэл орон нутгийнхаа засаг захиргаанд лам хуврагуудтай хамтран ажилладаг тухайгаа мэдэгдэж хандаарай. Аймгийн төвүүдийн ихэнх сүм хийдүүдтэй утас, факсаар харилцаж болох бөгөөд мөн ловон лам нартай нь гар утсаар холбогдох боломжтой. Зарим тохиолдолд лам хуврагуудтай уулзахаас сүм хийдэд харьяалалтай энгийн хүмүүстэй уулзах нь илүү хялбар байдаг билээ. Зарим сүм хийдүүдтэй утсаар холбоо барих боломжгүй байдаг тул орон нутгийнх нь шуудангийн салбараар дамжуулан факс илгээх буюу бие хүн явуулах шаардлагатай болдог. Өндөр зэргэмтэй лам нар нарийн бичгийн даргатай байдаг бөгөөд жишээлбэл Гандантэгчэнлин хийдийн хамба лам, шашны дээд сургуулийн захирал, захиргааны тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар гэж тусдаа байдаг. Гандантэгчэнлин хийдийн гадаад харилцааны лам Б. Мөнхбаатараар (англи хэлээр) дамжуулан холбоо тогтоож бас болно.

### **Цол хэргэм, хувь хүн**

Дээд лам нарыг “эрхэм” (Venerable) гэж хүндэтгэх ба Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба лам Чойжамц гуайг “эрхэм ламтан” (Your Eminence) хэмээн хүндэтгэн дууддаг. Томоохон хийдийн тэргүүн ламыг хамба лам гэдэг. Харин Гандантэгчэнлин хийдийн тэргүүн хамба лам нь Монголын бурханы шашны тэргүүн билээ. Дэд тэргүүлэх ламыг дэд хамба, гутгаар тэргүүлэх ламыг Да лам гэх тул үүнийг Далай лам гэдэг нэртэй андууравзай. Аж ахуйн асуудал эрхэлсэн ламыг даамал гэнэ. Хамба ламаас гадна шашин номын талыг хариуцсан лам байх бөгөөд түүнийг цорж гэх ба хамба ламгүй орон хийдийн цорж лам нь тухайн хийдийг тэргүүлдэг. Хэрэв та дацан буюу бурханы шашны гүн ухааны уламжлалт сургуульд зочилж байгаа бол тэргүүн ламыг нь шунлайв гэдэг. Гэлүгвагийн шашны хамгийн дээд эрдмийн цолыг гавж гэнэ. Монголд хувраг хүнийг лам гэж нэрлэдэг. Хэрэв танд Далай ламын нэрийг бичих шаардлага гарвал Дээрхийн гэгээнтэн Далай лам гэх юмуу эсвэл зүгээр л Дээрхийн гэгээнтэн гэж бичиж болно.

## **Мэндчилгээ**

Лам хуврагууд мэндчилэхдээ хоёр гарын алгаа цээжнийхээ өмнө хавсран бөхийдөг. Хариуд нь ижил байдлаар мэндчилээрэй. Хэрэв цаад хүн чинь эхэлж гар барихгүй бол танд гар барих шаардлагагүй. Хэрэв гар барин мэндлэх бол ханцуйгаа заавал буулгаж хүндэтгэл үзүүлээрэй. Хэрэв та зочин бол уулзах хүндээ цэнхэр өнгийн хадаг барина. Ингэхдээ хоёр гарын алгаа дээш хандуулан эрхий хуруугаа хадагнахаа дээгүүр гаргах хэрэгтэй. Энэ нь зочин хүнээс цаад хүндээ үзүүлж буй хүндлэл билээ. Хариуд нь нөгөө хүн хүндлэл болгон хадгийг чинь аваад таны мөрөн дээгүүр эргүүлж тохож өгдөг ёс бий. Хүмүүс лам хуврагуудын буцааж өгсөн хадагийг адистай хэмээн сүсэглэдэг. Хадагийг гурав эвхээстэй нуглах бөгөөд хүнд барихдаа заавал задгай амтай талыг нь барьж байгаа хүнлүүгээ хандуулдаг ёстой. Хадагны амыг нь буруу тийш нь харуулж барих нь цаад хүндээ хорлол хийхийг илэрхийлсэн муу утгыг агуулдаг тул сэрэмжлээрэй.

## **Лам хуврагуудтай уулзах**

Лам хуврагуудтай уулзах, сүм хийдэд орохдоо төлөв төвшин хувцаслаарай. Ердийн хувцас өмсөж болно. Гэхдээ задгай хувцаснаас татгалзвал зохино. Уулзалтын өдөр товлох болон аливаа төсөл эхлэхдээ уламжлалт цаг тооны бичгийг дагах эсвэл сүм хийдэд нь очин тусгай засал ном уншуулбал зохистой. Лам хуврагуудтай уулзах нь тийм ч амар биш байдаг. Аливаа шинэ үйлийг эхлэхэд барилдлага сайтай тусгай өдрүүд гэж байдаг. Лам хуврагуудтай уулзахад тохиромжтой тодорхой цаг ч бас бий. Сүм хийдүүд өглөөний цагаар хурал номын үйл ажиллагаатай байх бөгөөд лам хуврагууд хурал номондоо суухдаа зэргэмжийн дагуу суудлаа барина. Хамгийн том лам нь мөрний эхэнд суудаг. Лам хувраг хүнтэй уулзахдаа босч угтан дотогш оруулан суух суудлыг нь зааж өгөхдөө зөв гараа бүтэн урагш сунган хүндэтгэлтэйгээр зааж өгөөрэй. Уулзалтын төгсгөлд лам хүн таны мөрөн дээгүүр хадаг тохон хүндлэл үзүүлэх ёс бас бий.

## **Мөнгөтэй холбоотой асуудал**

Сүм хийдэд санхүүгийн асуудлыг хариуцсан тусгай лам нар байх ба санхүүгийн бүх асуудлыг хамба лам, ахмад лам түүнчлэн тэргүүлэгч, нягтлан зэргийн оролцоотойгоор шийддэг. Гарсан шийдвэрүүдийг бичиг хэрэгт хөтөлдөг бөгөөд нягтлан зэрэг тусгай лам нар хэрэгжүүлдэг. Төсөлд оролцож байгаа лам нарын хувийн санхүүжүүлэлт нь ихээхэн хязгаарлагдмал байдаг тул төслийн шугамаар эсвэл хурал цуглаанд оролцохоор явах тохиолдолд лам нарын аялалын зардал болон бусад зардлыг сүсэгтэн хүмүүс хувиасаа гаргадаг явдал бий. Тодорхой хүрээг хамруулсан хурал уулзалт зохион байгуулахаар бол төслийн зүгээс лам хуврагуудаас гарах зардлыг нь эргүүлэн олгох нь зохистой.

## **Төслийг юу амжилтанд хүргэдэг вэ**

Сүм хийдүүдтэй хамтран ажиллах нь чухамдаа буянтай сайхан зүйл билээ. Нэгэн хэвийн үйтгартай оффисын өрөөнүүдийг ардаа орхиж оронд нь идэвх санаачлагатай лам хуврагууд цугларсан шүтлэг мөргөлийн дагшин оронд очино.

Хөгжилт ертөнцөд хэрэглэгддэг ч гэсэн шашин номын газар хэрэглэхэд зохимжгүй олон үг байдгийг мэдвэл зохистой. Төслийнхөө талаар санхүү, зарлагын падаантай хэрхэн харьцах ба бусад бүхий л шаардлагатай зүйлсийг ажлын эхэнд сайтар тайлбарлах нь ихээхэн чухал байдаг. Хувь хүнтэй ганцаарчилан ажиллахын оронд багаар ажиллан багийн бүх гишүүдэд үйл ажиллагааныхаа тухай тодорхой танилцуулж байх нь цаашид ажил явуулахад маш дөхөмтэй байдаг.

### **Сүм хийдэд мөрддөг ёс дүрэм**

Бурханы шашны сүм хийдэд зочлохдоо эхлээд хариуцсан хүн байгаа эсэхийг шалгах нь зөв. Олон нийтэд тодорхой цагуудад л нээлттэй байдаг бурханы шашны олон төв бий. Лам хуврагууд хурал ном хурах, гүн ухааны хэлэлцүүлэг хийх үед дацан сүм хийдийнх нь хаалга нээлттэй бол орж болно. Гэсэн хэдий ч эхлээд дотор байгаа лам нараас зөвшөөрөл авах нь зүйтэй. Дотогш орохдоо гутлаа тайлахгүй ч гэсэн малгайгаа авах хэрэгтэй. Цаг агаарын хүйтэнд бусдын жишгийг дагах ба тодорхойгүй үе тохиовол гутлаа тайлсан нь дээр бөгөөд харин тэднийг биедээ авч явж болохыг лавлаарай. Сүм хийдийн босгон дээр зогсож болохгүй. Сүм дуган, шүтээн, сувраг, овоог нар зөв тойрдог. Сүм дуган дотор орохдоо хийдийн амгалан байдлыг эвдэхээс зайлсхийн гар утсаа унтраахаа мартуузай. Монгол хүмүүс сүм дуганд орохдоо биеийн мөргөл хийдэг. Хэрэв та тэдэнтэй адил мөргөхгүй бол үл ялиг бөхийн хоёр гарын алгаа энгэртээ хавсран бусдыг мөргөж дуустал чимээгүйхэн хүлээгээрэй. Сүм дуганд ороод бурхан шүтээний өмнө очихдоо бурхад сахиусны өмнө хадагаа тавин лам хуврагт хүндэтгэл үзүүлдэг шиг хоёр гарын алгаа энгэртээ хавсран хүндэтгэл үзүүлж болно. Хүндэтгэлийн бас нэг хэлбэр нь бурхан сахиусны өмнө зул барих явдал юм. Багш нар, лам хуврагуудыг сүм дуганд орж ирэх, гарч явахад нь босч хүндэтгэл үзүүлээрэй. Лам хуврагууд болон бусад хүмүүсийн өмнүүр гарахдаа сайтар бөхийж гарах нь зохистой. Суух үедээ сөхөрч суух болон завилж суух нь сайн. Сүм дотор суухдаа хөлөө тэнийлгэх шаардлага гарвал лам нар болон шүтээний зүгт хөлөө хандуулж болохгүй. Ихэс лам хуврагт мөргөж хадаг барих үед лам хуврагуудаас эхлэн эрэмбийн дагуу мөргөн хадгаа барьдаг. Бурханы шашны соёлд эрэгтэй лам хуврагууд нь эмэгтэй санваартнуудын өмнө явдаг. Ихэс ламын өмнө очин хадгаа барихад тэрээр өөрийн гараараа толгойд чинь адис тавих бөгөөд өөрөө эсвэл шавь нь бяцхан зангилаатай тарнидсан улаан утсыг өөрт чинь өгнө. Энэ утсанд хүндэтгэлтэй хандан дор газар битгий тавиарай. Монголчууд энэ утсыг хүзүүндээ зүүх буюу бурхан шүтээндээ хийж хадгалдаг. Хэрэв та зураг авахыг хүсвэл зөвшөөрөл аван зохистой цагийг харж хурал номд саад бололгүйгээр зураг авах нь зүйтэй.

### **Бурханы шашны зүйлс**

Бурханы шашны сүм хийдийн эд зүйлс тэрчлэн байгалийн онгон дагшин газар нутгийг ариун гэж үздэг тул сүм дуганы барилгын хормой дээр суух болон дээр нь хөлөө тавихыг цээрлэ. Суврагт сүншигийн ном, хутагт хувилгаадын лагшингийн чандар, бурханы дүрийг залдаг. Сувраганд хүндлэл үзүүлж нар зөв тойрч гараарай. Бурханы шашны судар номыг нарийн урт цаасан дээр бичдэг ч ердийн номын хэмжээтэй цаасан дээр хэвлэх тохиолдол ч бас бий. Судар номыг улаан юмуу шар даавуугаар баринтагладаг. Ном судрыг нам дор газарт тавих, дээгүүр нь

алхах болон өөр бусад эд зүйлийг дээр нь тавихыг цээрлэдэг. Сүм хийдийг тойрон металл, цилиндрийн хэлбэртэй дотроо ном судар агуулсан зүйлийг хүрд гэх бөгөөд үүнийг нар зөв эргүүлнэ. Ингэснээр мөргөл уншлагыг агаарт түгээн тоо томшгүй олон амьтанд тус хүргэж байна гэсэн утга юм.

### **Монголчуудын нийтлэг ёс**

Аливаа биет болон хүмүүсийг заахдаа үргэлж гарынхаа алгыг дээш нь хандуулаарай. Монголчуудын хувьд гарын хуруугаар зангах нь зохисгүй үзэгдэл билээ. Хэн нэгэн таньд хоол, унд өгвөл заавал авч амсаарай. Цааш нь идэж амжимгүй бол өмнөх ширээн дээрээ буцаан тавьж бас болно.

## ДЭД БҮЛЭГ: БАРИМТЫН СУДАЛГАА

### Байгаль хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа сүм хийдүүд

Энэ бүлгээс байгаль орчны чиглэлээр ажиллаж байгаа сүм хийд, төрийн бус байгууллага болон бусад холбогдох байгууллагуудын харилцах хаягыг үзнэ үү.

#### 1. МБШТөв Гандантэгчэнлин буюу Гандан хийд

Улаанбаатар хотод орших Гандантэгчэнлин хийд нь 850 орчим ламтай, Монгол улсын хамгийн том хамгийн чухал хийд билээ. Гандантэгчэнлин хэмээх нэр нь Төгс баясгалант их тив гэсэн утгатай. Энэ хийд Эрдэнэзуу хийд болон бусад гол гол хийдүүдтэй хамтран байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ARC, Дэлхийн Банкнаас хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож бусад сүм хийдүүдийг энэ чиглэлийн үйл ажиллагаанд татан оролцуулж байгаа үлгэр жишээ хийд юм.

Тус хийдийг байгаль орчны төрийн бус байгууллагуудтай холбон ажилладаг Да лам Бямбажав хэлэхдээ “Гандантэгчэнлин хийд нь үндсэн бурханы шашны сургалтаа голлон анхаардаг билээ. Гэхдээ байгаль хамгаалах ажил бол сүм хийдүүдийн сургалтынх нь салшгүй нэг хэсэг мөн. Үйлийн үрийн сургаалын дагуу лам нар мод огтлох, ус бохирдуулахийг цээрлэх ба хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалдаг. Өнгөрсөн 70 жилд коммунистууд Монголын бурханы шашныг үндсэндээ бүрэн үгүй хийсэн. Тиймээс лам хуврагууд бид сүйтгэгдсэн сүм хийд, алдагдсан ёс уламжлалаа дахин сэргээхээр ажиллаж байна. Харин одооноос эхлэн байгаль орчин болон нийгмийн салбарт хандсан үйл ажиллагаа явуулна. Ирээдүйд эдгээр салбаруудад олон зүйл хийж бүтээхээр төлөвлөөд байгаа.”

“Сүм хийд бүр сүсэгтэн олонд зориулсан байгаль орчны тухай сургалт, танин мэдэхүйн тусгай өрөөтэй болох хэрэгтэй. Хэрэв тусгай өрөө гаргах боломжгүй бол ядаж сүм хийд дотроо тусгай булантай болох хэрэгтэй. Лам хуврагууд олборлолт хийгдсэн болон хийгдээгүй газар нутагт амьдарч буй нутгийн ард олонтой уулзан байгаль орчны талаар яриа таниулга хийх хэрэгтэй байна. Учир нь бурханы шашны сургаал заримдаа засгийн хууль дүрмээс ч илүү хүчтэй байдаг” гэв.



#### Хэрэгжүүлсэн төслүүд

1. “Амьд гаригт зориулсан нандин бэлэг” Катманду хотод дэлхийн шашинтнуудын хэрэгжүүлж буй төслүүдийг танилцуулах уулзалт хурлыг 2000 онд WWF, ARC-аас зохион байгуулсан бөгөөд Гандантэгчэнлин хийд энэ уулзалт хуралд оролцон мөхлийн ирмэгт хүрээд байгаа цасны ирвэс, гөрөөсийг хамгаалах олон зууны түүхтэй Монголын бурханы шашны уламжлалыг танилцуулжээ. Энэ уламжлал нь бурханы шашны амьтан бүгдийг хайрлан хамгаалах сургаалын нэг хэлбэр бөгөөд

бурханы шашинтнуудыг байгалийн баялагийн менежментийг тогтвортой ашиглахад хөшүүрэг болдог байна. 2001 онд бурханы шашинтнуудын уламжлалт тахилгат Богд Хаан уул (Монголын хамгийн анхны бурханы шашны дархалсан уул), Хан Хэнтий тусгай хамгаалалтын бүс зэрэг газруудад энэхүү амьд гарагт зориулсан нандин бэлгийг хүргэсэн.

2. Монгол орны ариун дагшин газруудын тухай цуврал хэвлэлүүд: Монгол орны ариун дагшин газрууд 2001, Нутаг орны домог 2001, Уул, усны тахилга 2004

3. Байгаль экологи, хөгжил сэдэвт хойд бүсийн бурханы шашинтнуудын бага хурал.

4. Зургаан газарт чулуун хөшөө босгосон. Энэ төслийг ARC, WWF-аас хэрэгжүүлсэн.

5. Бурханы шашин, байгаль орчны тухай сэтгүүл гаргасан.

6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хийсэн.

7. Бурханы шашны байгаль орчны хөгжлийн холбоог үүсгэлцсэн. Энэ холбооны зорилго нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа лам хуврагууд болон сүм хийдүүдийн үйл ажиллагааг нэгтгэхэд чиглэсэн. Тодорхой өдрүүдэд мал гаргах, ан агнахыг цээрлэсэн зурхайн цаг тооны бичгийг хэвлүүлсэн. (Дэлгэрэнгүйг 4 дүгээр бүлгийн 1 дүгээр хэсгээс үзнэ үү)

8. Бусад сүм хийдүүдийн адил нутаг орны сайн сайхны тулд Гандантэгчэнлин хийдээс овоо тахилгын зан үйлийг хийдэг.

9. Бурханы Шашны Урлахуйн Ухааны Дээд Сургуулийн захирал бурханч лам Г. Пүрэвбаттай хамтран Чансаа сонинд байгаль орчныг хамгаалах асуудлаар нийтлэл хэвлүүлсэн. NEMO сангаас санхүүжүүлсэн төслийн хүрээнд бурханч лам Г. Пүрэвбат Монголын хөдөө нутгаар уламжлалт байгаль хамгаалах сэдвээр лекц уншсан.

11. Шашин, Байгаль Орчин, Хөгжил номыг орчуулан, эмхтгэн хэвлүүлсэн.

12. Уул усны эзэн Цагаан өвгөний шинэ танка зургийг бүтээсэн бөгөөд эл зурагт овоо тайлга, мал сэтэрлэх, дүлцэнгийн элс гол усанд өргөх, модны эзнийг аргадах зэрэг үйл явдлыг тусгасныг энэ товхимолд ашиглав. Үүнийг сүм хийд болон сүсэгтэн хүмүүст тараана.

### **Хийдийн түүхээс**

Монголын бурханы шашны тэргүүн тавдугаар богд Жавзандамба хутагт бээр Гандантэгчэнлин хийдийг анх 1838 онд Далхын дэнж дээр байгуулжээ. Тэрээр бурханы шашны бүхий л ухаанд оройлсон билиг оюуны дээд хутгыг олсон гэгээнтэн байсан юм.

Тухайн үед 5'000 гаран лам хуврагтай, бурханы шашны гүн ухаан, уламжлалт анагаах ухаан, зурхайн ухаан болон тарнийн ёсны есөн дацантай байжээ. XX

зууны эхэн үест Гандантэгчэнлин хийд Монголд бурханы шашны судлалын үндсэн төв нь болж чадсан байдаг. Гэвч 1938 онд хэлмэгдүүлэлтийн шуурганд хаагдаж зургаан жилийн дараа буюу 1944 онд үзвэрийн байдлаар дахин нээгдсэн бөгөөд коммунист засгийн үед шашин номын үйл ажиллагаатай байсан цорын ганц хийд байжээ. Өнөөдөр энэ хийд Монголын бурханы шашны төв нь бөгөөд гол гурван дуган, Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит бурханы шашны их сургууль, Дашчойнпэл, Гунгаачойлин, Идгаачойнзинлин зэрэг гүн ухааны уламжлалт сургуулиуд, уламжлалт анагаах ухааны болон зурхайн дацан, тарнийн ёсны Жүд дацан зэрэг салбаруудтай.

XX зууны эхэн үеэр өнөөгийн Улаанбаатар хотыг Их хүрээ буюу “Хурал номын их орон” гэсэн утгаар нэрлэж байжээ. Гандантэгчэнлин хийд нь Төвдийн бурханы шашинд зэргэмжээрээ Далай лам, Ванчин богд нарын удаа орох Богд хаан буюу Богд гэгээн алдраар олноо алдаршсан Жавзандамба хутагтын суудал барьсан хийд юм.

1912 онд 26.5 метр өндөртэй Жанрайсиг бурханы дүрийг бүтээсэн боловч коммунист засгийн үед уг дүрийг эвдэн хайлуулж металлээр нь зэвсэг хийсэн гэдэг. Тус хийдийн настай лам хуврагуудын санаачлага болон тэр үеийн соёлын яамны сайд байсан Н. Энхбаярын дэмжлэгээр уг бурханыг 1996 онд дахин бүтээн залсан нь Монголчуудын бахархлыг эргүүлэн авчирсан үйл явдал болсон.

1990 онд анхны бурханы шашны их чуулганыг орон даяар зарлан зохион байгуулжээ. Монгол даяар үйл ажиллагаагаа явуулж байсан бүхий л сүм хийдүүдийн тэргүүлэгчид болон төлөөлөгчид оролцсон энэ чуулганаар үндэсний хэмжээнд хамгийн том нь болох Гандантэгчэнлин хийдийг Монголын бурханы шашинтны төвөөр, тус хийдийн тэргүүн их хамба ламыг уг төвийн тэргүүнээр тус тус сонгожээ. Энэ хийд Монгол улсын 21 аймгийн сүм хийдүүдийг боловсон хүчнээр хангадаг ба Азийн буддистуудын энх тайваны бага хурлын удирдах газар 1969 оноос хойш энэ хийд дээр үйл ажиллагаа явуулж байна.

### **Харилцах хаяг**

Гадаад харилцааны албаны лам Б. Мөнхбаатар  
Ажлын утас: +976-11-360337 Факс: +976-11-360354 Гар утас: +976-99834099  
Цахим хаяг: mbcgandan@magicnet.mn, munkhbaatar\_mgl@yahoo.com. Да лам Бямбажав Ажлын утас: +976-11-300974 Факс: +976-11-360354 Гар утас: +976-99117415 Цахим хаяг: byambajav@gandan.mn.

## **2. Эрдэнэзуу хийдээс ARC, Английн Элчин Сайдын Яам, Монгол улсын засгийн газартай хамтран явуулсан үйл ажиллагаа**

Эрдэнэзуу хийд нь Чингис хааны нийслэл Хар Хорум хотын туурин дээр байгуулагдсан бөгөөд газар зүйн хувьд Монгол орны төв хэсэгт оршино. Улаанбаатар хотоос авто машинаар 6 цаг зорчин уг хийдэд хүрдэг. Дээр үедээ 62 дугантай 1'000 гаран ламтай байсан боловч 1939 онд дайрсан хэлмэгдүүлэлтийн хар салхинд

бүгд сүйтгэгдсэн аж. 1990-ээд оны үед Лавран дуган нь лам хуврагуудын мэдэлд эргэж ирсэн байдаг. Харин зуугийн гурван дуганыг сүм музейн зориулалтаар ашиглаж байгаа бөгөөд жуулчдын очих дуртай газар болжээ. Өнөөгийн байдлаар Эрдэнэзуу хийд нь 30 гаруй залуу лам хуврагуудтай. Эдүгээ Эрдэнэзуу хийд өөрийн Erdene Zuu Endeavor (EZE) салбараараа дамжуулан боловсрол, байгаль орчин, нийгмийн шударга ёсны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. EZE нь 2005 онд байгуулагдсан бөгөөд мөргөлчдийн хандиваар санхүүждэг. ARC, Английн Элчин Сайдын Яам, Монгол улсын байгаль орчны яамнаас санхүүжилт авч байв.

### **1. Боловсрол**

2005 онд бурханы шашны байгаль орчны бага сургуулийг байгуулан 30 гаран залуу лам нарт шашны боловсрол эзэмшүүлэхийн зэрэгцээ уламжлалт ба орчин цагийн байгаль хамгаалах арга ухааныг эзэмшүүлж байна.

### **2. Монголын уламжлалт экологийн төсөл**

Бүс нутагтаа дархлагдсан ой модыг сүйтгэж байгаа явдлыг хязгаарлах зорилгоор Монголын уламжлалт экологийн төслийг хэрэгжүүлдэг. Нутгийн хамгаалалттай бүсээс мод хулгайгаар огтлон орон нутгийн хоолны газарт борлуулдаг ядуу хүүхдүүдийн асуудал олны сэтгэлийг зовоож байв. Орон нутгийн хүмүүс энэ тухай мэдээлснээр лам хуврагууд тэднийг гэр бүлийнх нь хамтаар амьдрах ухааны сургалтанд хамруулсан нь анхлан бодсоноос ч илүү үр дүнд хүрчээ.

2005 оны 4 сараас 7 сарын хооронд 50 хүүхэд UNESCO-гийн загварт суурилсан амьдрах ухааны сургалтанд нийт 40 цаг хамрагдаж уламжлалт байгаль хамгаалах ухаан ба бурханы шашинтай танилцаж өөрийгөө болон бусдыг хүндлэх, шийдвэр гаргах, бүтээлчээр сэтгэх болон харилцааны ухаанд суралцжээ. 2006 онд орон нутгийн хүмүүсийн хүсэлтээр дараагийн 50 хүүхдийг эцэг, эхийнх нь хамтаар сургалтандаа хамруулсан байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд ой модоо сүйтгэвэл ямар их сөрөг үр дагавар гарах талаар хүүхдүүд тодорхой мэдлэгтэй болсон. Өвлийн цагаар түлээ түлшний бэрхшээл их гардаг тул эдгээр хүүхдүүдийг уламжлалт гар урлалд сургаж бүтээлийг нь Хархоринд зочилж байгаа жуулчдад борлуулах боломжийг хөгжүүлэх, ар гэрийг нь орлогын өөр эх сурвалжаар хангах, хоолны газруудад түлшний өөр туйлбартай хувилбарыг нэвтрүүлэх, орон нутгийнхаа идэвхтэй хүмүүсээр мод арчлуулах зэрэг ажлуудыг хийж байна.

### **3. Бясалгалын модтой цэцэрлэг**

Хархорин нь тал, хангай хоёрын зааг дээр оршино. Уулархаг газраараа тодорхой хэмжээний ой модтой боловч түлээ бэлтгэх, байшин барихад хангалттай биш билээ. Гэтэл сүүлийн үед энэ нутагт ой модыг огтлох явдал хурдацтай нэмэгдэж байна. Лам хуврагууд сумын төвдөө ойрхон 2'000 хавтгай метр газрыг бясалгалын зориулалттай ашиглахаар хашаа татан хамгаалжээ. Энэ хашаандаа Ногоон дарь эхийн тигээр мод суулгаж байгаа нь туршилтын шатандаа явж байна. 2007 онд 800 хар модны суулгац авчирч тарьсан боловч ихэнх нь Хар Хорины хөрс, цаг агаарт таараагүйн улмаас ургаагүй ажээ. Орон нутгийг моджуулахад ямар төрлийн мод энэ орчин нөхцөлд ургах боломжтойг тогтоох ба орон нутгийнханд түлшний найдвартай өөр эх сурвалжийг бий болгох талыг судлах зорилготой.

#### **4. Экологийн сүм**

Эрдэнэзуу хийд Хар Хорины ууланд нэгэн жижигхэн лусын сүм байгуулжээ. Аялагчдыг байгаль орчинтой зүй зохистой харьцаж, хайрлаж хамгаалаасай гэсэн үүднээс Монгол орны онгон зэрлэг байгалийн газрын зураг болон гэрэл зургуудыг дэлгэн үзүүлдэг байна. Энэ сүмд Гандантэгчэнлин хийдээс ARC-тай хамтран хэвлүүлсэн мод огтлох, ан агнах цээртэй өдрүүдийн барилдлагыг тооцон гаргасан цаг тооны бичгийг түгээдэг аж.

#### **Харилцах хаяг**

Эрдэнэзуу хийдийн ловон лам Баасансүрэн. Утас: +976-99097711 Цахим хаяг: baasansuren@erdenezuu.mn.

#### **5. Онгон дагшин газар**

Онгон дагшин уулсынхаа тухай мэдэх, хүндлэн шүтэж хамгаалах нь орон нутгийнхны ажил билээ. EZE-гээс хэлмэгдүүлэлтийн үед нууцаар хадгалж үлдсэн судар номуудыг хадгалж байгаа орон нутгийн айл өрхүүдийг сурвалжлан тогтоохоор төлөвлөж байгаа бөгөөд эл хөтөлбөрт санхүүжилт үгүйлэгдэж байгаа ажээ. Эрдэнэзуу хийдийн ловон Баасансүрэн хэлэхдээ “Уг судар номнуудыг сурвалжлан тогтоож олшруулан орчин цагийн Монгол хэл рүү хөрвүүлэн хэвлэх бодолтой байгаа. Ингэснээр ямар агуулгатай судар номнууд болохыг орон нутгийн хүн ардад таниулах ба тухайлсан дүйчэн өдрүүдээр орон нутгийнхаа сүм хийдэд уг судар номыг хурах боломж бий болох юм. Ер нь судар номуудыг сурвалжлан тогтоох тал дээр хүндрэл гарч байгаа. Хүмүүс ийм судрыг мөнгөөр зарвал ашигтай гэсэн бодолтой байдаг бөгөөд ламд үзүүлбэл зүгээр авчихна гэсэн буруу айдастай байдаг.” гэв.

#### **6. Хорих анги**

Хоригдлуудаа цэцэрлэгжүүлэх арга ухаанд сургахаар шийдэж, хүнсний ногоо тариалахад тохирсон үржил шимт газрыг хэрхэн мэдэж авах талаар туслалцаа үзүүлэхийг хүссэн орон нутгийн хорих ангийн даргийг лам хуврагууд Английн Элчин Сайдын Яамтай холбож өгсөн бөгөөд тус яамнаас уг хорих ангийн үйл ажиллагаанд зохих ёсны дэмжлэгийг үзүүлжээ.

#### **Харилцах хаяг**

Эрдэнэзуу хийд болон Эрдэнэзуу төслийн ловон лам, тэргүүн Баасансүрэн. Утас: +976-99097711 Цахим хаяг: baasansuren@erdenezuu.mn.

### **3. Дэлхийн Банкны NEMO сантай хамтран явуулсан Онцар Ешэи Лин хийдийн уурхайн төсөл**

2005 оны 10 сард Улаанбаатар хотоос зүүн зүгт 140 километрын зайтай орших Багануур дүүргийн Онцар Ешэи Лин хийдээс санаачилан Дэлхийн Банкны NEMO сангийн санхүүжилтээр уурхайгаас байгаль ба хүний эрүүл мэндэд учруулж байгаа сөрөг үр дагаварыг баримтжуулах төсөл хэрэгжүүлжээ. Энэ уурхай жилдээ 2.5 сая тонн нүүрс олборлодог бөгөөд Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцын нүүрсний 70 хувийг дангаараа нийлүүлдэг.

Дэлхийн Банкны NEMO сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл нь уурхайн үйл ажиллагаа оршин суугчдын болон уурхайчдын эрүүл мэндийг ноцтой муутгаж байж болзошгүй гэсэн таамаглалд бодит хариулт болсон байна. Түүнчлэн төслийн хүрээнд Багануур дүүрэгт байгаль орчны мэдээлэл, судалгааны төвийг байгуулж ард иргэдэд үр дүнг нь танилцуулах, орчны бохирдлыг бууруулах талаар дүүргийн оршин суугчдыг сургалтанд хамруулах зэргээр ажиллав.

Уг дүүрэгт хийсэн шинжилгээний үр дүн гарахад Багануурын уурхай нь оршин суугчдын эрүүл мэнд болон орон нутгийн байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байсан нь батлагджээ. Энэ уурхайн нүүрснээс ялгарах маш нарийн тоосонцор, хүнд металлын өндөр хувь болон нүүрс олборлолтоос ялгарах химийн хортой элемент зэрэг нь орон нутгийн оршин суугчдын эрүүл мэндэд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байв. Зөвхөн Багануур дүүрэг гэлтгүй уг нүүрсийг хэрэглэдэг Улаанбаатар хотод ч үүнтэй ижил байдал хэдийнээ үүсчээ.

Олборлолтын үед нүүрс хоргүйжүүлэх механизмыг нэвтрүүлэх, мэдээллийн төв байгуулах, мөн орон нутгийн сургуулиудийн сургалтын хөтөлбөрт байгаль орчны талаар бурханы шашны баримталдаг ойлголтыг сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах, уурхайчид болон тэдний ар гэрийнхэнд өдөр тутмын хэрэглээндээ нүүрсний хорыг багасгах тал дээр прагматик зөвлөгөө өгөх боломж бий эсэхийг асуусан олон санал хүсэлт ирсэн байдаг. Энэ төслийн үйл ажиллагаа нь оршин суугчдын зүгээс онцгой дэмжлэг хүлээсэн ч дүүргийн засаг даргын алба, орон нутгийн христийн шашинтнуудын зүгээс эсэргүүцэлтэй тулгарсан байна.

1996 онд байгуулагдсан Онцар Ешэи Лин хийд нь 16 ламтай, 8 туслах ажилчинтай. Анх 1996 онд байгуулагдсан ч 2003 онд энэ нэрээрээ дахин сэргээгдсэн ажээ. Энэ хийд дээр Зана Агваанбалдангийн судалгааны төв байгуулагдан Монгол Улсын Их Сургуулийн Шашин Судлалын Тэнхимтэй хамтран энгийн иргэдэд бурхан шашны мэдлэг олгох, хурал номын үйл ажиллагааг тогтвортой явуулах зэрэг үйл ажиллагаануудыг явуулж байна. Санхүүжүүлэх байгууллага, хувь хүн олдвол энэ хийд байгаль орчин болон нийгэм рүү чиглэсэн үйл ажиллагаануудыг цаашид өргөн хүрээгээр явуулах хүсэлтэй аж. “Хэрэв бидний үйл ажиллагааг дэмжих хувь хүн, хандивлагчид байх аваас энэ төслийг цаашид үргэлжлүүлэх сонирхол бидэнд их байна.” гэж Онцар Ешэи Лин хийдийн ловон лам хэлсэн юм. Мөн тэрээр “Онцар Ешэи Лин хийдээс шашин номын тал дээр олон сүм хийдтэй хамтран ажилладаг ч байгаль орчны салбарт энэ чинээгээр ажиллаагүй байна. Лам хуврагуудыг нь байгаль орчны сургалтанд хамруулбал сүм хийдүүдэд энэ чиглэлээр хамтран ажиллах нөхцөл даруй бүрдэнэ. Биднийхтэй ижил төстэй төсөл, санал гарч ирвэл бидний зүгээс хамтран ажиллахад бэлэн байна.” гэж нэмж хэлсэн юм.

### **Харилцах хаяг:**

Ловон лам О. Цацралтөр. Ажлын утас: +976-121-22578 Гар утас: +976-9911-0461 Цахим хаяг: Buddhist\_mng@yahoo.com. Төслийн зөвлөх Камо Ёшиаки.

#### **4. Дашчойлин хийд**

Дашчойлин хийд нь Улаанбаатар хотод байршилтай бөгөөд ашигт малтмалын компаниудын үйл ажиллагааг хурал номондоо даатгадгаараа олны танил болжээ. Дашчойлин хийдийн лам Н. Батсайханы хэлснээр бол ашигт малтмалын компаниудын 80 хувь нь энэ хийдэд лус савдаг аргадуулах хурал ном хуруулдаг аж. Ингэж хурал ном хурах нь газар нөхөн сэргээхэд дэм болдог. Харин компаниуд олборлолт хийж байгаа газар, ашиглаж байгаа техникийнхээ талаар сүм хийдээс зөвлөгөө авдаггүй тул тухайн компаниудын үйл ажиллагаа байгаль орчинд чухам ямар нөлөө үзүүлж байгааг сүм хийдүүд төдийлөн мэддэггүй.

Дашчойлин хийд нь төрийн болон орон нутгийн овоо тайлгын ёслолд оролцдог ба лам хуврагууд нь гол усны лус савдагыг тахиж зан үйлийг үйлддэг. 2005 онд Түжийн нарсанд 1'000 мод, Богд Хаан ууланд 1'000 мод, 2007 онд Богд Хаан ууланд дахин 1'000 мод тарьсан аж. Дашчойлин хийд өөр бусад шашны байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ хүмүүнлэг, боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай мөн хамтран ажилладаг. Дэлхийн Бурханы Шашинт Залуучуудын Холбоо, Азийн Буддистуудын Энх Тайваны Бага Хурал, Дэлхийн Буддистуудын Холбооны гишүүн хийд билээ.

“Байгаль орчныг хамгаалах явдал бол бурханы шашны салшгүй нэг хэсэг билээ. Бурханы шашин бол шинжлэх ухаанч шашин ба байгаль хамгаалах арвин их уламжлалтай. Хог тарих, амьтны амь таслах, газар ухаж хөндөхийн сөрөг үр дагаварыг учир шалтгааны үүднээс тайлбарлан сургадгаараа байгаль экологид ээлтэй шашин юм. Ер нь бурханы шашны үндсэн үйл ажиллагаануудынх нэг нь байгаль орчныг хамгаалах үйл. Байгаль хамгаалах үйлст залуу хүмүүсийг татан оролцуулах хэрэгтэй бөгөөд тэдэнд байгаль орчныг хамгаалах сэтгэхүйг бий болгох нь чухал. Гэрийнхээ гаднах орчны хогийг цэвэрлэж байгаа сургуулийн жаахан хүүхэд ч хажуугаар өнгөрч байгаа хэн бүхэнд тэр сэтгэхүйг өгч чадах юм.” гэж Н. Батсайхан өгүүлэв.

#### **Хийдийн түүхээс**

Урьд нь Дашчойлин хийдэд олон эрдэм мэдлэгтэй лам хуврагууд сууж байжээ. Эл хийд 1990 онд дахин сэргээгдсэн бөгөөд өнөөгийн байдлаар 100 гаран ламтай. Цогчэн дуган, Сахиусны дуган, Ганданчойнхорлин зэрэг гурван дугантай бөгөөд мөн олон ховор нандин шүтээн бурхантай. 1998 онд Зүүн Хүрээ Коллежийг байгуулсан. Тус коллеж лам хуврагуудад бурханы шашны боловсрол, бурханы шашны гүн ухаан, Санскрит, Төвд, Монгол хэл зүйн ухааныг эзэмшүүлдэг.

#### **Харилцах хаяг:**

Хамба лам Дамбажавтай байгаль орчны төслөөр харилцаж болно. Утас: +976-11-352006.

## **5. Амарбаясгалант хийд**

Сэлэнгэ аймгийн нутгийн хойд хэсэгт орших энэ хийд Монголын гурав дахь том хийд юм. Өнөөдөр энэ хийдэд 60 орчим лам хуврагууд суурин амьдарч байгаа бөгөөд лам хуврагууд нь хийдийнхээ хүрээнд амьдардаг цөөхөн хийдүүдийн нэг юм. 2002 онд Амарбаясгалант хийд Амар Мөр ТББ-ыг үүсгэн байгуулж хоригдлууд, өнчин хүүхдүүд, ядуу буурай айл өрхийн хүүхдүүдэд буюны үйл ажиллагаагаа хүргэж эхэлжээ. Энэ ТББ бурханы шашны лидерүүдийг гадаадаас урин залж ном тавиулах зэргээр бурханы шашны сургалтуудыг зохион байгуулдаг.

2003 онд ARC, WWF-аас зохион байгуулсан байгаль орчны сургалтын хөтөлбөрт лам нараа хамруулсан. (Энэ хөтөлбөрөөр сүм хийдүүд байгаль цаг уурын өөрчлөлтийн тухай сургалтанд суусан ажээ.) “Монгол орны онгон дагшин газрууд” хэмээх номыг хэвлүүлэхэд хувь нэмрээ оруулсан. 2004 онд Амарбаясгалант хийд ARC-аас WWF-тай хамтран зохион байгуулсан бурханы шашны үндэсний боловсролын хөтөлбөрт оролцжээ. Энэ хөтөлбөрөөр лам хуврагууд болон малчдыг усны нөөц болсон гол горхийг хамгаалах тухай сургалтад хамруулан гол ус хамгаалах шашны зан үйл үйлдсэн бөгөөд энэхүү зан үйлийн ач холбогдлыг орон нутгийнханд таниулжээ. Энэ төсөл засгийн газраас зарласан “Монгол улсын Улсын Үндэсний Жилийн Аян”-д багтсан байна. Эдүгээ жуулчид, мөргөлчид ихээр ирэхийн хирээр хог хаягдлын асуудал анхаарал татаж эхэлжээ.

### **Хийдийн түүхээс**

Манж Чин улсын Энх Амгалан хаан зарлиг буулган Амарбаясгалант хийдийг Өндөр Гэгээн Занабазарт зориулан байгуулжээ. (Гандантэгчэнлин хийдийн шашны их сургуулийг энэ их хутагтын нэрээр нэрлэсэн байдаг). Хийдийн барилгын ажил 1726 онд эхэлснээс хойш арван жилийн дараа дуусчээ. 1930-аад оны хэлмэгдүүлэлтээр энэ хийдийн бүх дээд лам нарыг егүүтгэсэн бөгөөд хадгалагдаж байсан ховор нандин лагшингийн шүтээнүүд болон судруудыг үгүй болгосон байна. Нуранги болсон энэ хийдийн сэргээн босголтын ажлыг 1990 онд эхлүүлсэн байдаг.

## **6. Хамарын хийд**

Дорноговь аймгийн нутгийн зүүн хэсэгт орших Хамарын хийд нь байгаль орчныг хамгаалах салбарт санаачлагатай ажиллаж байгаа бөгөөд Таван дохио ТББ-тай хамтран говийг моджуулах төслийг хэрэгжүүлсэн. Орос цэргүүдийн сүйтгэсэн хайлаас модны төгөлд 100 суулгац тарьсан нь ажлынх нь гараа байв. 2003 оноос хойш орон нутгийн сургуулийн хүүхдүүдийн туслалцаатайгаар Хамарын хийдэд олон зуун мод суулгасан боловч усны асуудал, мал, салхи шуурганаас сайн хамгаалж чадаагүй, модны сонголтоо буруу хийсэн болон мод суулгах арга технологи нь буруу байсан зэргээс шалтгаалан олон зуун мод амьдарч чадаагүй аж. Гэсэн хэдий ч нутгийн байгаль хамгаалах төслийн удирдагч бөгөөд Хамарын хийд музейн захирал Алтангэрэл “Олон удаа суулгаж байж мод суулгах туршлага хуримтлуулна. Мод ургуулж цөлжилтийн эсрэг тэмцэнэ. Модны үндэс хөрсөн дор ус чийг татан усны хуримтлал бий болгоно гэж итгэж байгаа” хэмээн ярьж байлаа.

Дараагийн удаа мод тарих тухайн газрын хөрсийг хүн, машины хөлд сүйтгэгдэхээс сэргийлсэн хашаа босгохоор төлөвлөжээ. Байгаль хамгаалахад бурханы шашны зан үйлийг ашиглах хэрэгтэй гэж Алтангэрэл ярьдаг бөгөөд тэрээр нас барсан хүмүүсийн дурсгалд зориулан мод тарьдаг уламжлалыг бий болгохоор хөөцөлдөж байгаа ажээ. Түүнчлэн олон улсын Месеор ТББ-тай хамтран 25'000 евроны төсвөөр Хамарын хийд дээр хүүхдийн цэцэрлэг болон орон нутгийнханд зориулсан мэдээллийн төв мөн бичиг үсэг тайлагдаагүй насанд хүрэгчид болон сургуулиас завсардсан хүүхдүүдэд зориулсан албан бус сургалтын төвийг барьж байна.

### **Хамарын хийдийн түүхээс**

1820 оны үед Монголын нэрт соён гэгээрүүлэгч, зохиолч, Говийн догшин ноён хутагт Данзанравжаа энэ хийдийг байгуулжээ. Тэрээр энгийн ард олны боловсролыг дээшлүүлэх үйлст өөрийн амьдрал хөдөлмөрөө зориулж байсан бөгөөд уг хийд дээр сургууль, театр, музей, номын сан зэргийг байгуулан соён гэгээрүүлэх ажилд үнэтэй хувь нэмэр оруулж байв. Тухайн үедээ Хамарын хийд 4 дацан, 1 хүүхдийн дацан, 80 гаруй сүм, 500 гаруй лам хуврагтай байсан гэдэг. Данзанравжаагийн нөлөөгөөр эмэгтэйчүүдэд аливаа үйл ажиллагаанд оролцох боломж нээгдсэн байна. Хийдийн хойно хэд хэдэн агуй байх ба энэ агуйнуудад лам хуврагууд 108 хоногийн бүтээл бясалгалд суудаг байжээ. Хамарын хийд нь Улаан малгайтны ёсны чухал төв бөгөөд энэ хийдэд Говийн догшин ноён хутагт Данзанравжаа суурин заларч байсан юм. 1938 онд эл хийд бүрэн устсан ч 1990 оны үед дахин сэргээгдсэн. Хийдийн ойролцоо аливаа өвчнийг анагаах увидастай рашааны худаг байх бөгөөд Данзанравжаа өөрийн зохиосон “Адистит ёсны судар”-таа энэ рашааныг ходоод, нарийн гэдэс, цөс, элэгний өвчнийг анагаах увидастайг тэмдэглээд хэрэглэх зааварчилгааг нь мөн өгсөн байна.

## **7. Лувсанданзанжанцан Судлалын Төв**

Монгол орны өмнөд хэсэгт орших Баянхонгор аймагт байршилтай уг төв нь хутагт, эрдэмтэн Ханчэн Чойжил Лувсанданзанжанцангийн (1639-1704) зохиол бүтээлийг олны хүртээл болгох, шашин номын болон байгаль орчныг хамгаалах зэрэг үйл ажлуудыг явуулдаг. Энэ төв нь сүм хийдийн тэргүүд, эрдэмтэд, шинжлэх ухаанчдыг уулзалддаг газар болсон юм.

### **а. Лобби**

Лувсанданзанжанцан судлалын төв нь байгаль орчныг хамгаалах, сурталчилах тал дээр бат бөх байр суурьтай явсаар ирсэн. 1990 оноос эхлэн орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийг амжилттай лоббидсоны үр дүнд аймгийн онгон дагшин тахилгат газруудыг тогтоолгуулж, тухайн газруудад ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж байсан компаниудын үйл ажиллагааг зогсоолгуулсан байна. 2005 онд онгон дагшин газар үйл ажиллагаагаа явуулж байсан гурван компани ажиллагаагаа зогсоосон бол дахин гурван компани удахгүй үйл ажиллагаагаа зогсоохоор болжээ. Өнөөдрийн байдлаар ашигт малтмалын лиценз авсан 100 орчим компанитай энэ төв тэмцэж байгаагийн зэрэгцээ байгаль орчныг хамгаалахын тулд ашигт малтмалын хуулийг дахин хянуулахаар ажиллаж байна.

2006 онд Азийн Сантай хамтран зохион байгуулсан хурлын үед байгуулагдсан Нутаг усаа хамгаалах эвслийг төвийн тэргүүн Д. Батболд тэргүүлдэг бөгөөд үүнд 14 хөдөлгөөн нэгдээд байгаа ажээ. Энэ хурлаас хойш Баянхонгор аймгийн иргэд ашигт малтмалын үйл ажиллагааг багасгах талаар идэвхтэй ажилласан бөгөөд олборлолт хийж байгаа компаниудын эсрэг удаа дараалсан үйл ажиллагаа явуулсан аж. “Бид нутгийн иргэдийн байгаль орчны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг хуулиар олгогдсон эрхээ эдлэхэд нь анхаарлаа хандуулдаг. Мэдлэгтэй хүмүүс аливааг амархан ойлгох бөгөөд тэднийг няцаах хэцүү.” гэж Батболд тайлбарлаж байв. Эдгээр хөдөлгөөнүүдийн явуулсан үйл ажиллагааны үр дүнд энэ бүс нутагт олборлолт хийж байгаа компаниуд байгаль орчны тал дээр анхаарал тавих болжээ. Жишээлбэл: байгаль орчны нөхөн сэргээлтийн хүрээнд олборлолт хийгдсэн газруудад чацарганы мод тарьж байна.

### **6. Онгон дагшин газрууд**

Энэ төвөөс уламжлалт байгаль хамгаалах ухааныг сэргээх, тахилгат газруудын тахилгын ёсыг сэргээх ажлыг дэмждэг. Гурван жилийн дотор эндхийн лам хуврагууд Төвд, Монгол хэл дээр бичигдсэн “Баянхонгор нутгийн лус савдагийг тахиx тахилгын судрууд” хэмээх номыг эмхэтгэн ард олны хүртээл болгосон. Эдүгээ эл төвөөс тахилгат уул хайрханд зориулсан хэд хэдэн сүмийг барьж байгуулахаар барилгын ажлаа эхлүүлээд байгаа аж.

### **с. Мод, хүнсний ногоо**

2004 онд энэ төвөөс өнгөрсөн арван жилийн хугацаанд тал хувь нь сүйдсэн Түйн голын уд модны төглийг сэргээх ажлыг гүйцэтгэжээ. Япон улсын Ойта Префектур судалгааны төвтэй хамтран орон нутгийнханд ашигт малтмалаас өөр орлогын эх үүсвэрийг бий болгохын тухайтад чихрийн хүрэн манжин тариалсан. 2002 оноос өнөөг хүртэл ADRA-тай хамтран эрүүл хүнсний төслийг хэрэгжүүлж байна. Моджуулалт 20 хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор аймгийн захиргааны албатай хамтран 2003 оноос өнөөг хүртэл 85'000 мод суулгаад байна.

### **Харилцах хаяг**

bayangreen@yahoo.com. Утас: +976-99449889

## **8. Гандандаржаалин хийд**

Тус хийд нь Монголын алс хязгаар Хан Хөхийд орших багахан хийд бөгөөд анх 1818 онд байгуулагдсан. Хожим 1990 онд дахин сэргээгдсэн бол өнөөгийн байдлаар 17 лам энэ хийдэд шавилан сууж байна. Орчны рашаан усны чанарыг шинжлүүлэх төсөл дээр ARC-аас дэмжлэг авсан. Орон нутгийн онгон дагшин газруудыг нэрлэвэл Хан Хөхийн овоо, Цагаан нуурын овоо, Хосын овоо, Тахилтын овоо, Дэлгэрийн овоо, Модтолгойн овоо, Гичгийн овоо, Хангилцагийн гол эдгээр болно.

ARC/WWF-ийн Хан Хөхийн байгаль хамгаалах төслийн хүрээнд орон нутагт мод бэлтгэх ажлыг багасган түлшний өөр эх сурвалжийг бий болгох ажлыг гүйцэтгэсэн байна. Уг төслийн хүрээнд энэ алс хязгаарлагдмал нутагт үйл ажиллагаагаа явуулж

байгаа сүм хийдүүдийн дэмжлэгээр бурханы шашны лам хуврагууд болон энгийн ардад зориулсан экологийн сургалт зохион байгуулсан юм.

**Харилцах хаяг:**

Утас: +976-014541260

**9. Гандан Шаддүвлин хийд**

Орхон аймагт орших энэ хийдийн ойролцоо зэс молибдений үндсэн орд байдаг бөгөөд лам нарын үзэж байгаагаар бол уурхайгаас ялгарах бохирдлын улмаас энэ нутагт төрөлхийн зүрхний согогтой хүүхдийн төрөлт өндөр хувьтай байгаа аж<sup>12</sup>. Энэ хийдийн лам хуврагууд бурханы шашны үндэсний байгаль хамгаалах хөтөлбөрт оролцох хүсэлтэй байдаг байна.

**10. Сэлэнгэ аймгийн хийд**

Энэ хийд жижиг шаталбартай мод тарих ажлыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ орон нутгийнханд байгаль хамгаалах арга ухааныг таниулж байна. “Хэрэв чи сонгино суулгавал сонгино хураан авна. Харин модоо огтловол модгүй болно.” гэж сургадаг хэмээн Сэлэнгэ аймгийн ловон лам Дондүв хэлж байлаа. Энэ хийдийн лам нар цэцэг тарьдаг бөгөөд “Зовлонтой хүмүүс сайхан цэцэг хараад зовлонгоо түр ч гэсэн мартдаг юм.” гэж тэрээр өгүүлэв.

## **ГУТГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГУУД**

---

Олон улсын болон Монголын хөгжлийн ба байгаль орчны байгууллагууд бурханы шашны болон бусад байгаль орчны байгууллагуудтай уялдаатай ажилласан нь

### **1. Дэлхийн Банк**

Дэлхийн Банкнаас орон даяар байгаль орчны болон хөгжлийн хүрээнд шашны байгууллагуудтай хамтран төсөл хэрэгжүүлж, дэмжлэг туслалцаа үзүүлсээр ирсэн. 2006 онд хэвлүүлсэн “Шашин ба Байгаль Орчин” гэдэг номондоо яагаад шашны байгууллагуудтай хамтран ажиллах болсноо тайлбарлахдаа “Иргэний нийгмийн үүрэг нь байгаль орчин ба хөгжлийн хөтөлбөрийн үндсэн сүлжээ болохыг бид улам бүр мэдэрч байна. Шашны болон шашны суурьтай байгууллагуудад ямар их чадамж байгааг хангалттай нээгээгүй байна. Дэлхийн аль ч хэсэгт шашны байгууллагууд иргэний нийгмийн ямар ч элементүүдээс илүү өргөн сүлжээтэй байдаг бөгөөд зуунаас зуунд дамжсан дадлага туршлагатай тул аливаа орны боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн бүтэц болон боловсон хүчний асуудлыг тогтвортой шийдсээр ирсэн байдаг. Улс төрийн намуудыг бодвол илүү олон дагалдагсадтай бөгөөд нийгмийн бүхий л салбарыг хамаардаг. Шашны байгууллагууд бол хамгийн эртний, хамгийн өргөн, хамгийн их хүндлэгдсэн, нийгмийн хамгийн гүнд нэвтэрсэн төрийн бус байгууллагууд мөн билээ. Хэдийгээр зарим үед ил гарч ирж байгаагүй ч байгаль орчны ухаалаг менежментийг хөгжүүлэх тал дээр бидэнтэй нэг байр суурьтай байдаг. Байгаль хамгаалах салбарт шашны бүлгүүдийн хүчирхэг дуу хоолойг оролцуулах бүрэн чадамж бий гэж үзэж байна.” гэв.

Өнөөдөр ой, усны нөөц, байгалийн бохирдол, цэвэр усны хомсдол зэрэг нь Монгол орны тулгамдсан асуудлууд болоод байна. Дэлхийн Банкнаас Хотын Үйлчилгээг Сайжруулах Төсөл 1-ийн хүрээнд усны хангамжийн сүлжээг өргөтгөх, Улаанбаатар хотын амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхүүд болон гэр хорооллынхны эрүүл мэндийг сайжруулах зэрэгт туслалцаа үзүүлсэн бөгөөд өнөөгийн байдлаар энэ төсөл хоёр дахь шатандаа хэрэгжиж байна. Мөн GEF-ийн санхүүжилтээр түлшний хэмнэлттэй зуухны төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн. Түүнчлэн Хөвсгөл нуурын хойд хэсэгт цаг уурын өөрчлөлт, мал сүрэг, биологийн олон төрөл зүйлийн мөхөл зэргийн хоорондын харилцан нөлөөллийг шинжлэх зорилгоор 5 жилийн хугацаатай судалгааны ажил хийж байгаагийн дээр 12 жилийн хугацаанд хэрэгжих Тогтвортой амьжиргаа төслийг бүх аймагт хэрэгжүүлж эхлээд байна. Эдүгээ Дэлхийн Банкнаас хэрэгжүүлэх гэж буй ой модны болон Улаанбаатар хотын бохирын усны төслүүд нь бэлтгэлийн шатандаа явагдаж байгаа болно.

### **Нидерланд Монголын Хамтарсан Байгаль Орчны Реформын Итгэмжлэлийн Сан (NEMO)**

2005 оны 4 сард Нидерландын засгийн газраас Монгол улсын байгаль орчин, ашигт малтмалын талаар хэлэлцэх асуудлыг чадавхжуулан хөгжүүлэх зорилгоор Дэлхийн Банканд оруулсан 6 сая ам долларын тэтгэлгээр уг санг байгуулжээ. Анхны үе шат нь 2006 оны 9 сард амжилттай хэрэгжиж дуусвар болсон бол 2007

онд төслийг хоёр дахь шатыг нэмэлт 5 сая ам долларын сантайгаар дараагийн дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр тогтсон байна. Монголын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам (2008 оны дунд үеэс эхлэн жуулчлалыг хамаарах болжээ), Бээжин дэх Нидерландын Элчин Сайдын Яам, Нидерландын Хөгжлийн Хамтын Ажиллагааны Яам болон Дэлхийн Банкнаас 2007-2010 оны хооронд хэрэгжүүлэх NEMO 2 сангийн үйл ажиллагаагаар ашигт малтмалын менежмент, бохирдлын менежмент болон байгаль орчны засаглал дээр гол анхаарлаа хандуулан ажиллахаар тогтсон байна.

NEMO сан нь байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ихэнх нэгж, агентлаг, ТББ-үүд болон нутаг орны ихэнхтэй хамтран ажилласан. Мөн ашигт малтмалын менежментийн суурь үзүүлэлтийг бий болгож, байгаль орчны асуудлыг үндэсний хэмжээнд гаргаж тавин, орон нутгийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн бага болон дунд хэмжээний байгаль орчны үйл ажиллагааг санхүүжүүлж байв. Энэ сангийн бас нэг зорилго нь Гандантэгчэнлин хийд дээр байгуулсан эко-гэр болон онгон дагшин газар нутгийн байгаль орчны менежментэд оруулж буй хувь нэмэр зэрэг боловсрол, танин мэдэхүйгээр дамжуулан байгаль орчны менежментэд лам хуврагуудын оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Энэхүү гарын авлага эдгээр үйл ажиллагааны нэг хэсэг нь билээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг [www.worldbank.org/nemo](http://www.worldbank.org/nemo) гэсэн цахим хуудасны Дэлхийн Банк Монголын бурханы шашинтнуудтай хамтран ажиллаж байгаа нь гэсэн хэсгээс үзнэ үү.

### **Дэлхийн Банк Монголын бурханы шашинтнуудтай хамтран ажилласан нь**

Шашин бол ихэнх хүмүүст хүрдэг хамгийн үр дүнтэй хэлбэр болохоор Дэлхийн Банкнаас хүндэтгэлтэй ханддаг гэж тус банкны дэд бүтцийн ажилтан өдгөө тус банкны санхүүгийн корпорацид ажиллаж байгаа О.Санжаасүрэн хэлжээ. Бурханы шашин нь Монголын уламжлалт шашин болохоор Дэлхийн Банкнаас байгаль орчныг хамгаалах, байгаль орчны тухай ойлголтыг хүмүүст өгөх болон хөгжлийн ба байгаль орчны төслийг хэрэгжүүлэхэд бодит дууриал болдог. Тус банкнаас ARC, WWF болон Гандантэгчэнлин хийдтэй хамтран доорх төслүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Монгол орны онгон дагшин газруудыг хамгаалах төслийн хүрээнд Монгол хэл дээр эмхтгэн хэвлүүлсэн цуврал номыг бурханы шашны сүм хийдүүдэд түгээсэн. Дэлгэрэнгүйг ном зүйгээс үзнэ үү.
- Зургаан онгон дагшин газарт чулуун хөшөө босгосон бөгөөд уг төслийг ARC, WWF-аас хэрэгжүүлсэн. Энэ ажиллагаагаар орон нутгийн ард олонд дээрх газар нутгуудыг онгон дагшин тахилгатай болохыг таниулсан. Байгаль орчныг сүсэг бишрэлээр дамжуулан хамгаалах нь төрийн хууль тогтоомжоос илүү үр дүнтэй арга болох нь энэ мэт олон баримтаар батлагдаж байв.

• Хөвсгөл Нуурийн Судалгааны Төсөл нь 5 жилийн хугацаатай хэрэгжих GEF-ийн дунд хэмжээний төсөл бөгөөд үүнийг Монголын Шинжлэх Ухааны Академийн Гео-экологийн Хүрээлэн гүйцэтгэж байна. Бэлчээрийн ашиглалт, ой мод огтолсны улмаас үүдэн гарсан биологийн олон төрлийн мөхөл, ой, тал хээр, гол горхины динамик нөлөөг судалж байгаа аж. Уг судалгааны зорилго нь Хөвсгөл нуурыг болон ижил төстэй бусад ой, тал хээрийн бүсийг хэрхэн хамгаалж болох арга замыг олж тогтооход чиглэж байна. Гандантэгчэнлин хийдээс Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Монголын Бурханы Шашны Их Сургуультай хамтран уул усны лус савдаг ба тэдгээрийн тахилгын зан үйл, түүнчлэн байгаль хамгаалах уламжлалт зан үйл ба түүний ач холбогдлын талаар тайлбарласан номыг малчдад зориулан хэвлүүлсэн. Тус хийд болон шашны их сургуулиас очсон лам хуврагууд орон нутгийн лус савдагийг аргадан тахисан хурал ном хурсан нь орон нутгийн лам хуврагуудыг уламжлалт тахилгын ёсыг сэргээхэд ихээхэн дэмжлэг болжээ. Хөвсгөл нуур бол Монголын хамгийн том нуур бөгөөд дэлхийн цэнгэг уст нууруудын нэг нь юм. Эл нуур нутгийн хойд хэсэгт оршдог бөгөөд Сибирийн тайгын үргэлжлэл, бэлчээрт хөндий, мөнх цаст уулсаар хүрээлэгдсэн. 1992 онд үндэсний цэцэрлэгт хүрээлэн болгосон бол эдүгээ UNESCO-гийн дэлхийн өвд нэрийг нь дэвшүүлээд байна.

• 2005 оны Байгаль, Экологи ба Хөгжил сэдэвт хойд бүсийн бурханы шашинтнуудын бага хурал. Тэргүүн бүлгийн гуравдугээр хэсгээс үзнэ үү.

• Улаанбаатар хотын дагшин газар: Энэ хөтөлбөр нь Гандантэгчэнлин хийд, Тасганы овоо болон Гэсэр сүмийн хооронд орших дагшин газрын асуудал дээр анхаарлаа хандуулж байна. Байгаль орчны боловсрол, байгаль хамгаалах менежментийн сургалтанд лам хуврагуудыг хамруулж, байгаль орчны талаарх ухамсрыг нийгмийн бүх салбарт хүргэх ажлийг тэдэнд өгсөн юм.

• Энэхүү шашин ба байгаль орчны тухай гарын авлагыг Монголын Байгаль Орчны Яам болон Дэлхийн Банктай хийсэн гэрээний дагуу ARC-аас эмхтгэн гаргасан.

### **Харилцах хаяг**

Сөүлийн гудамж - 4, MCS Плаза 5, Дэлхийн Банк. Улаанбаатар-210644. Харилцах хүн: Жамбын Сүнжидмаа. Утас: +976-11-312-647; гарц 207. Факс: +976-11-312-645 Цахим хаяг: [sjamba@worldbank.org](mailto:sjamba@worldbank.org)

## **2. Шашин ба Байгаль Хамгаалах Холбоо (ARC)**

Дэлхийн гол шашны байгууллагуудыг сургаал номлол, итгэл үнэмшил, зан үйлээрээ дамжуулан байгаль хамгаалах хөтөлбөр хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой байгуулагдсан шашны бус байгууллага бөгөөд тэдний үйл ажиллагааг байгаль орчны үндсэн байгууллагуудтай холбож тусалдаг. Мөн шашны байгууллагуудыг нөөц боллоцоогоо ашиглан хэрэгтэй төсөл хэрэгжүүлэхэд дэмжиж ажилладаг. Төрийн бус байгууллага, олон улсын агентлаг болон засгийн газраас шашны байгууллагатай хамтран байгаль хамгаалах салбарт ажиллахад нь дэмжлэг үзүүлдэг.

Сүр жавхлантай хунтайж Филиппин үүсгэн байгуулсан энэ холбоо арав гаран жил WWF-ийн далбаан дор үйл ажиллагаагаа явуулж байсан бол 1995 онд бие даасан хүмүүнлэгийн байгууллагын статустай болжээ. Өнөөгийн байдлаар энэ холбоо Бахай, Буддизм, Христ, Дао, Хинди, Ислам, Жейн, Иудайзм, Шинто, Сикхизм, Зороастрианизм зэрэг 11 шашны олон урсгалтай хамтран ажиллаж байна.

1996 оноос эхлэн Монголд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Гандантэгчэнлин хийд болон өөр олон сүм хийдүүдтэй харилцаатай байдаг. Монгол улсын ерөнхийлөгч Н. Энхбаяр нь ARC-ийн олон улсын ерөнхийлөгчөөр ажиллаж байв. 2000 оноос эхлэн Дэлхийн Банктай хамтран шашны болон биологийн олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлж байна. Эдгээр төслийн талаарх мэдээллийг [www.worldbank.org/faithsandenvironment](http://www.worldbank.org/faithsandenvironment) гэсэн хаягаар орж үзэж болно.

Дэлхийн Банкны хэсэгт ARC-ийн төслүүдээс мөн дурьдсан болно.

### **1. Алдагдсан судрыг хэвлүүлэх төсөл**

Ингээд ARC—аас дэвшүүлж байгаа энэхүү маш өндөр ач холбогдолтой гэж хэлж болохоор чухал санаачлагыг дэмжих боломж олдсонд би туйлын баярлаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд энэ санаачлага дэлхий ертөнц дээрх сайн сайхан амьдралын баталгаа болно гэдэгт итгэлтэй байна.

ХУН ТАЙЖ, ФИЛИПП

## **ARC-UN-ний найман жилийн төлөвлөгөөний танилцуулга**

Шашин ба Байгаль хамгаалах Холбоо (цаашид ARC гэх) нь Английн нэгдсэн вант улсад төвтэй олон улсын байгууллага бөгөөд Эдинбургийн гүн, Эрхэм дээдэс хунтайж Филиппийн санаачлагаар 1995 онд байгуулагдсан юм. ARC нь дэлхийн томоохон шашнуудад өөрсдийн гол номлол, итгэл үнэмшил болон зан заншилд тулгуурлан байгаль орчныг хамгаалах төсөл хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүдэг биеэ даасан байгууллага билээ. Энэхүү байгууллага нь өнөөдөр Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран дэлхийн цаг уурын өөрчлөлтийг саармагжуулах болон байгаль орчныг хамгаалах үйлсэд дэлхийн томоохон шашнуудыг татан оролцуулах зорилгоор НАЙМАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ боловсруулах ажлыг эхлүүлж байна. Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл та манай [www.arcworld.org](http://www.arcworld.org) хаягаар зочилно уу.

### **Дэлхий дахины өмнө тулгарч буй хамгийн том бэрхшээлүүдийг хөндөх нь**

Цаг уурын өөрчлөлт, байгалийн тэнцвэр, хүн байгалийн шүтэлцээ алдагдаж байгаа нь дэлхий дээр амьдарч буй бүхий л амьд биетийн өмнө тулгараад байгаа хамгийн том бэрхшээл болж байна. Өөрөөр хэлбэл, дээрх асуудлууд нь аливаа нийгмийн бүлгүүдээр хязгаарлагдах бус дэлхийн бүх улс орон, ард түмнүүдийн амьдралын эх булагт заналхийлж, байгалийн өөрийн гайхамшигт зүй тогтолыг үгүй хийж байна. Энэ нь олон хүнд айдас, ирээдүйдээ үл итгэх явдлыг бий болгож байгаа билээ. Тийм ч учраас дэлхийн томоохон шашнууд байгаль хамгаалах үйлсэд өөрсдийн мэргэн ухаан, зөн билэг, итгэл найдвар, сүсэгтэн олныхоо хүчээр тэргүүлэх байдлаар оролцох цаг нь нэгэнт ирсэн хэмээн бид үзэж байна. Дэлхий нийтийн өмнө тулгамдаад буй асуудлуудад илүү үр дүнтэй, бүтээлч байдлаар хандаж, бодит практикт суурилсан хөтөлбөр, бүтээлч загваруудыг бий болгоход туслах зорилгоор бид сүсэгтэн олонд зориулсан цуврал гарын авлага (заавар)-ыг боловсруулсан юм.

### **“Үе дамжсан өөрчлөлт” гэж юу вэ?**

Энэхүү хөтөлбөрийн гол амин зорилго нь бидний ирээдүй хойч үе төдийгүй тэдгээрийн үр удам ч ажил хэрэг болгон хэрэгжүүлж улмаар ашиг тус, хувь нэмрийг нь хүртэж байхаар өөрчлөлтийг бий болгоход чиглэсэн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАЙМАН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ боловсруулахад тань туслах явдал юм. Хүмүүний зан үйл өөрчлөгдтөл олон зуун үе өнгөрөх шаардлагатай байдаг. Мэдээж улс түмэн дамжсан томоохон өөрчлөлтүүд түүхийн хуудаснаа тэмдэглэгдэн үлддэг ч аливаа хувьсал өөрчлөлтүүд бий болох урьтал нөхцөл нь ямагт шашны үзэл санаа, шашны зан үйлтэй салшгүй холбоотой байдаг. Бүхий л шашнууд нь мэргэн ухааныг түгэн дэлгэрүүлж, үүгээрээ өв уламжлалыг хүндэтгэх сэтгэлгээг ард түмний дунд бий болгож байдаг. Энэхүү өв уламжлалаас шашнууд нь одоо байгаа зүйлсдээ дүгнэлт хийж, ирээдүйн төлөвөө тодорхойлдог билээ. Хүн төрлөхтөний түүхэн замнал, өв уламжлалаас харахад бид урьд өмнө ч гэсэн ийм экологийн хямралтай тулгарч байсан ба энэ хүнд байдлыг:

- Нэгдүгээрт, бид байгаа орчиндоо дасан зохицох,
- Хоёрдугаарт, мартагдсан эсхүүл үгүйсгэсэн сургааль, номлол, мөн чанарыг сэргээх,
- Гуравдугаарт, тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх шинэ арга замуудыг бий болгох замаар туулж байсан түүх байдаг.

Тухайлбал, Камбожид олон жилийн турш өрнөсөн иргэний дайны хөлд нэрвэгдсэн камбожийн нийгэм, эдийн засаг, байгаль экологийн сүйрлийг даван туулахад бурханы шашны нөлөө хамгийн их байсан гэж үздэг бөгөөд тийм ч учраас энэ шашин одоо хир нь Камбожийн тэргүүлэх шашны нэг байсаар байгаа юм.

## I. Найман жилийн төлөвлөгөөний хамрах гол 7 асуудал

Эдгээр 7 асуудал нь энэхүү зааврын гол цөм нь билээ. Энэ бол та асуултанд хариулаад хариуг нь бидэнд явуулдаг санал асуулга биш юм. Энэ нь та сүсэгтэн олон, шашны болон бусад байгууллагуудтай хамтран өөрсдийн нөөц бололцоо, уламжлал, итгэл үнэмшилдээ тулгуурлан ямар өөрчлөлтийг хэрхэн хийх талаар шийдвэр гаргахад тань туслах сэдвүүдийн жагсаалт юм.

Дараа дараачийн хуудсуудад бид таны анхаарлаа хандуулбал зохих асуудлуудыг бодит түүх, жишээнүүдийн хамт танд хүргэх болно.

1. Шашин ба үл хөдлөх хөрөнгө- газар, хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн байгууллагууд, үл хөдлөх хөрөнгө худалдан авах
2. Боловсрол ба залуучууд- сургуулийн барилга, байгууламж болон хичээлийн хөтөлбөр, байгаль орчны чиглэлийн сургалтууд, зуслангууд
3. Номлол- онолын мэдлэг болон сургалт, өв уламжлал, амьдралын ухааныг сэргээх, цаг уурын өөрчлөлт хурдацтай явагдаж байгаа бүс нутгуудын ард иргэдэд туслах арга
4. Амьдралын хэв маяг
5. Хэвлэл мэдээлэл ба сурталчилгаа
6. Нөхөрлөл, eco-twinning (ижил төстэй экологийн асуудлуудтай тулгараад буй бүс нутгуудыг хооронд нь холбох), байгаль хамгаалах албуудыг / төв /байгуулах
7. Тэмдэглэлт баяр ёслолууд

### 1. Шашин ба үл хөдлөх хөрөнгө

#### А) Бүтээн байгуулалт болон одоо оршин байгаа барилгууд

Та урьд өмнө нь барьж байгуулсан барилга, цаашид барих гэж буй барилга байгууламж тань байгаль орчинд хэрхэн нөлөөлж буй тухай бодож үзсэн үү? Тухайлбал: таны барих гэж байгаа шинэ барилгын байгаль орчинд нөлөөлөх байдлыг ямар хэмжээнд үнэлсэн бэ? Гол тулгарч буй экологийн асуудлууд нь юу вэ, та тэдгээрийг шийдвэрлэх гарцыг олсон уу?

Эрт дээр үеэс Монгол оронд сүм хийдүүдийг зуны ангам халуун, өвлийн хахир хүйтнийг тэсвэрлэх чадвартай материалуудаар барьдаг байсан билээ. Харин бетон нь дээрх байгалийн нөхцөлд таарахгүй. Тиймээс Монгол оронд сүм хийдүүдийг барьж байгуулах болон сэргээн засварлахдаа уламжлалт арга ухааныг ашиглах шаардлагатай бөгөөд энэ аргаар ч хүмүүс өөрсдийн сууц, байшин барилгыг барих нь хамгийн дөхөм, амьдралд нийцсэн шийдэл юм.

Хятадын Дао шашны сүм хийдүүд захиргааныхаа байшингийн дээвэр дээр нарны цахилгаан үүсгүүр байрлуулснаараа байгалийн нөөцийг хэмнээд зогсохгүй өөрсдийн шашны үзэл баримтлалыг мөрдөх боломж бий болсон байна. 2006 онд ARC нь хэд хэдэн сүм хийдүүдэд байгаль орчныг хамгаалахад чиглэсэн анхны хурлаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн юм. Энэ хуралд оролцсон нийт 10 хийдүүдийн бараг хагас нь дараа жил гэхэд бүгд өөрсдийн хөрөнгөөр нарны цахилгаан үүсгүүртэй болсон байсан юм. Мөн түүнчлэн, Шаанси мужын ард иргэд Тайбайшан дахь шинэ экологийн (лусын) сүмээ нутгийнхаа байгалийн гаралтай материалаар барьцаасан юм.

### **Б) Газар ба ой мод**

Та өөрийнхөө эзэмшдэг бэлчээрийн газар эсхүүл ой мод, уурхайгаа ямар замаар ашиглавал байгаль орчинд хор нөлөөгүй байх талаар бодож үзэж байв уу? Газрын хэвлий, хөрсний талаар бурханы шашинд юу гэж сургасан байдаг талаар та мэдэх үү?

Солан нь Францын Рхон хөндий дэх 15 үнэн алдартаны шашинт гэлэнмаа нарын нийгэмлэг билээ. Тэд өөрсдийн хийдээ эзэнгүй хаягдсан фермийн байгууламж дээр байгуулсан бөгөөд, 1991 оноос хойш тэд уг газартаа органик ферм байгуулан, органик аргаар гаргаж авсан дарс, чангаанзны чанамал хийж, туулайн бөөр болон инжрийн мод тариалж байна. Орон нутгын удирдлага нь тэдний ойг мод бэлтгэх зорилгоор тайран авч, шинэ мод тарин гучин жил гар хүргэлгүй орхино гээд 75 хувийн нөхөн олговор тэдэнд санал болгосон байна. Гэхдээ тэд үүнийг зөвшөөрсөнгүй. Үүний оронд ой хамгаалагч нь унагах шаардлагатай гэж үзсэн модоо өөрөө сонгож тайрч байсан ба оронд нь 5000 зулзаган модыг гараар суулгажээ. Энэ бүхний үр дүнд гэлэнмаа нар сүмдээ орлого бүрдүүлэх эх үүсвэртэй болсон төдийгүй тухайн газрын амьд байгалийн унаган төрх хэвээр хадгалагдаж чадсан бөгөөд сүмийн ойр орчим ариун дагшин хэвээр үлдсэн юм. Удаан маргалдсаны эцэст тухайн орон нутгийн удирдлага модыг гараар суулгах ажилыг дэмжсэн ба газрын эзэд ч гэсэн бодит байдлаар батлагдсан ойн аж ахуйн шинэ загварыг мөрдөх болсон билээ.

### **В) Ус**

Та Бурханы шашин цэвэр тунгалаг усны тухай юу гэж сургадаг талаар мэдэх үү? Та энэхүү сургаалийг мөрдлөгө болгон байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй усжуулалт, цэвэршүүлэлт, усан сан байгуулах, цэцэрлэгжүүлэлт, муу ус гадагшлуулах систем зэргийг дэмжих боломжийн талаар мэдэх үү? Танай сүм хийдийн ойролцоо урсдаг гол горхи байдаг уу? Та тэдгээрийг хэр зэрэг бохирдсоныг шалгаж үзсэн үү, хэрвээ тийм бол та бохирдлыг бууруулах ямар нэгэн арга хэмжээ авсан үү?

Саяхан Энэтхэгийн Банглор дахь “Нутгийн уламжлалт анагаах ухааныг дахин сэргээх” сан нь зэс саванд ус хадгалах тухай Хинду Аюурведикийн сургаалийн мөн чанарыг судлахаар лабораторийн шинжилгээ явуулжээ. Судлаачид усыг зэс саванд хадгалсанаар e-coli бактер ердөө 12 цагийн дотор устдагийг олж тогтоосон байна. Жил бүр 4 сая гаруй таваас доош насны хүүхдүүд нь e-coli бактерийн халдвараас болж суулга өвчинөөр нас бардаг гэсэн тооцоо байдаг. Тэгвэл усыг ариутгах тухай эртний энэ сургааль олон хүмүүсийн амийг аврах боломжийг нээж байна.

### **Г) Эрүүл мэнд хамгааллын тогтолцоо**

Хэрвээ та клиник, эмнэлэг зэрэг эрүүл мэндийн байгууллагад ажилдаг болон удирддаг бол усны хэрэглээ, ариутгал, цэвэр байдал, хүнсний хангамж, барилга байгууламж, тээвэр, цахилгаан, хог хаягдлыг багасгах, материалуудыг дахин боловсруулах зэргээр байгаль орчныг хамгаалахад чиглэсэн байгаль орчныг хамгаалах тогтвортой төлөвлөгөөг боловсруулж байсан уу? Хэрвээ дээр асуудлуудыг шийдсэн бол манай дэлхийн агаар мандал төдийгүй өвчтөнүүдийн чинь эрүүл мэндэд ч шууд нөлөөлөх байсан бизээ. Таны өвчтөнүүд болон тэдгээрийг эргэн ирж байгаа хүмүүст өгч байгаа хоол хүнсний эх сурвалжын талаар сонирхож үзсэн үү? Та өөрийн орон нутагт байгалийнхаа зүй тогтлоор, ямар нэгэн хортон шавьж устгах бодис хэрэглэлгүй тарьж үргүүлсэн, боловсруулсан хүнсний ногооны хэрэглээ нэмэгдэж байгаа тухай мэдсэн үү?

### **Д) Хоол хүнс, үйлчилгээ, жижиглэнгийн худалдаа**

Дэлхий даяар шашны байгууллагууд нь зочид буудал, бэлэг дурсгалын дэлгүүрүүд, кафе болон ресторонуудыг ажиллуулдаг тохиолдол бий. Хурим, шинэ хүүхэд мэндлэх болон оршуулгын зан үйлүүдэд ихэнх тохиолдолд өгөөмөр бэлэг сэлт, их хэмжээний хоол бэлтгэх

шаардлага гардаг байна. Та Монгол дахь бурханы шашны сүм хийдүүдийн эргэн тойронд байрлах үйлчилгээ, жижиглэнгийн худалдааны газрууд нь ёс суртахууны болоод экологийн хувьд тааламжтай үйл ажиллагаа, сэргээгдэх эрчим хүч ашиглаж байгаа эсэхийг сонирхож үзэв үү? Органик хоол хүнсийг түлхүү хэрэглэх, үйлдвэрийн бүс чөлөөт фермийн аргаар гаргаж авсан өндөг хэрэглэхийг уриалах зэргээр шинэ шинэ өөрчлөлтүүдийг нэвтрүүлж болох юм.

Энэтхэгийн Керала мужийн Коттоям дахь Христийн шашинт эмэгтэйчүүдийн холбоо нь хотынхоо төвд хоолны цэг байгуулжээ. Энэ нь Коттоямд байгуулагдсан анхны байгалийн хийн түлшээр бэлтгэсэн бүтээгдэхүүн зардаг мухлаг байсан юм. Хэдийгээр уг мухлагыг босгоход харьцангуй үнэтэй буюу 40000 рингет (ойролцоогоор 1000 ам. доллар) орчим байсан ч гэсэн тэд энэхүү зардлаа түлш хэмнэснээр жилийн дотор нөхнө гэдэгтэй итгэлтэй байгаа бөгөөд бусад айл гэрүүд болон аж ахуйн нэгжүүд байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх арга замын талаар үлгэр дууриал болж байгаадаа баяртай байгаа билээ. Монголд сүм хийдүүд нь өөрсдийн оршин байгаа бүс нутагтаа үлгэр дууриал болохуйц, байгаль орчинд эерэгээр нөлөөлөх хоол эсхүүл хүнсний цэгүүдийг ажиллуулдаг үү?

### **Е) Санхүүгийн хөрөнгө оруулалт болон бичил санхүү**

Бичил санхүүгийн тухай санаачлага нь ядууст бага хүүтэй зээл олгодог болсоноороо сүүлийн 30 жилд нийгэмд эерэг өөрчлөлт авчрах гэсэн оролдлогуудаас хамгийн үр дүнтэй нь байж чадсан юм. Бичил санхүүгийн санаачлагыг эхлүүлэхэд тийм ч их мөнгө хөрөнгө орохгүй билээ. Бичил санхүү нь Монголд сүм хийдүүдийн хөхүүлэн дэмжиж болохоор санаачлага мөн гэж та бодож байна үү?

Нобелийн шагналт Мухаммед Юнүс нь анх хэсэг ядуу гар урчуудад 27 доллар зээлдүүлэхийн зэрэгцээ тэдэнд бусад банкнаас их хэмжээний зээл авахад нь сайн дураараа батлан даагч болсоноор Грамийн банкны суурийг тавьж байжээ. Өнөөдөр түүний үүсгэн байгуулсан Бангладеш дахь Грамийн банк нь 5.3 сая хүнд 5 орчим сая доллар зээлүүлээд байна. Энэ бүхэн түүний ядуу хүмүүс ч гэсэн найдвартай зээлдэгч, идэвхитэй хувиараа бизнес эрхлэгчид болж чадна гэсэн итгэл үнэмшил дээр суурилсан билээ. Екьюменикал сүмийн зээлийн фонд нь дэлхийн хоёрдугаар дайны дараа сүм хийдийг сэргээн засварлах зорилготойгоор Англид байгуулагдсан бөгөөд энэ нь сүүлдээ амьдрах эх үүсвэрийг бий болгоход чиглэгдсэн жижиг бизнесийг дэмжих зээлийн хөтөлбөр болон өргөжжээ. Өнөөдрийн байдлаар тэдний үйл ажиллагааны голлох чиглэл нь Африк, Ази-Номхон далай, Латин Америкийн болон Карибын бүс нутгууд дахь жижиг, нийгэмд чиглэсэн бизнесүүдэд болон экологийн фермийн бүтээгдэхүүн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй ус шүүх систем зэрэгт зээл олгох болсон байна. Дэлгэрэнгүй мэдээллийг [www.eclof.org](http://www.eclof.org) –оос үзнэ үү.

## **2. Боловсрол ба залуучууд**

Дэлхийн боловсролын байгууллагуудын 50 орчим хувийг шашны байгууллагууд үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулдаг юм.

### **А) Сургууль болон сургуулийн гаднах сургалтын хөтөлбөрүүд**

Сургалтын хөтөлбөртөө байгаль орчины талаар илүү өргөн, сүсэг бишрэлд суурилсан хичээлүүдийг нэвтрүүлэх боломж та бүхэнд хэр байдаг вэ? Танд сурагчдад ногоо тарихыг зааж сургах ногооны талбай байдаг уу, эсхүл бий болгох бололцоотой юу? Та хортон шавьж устгах бодис ашиглахгүйгээр ургуулсан ногоог хүнсэндээ хэрэглэхийн ач холбогдлыг хүмүүст таниулахаар хичээдэг үү? Та байгальд гаран шувууд, ургамлыг судлан, зургийг нь зурсанаар залуучуудад байгалийн сайхныг сайшаахад тусалдаг үү?

Эрдэнэ зуу хийдийн лам нар дархан цаазтай газраас мод унаган тухайн бүс нутгийнхаа ресторан, хоолны газруудад зардаг байсан ядуу айлын хүүхдүүдтэй ажиллах төсөлд оролцсон юм. Лам нар тэдгээр хүүхдүүд болон тэдний гэр бүлийнхэнд амьдрах ухааны хичээл заасан нь хэн бүхний хүлээж байснаас ч хамаагүй илүү үр дүнд хүрсэн юм. 2005 онд тавин мод бэлтгэгч хүүхдүүд 40 цагийн амьдрах ухааны хичээлд суун уламжлалт байгаль хамгаалах ухаан ба шашны мөн чанар, мөн түүнчлэн өөртөө итгэлтэй байх, шийдвэр гаргах, шинийг санаачлах хичээлүүдэд хамрагдсан байна. 2006 онд Эрдэнэ зуу хийд нь дахин тавин хүүхдэд зориулан хоёр дахь сургалтаа зохион байгуулаад зогсохгүй үг үйл ажиллагаанд хамрагдахыг хүссэн тэдний эцэг эхэд ч гэсэн зориулсан хөтөлбөрийг боловсруулан зааж эхэлжээ. Энэ нь мод огтлох явдлыг багасгаад зогсохгүй үг сургалтанд хамрагдсанаар сургуулиас завсардсан олон хүүхдүүд сургуульдаа эргэн орсон билээ. Мөн түүнчлэн энэ төслийн хүрээнд орон нутгийн цайны газрууд болон ресторонуудад түлшний бусад эх үүсвэрийг бий болгох талаар танилцуулах ажлыг зохион байгуулсан юм. Ол Хэлүвис бол Английн нэгдсэн вант улсын Сомэрсэт дэхь католик шашны сургууль юм. 2008 оны 4-дүгээр сард болсон “Дэлхийн өдрөөр” 7-13 насны сурагчдын бүтэн өдрийн хичээлийн хуваарь нь экологийн холбогдолтой үйл ажиллагаанд зориулагджээ. Үүнд сурагчдын хамт бараг 2 м өндөр шувууг уд модоор урлах уран бүтээлчийг урих, ойролцоох гол горхио цэвэрлэх, шавьжны амьдралын талаар хичээл орох, сонгино мэтийн байгалийн гаралтай зүйлсээр даавуунд будаг оруулах болон Буддын шашны хийморийн дарцагаас санаа авч байгаль орчинтой холбоотой залбирлаа бичсэн дарцаг хийсгэх зэрэг үйл ажиллагаанууд явагдсан байна. Энэ бүхэн сурагчид болон тэдний эцэг эхэд маш таалагдсан бөгөөд дараа жил дахин “Дэлхийн өдрийг” тэмдэглэх хүсэлт иржээ. Сүм хийдүүдээр дамжуулан Монголын сургуулиудад Дэлхийн өдрийг тэмдэглэж болох уу?

#### **Б) Сургуулийн барилга болон тоглоомын талбай**

Та боловсролын үйл ажиллагаа явуулдаг бол сургуулийн шинэ барилга, өргөтгөлүүд нь байгаль орчинд ээлтэй байж чадах уу? Мөн түүнчлэн тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүд нь хүрээлэн буй орчиндоо халгүй, хүүхэд багачуудын хэрэгцээг бүрэн хангаж чадаж байгаа талаар та өмнө нь бодож байсан уу? Та хяналт тавьж чаддаг уу?

#### **В) Хадгалалт ба дахин боловсруулалтын бодлого**

Та өөрийн боловсролын байгууллагын барилгуудад эрчим хүч, ус хэмнэх бодлого явуулдаг уу? Та цаас, хоол, муу ус зэрэг хаягдалаа хэрхэн зохицуулдаг вэ? Та цэвэрлэгээ хийх хөтөлбөр зохион байгуулдаг уу?

Их хөлгөний уламжлалыг хадгалах төвийнхэн лам хуврагууд болон болон Хөдөө аж ахуйн их сургуулийн оюутнуудтай хамтран цэвэрлэгээ хийх компани ажлыг хэд хэдэн удаа Улаанбаатар хотноо өрнүүлжээ. Лам нар хог цэвэрлэж олон нийтэд хүрээлэн буй орчиндоо анхаарал хандуулахын чухлыг биечлэн үзүүлэхийг харсан олон түмэн тэднийг гайхан бас сэтгэл нь хөдөлж байв.

#### **Г) Залуучуудын байгууллага болон зуслангууд**

Байгалийн үзэсгэлэнт газарт тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг хүүхэд залуучуудад зориулсан зуслан ажиллуулдаг эсхүүл гудамж талбай цэвэрлэх ажил зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа санаачлан зохион байгуулдаг шашны залуучуудын байгууллага байдаг уу?

2007 оны зун Английн Бирмингхэм хотыг Муслиман шашинтнууд “Цэвэрхэн Мэдина гудамж” нэртэй дуу хөгжим, видео, төрөл бүрийн мэдээлэл өгөх самбартай гудамжныхаа хогийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулжээ. Энэ үйл ажиллагаа нь бусад Муслиман шашинтнуудад үлгэр дууриал болоод зогсохгүй Монголын хотуудад

цэвэрлэгээ хийхийг сонирхолтой хөтөлбөр болгох загвар болж болох юм. 2000 онд Леван улсын Маронайт сүмийнхэн өөрсдийн тахин шүтдэг Харисса ойн зарим хэсгээ Маронайтын дархан цаазат газар болгожээ. Гурван хамгийн том газар эзэмшигчид нь барилгын компаниудын санал болгосон их хэмжээний мөнгөнөөс татгалзаж энэхүү төлөвлөгөөнд сайн дураараа оролцсон байна. Тэдний нэгээс яагаад ийм шийдвэр гаргах болсон талаар нь асуухад тэрээр багадаа сүмээс зохион байгуулдаг байсан ойн аялал, зугаалгад оролцдог байсан ба “Тэр үе миний амьдралын хамгийн жаргалтай мөчүүдийн нэг байсан юм. Тиймдээ ч одоо би энэ ойгоо хамгаалахыг хүсч байна” хэмээн хариулжээ. Бурханы шашны сүм хийдүүд нь онгологдсон уулнаа зуны зусланг байгуулах боломжтой юу? Магадгүй ирээдүйд нэгэн өдөр Монголын хойч үеийнхэн тэдний онгон, дагшин байдлыг ухаарч болох юм.

#### **Д) Байгаль орчны хяналт**

Та амьдралын сургуулийг нэгэн хичээл гэж үзээд өөрийн шашны сүсэгтэн олныхоо сониуч зан, мэдлэг туршлага дээр тулгуурлан хүрээлэн буй орчны хяналт явуулж болох уу? Зарим тохиолдолд зөвхөн анхааралтай хяналт шинжилгээ, дэс дараалалтай ажиглалтаар гол болон эко-систем дэх ургамал, амьтны аймаг, бохирдлын тухай шинжлэх ухааны мэдээллийг цуглуулан аливаа бохирдолоос урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авч болдог. Хэрвээ танай орон нутгийн иргэдийн онголон шүтдэг, байгалийн үзэсгэлэн бүрдсэн газар нутаг, уул ус байдаг бол та бүхэн одоо түүнийг хайрлан хамгаалахад нэн таатай үе ирээд байна.

Улаанбаатар хотоос баруун зүгт 140 км зайд орших Багануурын нүүрсний уурхай нь 200 сая тонн нүүрсний нөөцтэй бөгөөд жилд 2500 тонн орчим нүүрс олборлон тухайн орон нутгаа бохирдуулахын зэрэгцээ хүн амын дунд амьсгалын замын өвчлөл үүсгэн, хөрсний эвдрэлийг бий болгодог юм. 2005 онд Онцар Исэй Лин хийдийн лам нар нь Дэлхийн банкны “Голланд-Монголын байгаль орчны шинэчлэлийн төлөөх сан”-ийн хөрөнгө оруулалт болон Японы шинжээчдийн тусламжтайгаар уг уурхайн байгаль орчин болон хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг баримтжуулах төслийг хэрэгжүүлж эхэлжээ. Үүний үр дүнд уурхайчид болон тэдний гэр бүлийнхэн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх зарим нөлөөллүүдийг бууруулах тухай суралцаж, уурхайн удирдлагууд олон нийтийн эсэргүүцлийн өмнө буулт хийн хоргүйжүүлэх механизмуудыг судлан, орон нутгийн сургуулиудын хичээлийн хөтөлбөрт байгаль орчноо хайрлан хамгаалах тухай буддын сургаалийг тусгаж өгсөн байна. АНУ-ын далайн баруун эргийн дагуу урсах Колумби голын хөндийгөөс үүссэн Католик шашны епископ нь 1980-аад онд өөрсдийнх нь шүтэж хайрлаж ирсэн голын суваг нь бохирдож эхэлж буйг анзаарчээ. Тэд өөрсдийн сүсэгтэн олныг голын дагуу хяналт явуулахыг уриалсан бөгөөд уг ажиглалтаар илрүүлсэн баримт мэдээллээ тухайн газар нутгийн засаг захиргааны бүх шатны байгууллагууд, бохирдлыг бий болгож байгаа аж ахуй нэгжүүд болон олон нийтэд захиа, мэдээлэл, сургалт сурталчилгаагаар дамжуулан нөлөөллийн ажлыг зохион байгуулснаар одоо уг голын суваг харьцангуй цэвэрхэн болсон байна.

### **3. Номлол -шашны номлол, уламжлал ба эрдэм мэдлэг**

Аливаа шашин зовж шаналсан хэн бүхэнд өөрийн сургааль, номлолоор дамжуулан тайтгарлыг өгдөг.

#### **А) Сургалт**

Та бүхэн ирээдүйд танай шашныг удирдагч эсхүүл багш болох хүмүүсийг бэлтгэхдээ тэдэнд байгаль орчны талаар мэдлэгийг хэрхэн, яаж сургадаг вэ? Монголд Шри Кушак Бакулагийн үүсгэн байгуулсан коллежийн жишээгээр залуу лам нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг илүү “байгальд орчинд чиглэсэн” болгож болох уу?

### **Б) Хямрал болон дасан зохицол**

Танай шашинд хямрал, сүйрлийн талаар юу гэж сургадаг вэ? Урьд өмнө аливаа хүнд хэцүү байдал, хямралыг хэрхэн даван туулдаг байсан бэ? Таны шашны үзэл баримтлалаар өнөөдөр дэлхий ертөнцөд тулгараад байгаа цаг уурын өөрчлөлтийг хүн төрөлхтөний өмнө тулгараад буй хямрал хэмээн үзэж болох уу? Хэрэв тийм бол та бүхэн өөрсдийн туршлагад тулгуурлан уг хямралыг хэрхэн даван туулах талаар бодлого боловсруулах боломжтой юу?

### **В) Шашны зан үйл, ишлэл ба залбирал**

Танай шашны зан үйл, ном судар, сургаалиар дамжуулан байгаль орчноо хайрлан хамгаалах уламжлалт аргуудыг номлоод зогсохгүй, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, хүнийг юу эзэмшиж, хэрэглэж буйгаар нь биш бусдад хэрхэн хандаж байгаагаар нь дүгнэхийг сургаж болох уу?

### **Г) Онгологдсон газрууд**

Та бүхний шүтэн дээдлэж, онголсон дархан газрууд нь зэрлэг онгон байгалийг хэвээр хадгалан авч үлдэхэд хэр үүрэгтэй байдаг вэ? Жишээ нь: Ялангуяа төв газарт байрладаг сүмийн цэцэрлэгүүд ихэнхдээ мини-эко-системийг бүрдүүлдэг, онгологдсон уулс нь ховордсон амьтдын сүүлчийн орогнох газар болдог, худаг, шанд болон нуур зэрэг ариун усны эх ундарга нь амьдрах газраа алдсан амьтдын сүүлчийн найдвар болдог билээ.

Хятад дахь онгологдсон уулсыг хэдэн зууны турш Дао шашны лам болон гэлэнмаа нар нь хамгаалсаар иржээ. Одоо Дао шашин нь энэхүү чухал, оюун санааны болоод байгалийн өвөрмөц тогтоцын өлгий нутаг болсон газар нутгаа аялал жуулчлал, хөгжил дэвшил болон мод бэлтгэлээс үүсэх дарамтаас хамгаалахын тулд байгаль орчноо хамгаалах хөтөлбөр боловсруулахаар идэвхи зүтгэлтэй ажиллаж байна. Сүм дуган болон Лалын шашны сүм хийдүүдийн ойролцоо орших цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар ба цэцэрлэгүүд нь ихэнх том хотуудын хувьд цөөн хэдэн зэрлэг онгон байгалийн төрхөө алдаагүй газруудын нэг байдаг. Зарим газар оронд хүмүүс өвсөө хадахгүй, хортон шавж устгах бодис хэрэглэхгүй байж, тухайн газар нутгийнхаа байгалийн унаган төрхийг эргэн сэргээх, хадгалах арга хэмжээ авч байгаа төдийгүй зочилон ирж байгаа хүмүүст өөрийн үйл ажиллагаагаа таниулах мэдээллийн гарын авлага бэлтгэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал: Истанбулын Еюүпийн лалын сүмийн хөгшин модод нь өрөв тасын амьдрах сүүлийн газар болж үлдсэн билээ.

### **Д) Түүх ба заншлууд**

Танай өвөг дээдэс эрт дээр үеэс байгаль дэлхийгээ хэрхэн хайрлан хамгаалж ирсэн тухай өгүүлэх мартагдсан түүх судар, ном эсхүүл уламжлалт зан үйл байдаг уу? Хэрвээ байдаг бол үүнийг дахин сэргээх боломжтой юу?

### **Е) Идээшин дасах**

Танай шашны удирдлагууд эсхүүл танай багш нар байгалийн гамшиг, цаг уурын өөрчлөлтөд өртөж байгаа ард иргэдэд ямар тусламж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй гэж та үздэг вэ? Хар салхи, халдварт өвчин, үер усны гамшиг тохиоход танай сүм хийдийн зүгээс ард иргэдэд ямар тусламж дэмжлэг үзүүлэх боломжтой вэ? Энэ талаар танай сүм хийд тодорхой бодлого чиглэл гаргасан уу?

### **Ё) Залбирал**

Залбирал нь бүх шашны үйл ажилгаануудын хамгийн чухал цөм байдаг. Та илүү эв нэгдэлтэй ертөнцийн төлөө, өөрсдийн өөрчилж болох асуудлуудад гарц олохын төлөө, өөрчилж чадахгүй зүйлсээ хүлээн зөвшөөрөхийн төлөө залбирч болох уу?

Буддын шашны их багш Франгү Ринбүүчигээс дэлхийн цаг агаарын өөрчлөлтийн талаар буддын шашинтнууд юуг хийвэл зохих талаар асуужээ. Тэрээр хүмүүс дараах хоёр зүйл хийвэл зохино хэмээн айлдсан юм: “Нэгдүгээрт, хүмүүс тэдэнд ямар зүйл тохиолдоод байгааг ухаарах хэрэгтэй ба цаашид яах талаар сайтар тунгаан бодож, арга замыг тодорхойлох. Хоёрдугаарт, чин сэтгэлээсээ бурхан Буддад залбирах хэрэгтэй. Энэ нь хэдийгээр дэлхийн дулаарлыг шууд зогсоохгүй ч бидний үзэл санаа аажмаар өөрчлөгдөхөд тус болох болно. Ингэснээрээ бид энэ нөхцөл байдлаас гарах гэж хичээн зүтгэх болно”.

#### **4. Амьдралын хэв маяг**

##### **А) Хяналт**

Танай шашны байгууллага, гэр бүл эсхүүл та өөрөө хувь хүнийхээ хувьд өөрийн хөрөнгөө хэрхэн ашиглаж буй талаар болон таны ашиглаж буй байгалийн нөөцийн хэрэглээ, дахин боловсруулалт, эрчим хүчний эх үүсвэрийг хэр үр ашигтай зарцуулж байгаа талаараа байгаль орчны хяналт шинжилгээ, дүгнэлтийг гаргуулж байсан уу? Та өөрийн сүсэгтэн олноо байгаль орчны хяналт явуулан тулгамдаж буй асуудлуудад тохирох шийдэл хайхад нь дэмжиж, туслах боломжтой юу? Хэрвээ үгүй бол энэ баримтын төгсгөлд хяналт шалгалт явуулах арга замуудтай танилцаарай.

##### **Б) Амьдралын хэв маяг**

Та хийддээ ирж байгаа сүсэгтэн олныг хэрхэн байгаль орчинтойгоо зөв харьцах талаар зөвлөгөө өгөх боломжтой уу? Хэрвээ тийм бол ямар зөвлөгөө өгдөг вэ? Тэдний үйл ажиллагааг хэрхэн дэмждэг вэ? Харин үгүй бол энэ бас Танай Найман жилийн төлөвлөгөөний гол хэсэг нь байж болох юм шүү.

Жайн шүтлэгт залуучуудын холбоо нь эртнээс өөрийн гишүүдээ энгийн, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг хоол хүнсэндээ хэрэглэхийг хөхүүлэн дэмжсээр иржээ. Тэд ингэснээрээ амьтдыг их хэмжээгээр хороосноос үүдэх зовлонгийн шалтгаан, муу кармагийн үр дагавраас ангид оршоод зогсохгүй амьтдыг таргалуулахад ашигладаг үр тарианы хэрэглээ болон уг амьтдаас ялгарах хүлэмжийн хийг багасгаснаараа дэлхийгээ экологийн хувьд аврах алхам хийж байна гэдэгтээ итгэлтэй байгаа билээ. Монгол нь эрт дээр үеэс махыг хүнсэндээ түлхүү хэрэглэдэг ч зарим газруудад хүнсний ногоог хэрэглээнд нэвтрүүлэх боломж байна уу? Хилийн чанад дахь хөгжлийн төлөөх Католик шашинтангуудын сан нь эртнээс “Эгэл даруу амьдарсанаар та өөр хэн нэгэнд амьдрах боломж олгодог” гэсэн нэртэй компанит ажлыг өрнүүлээд байгаа билээ. Уг компанит ажлын хүрээнд тэд Католик шашинтнуудыг бусдад өгөөмөр хандан, байгаль орчиндоо хайр гамтай хандахыг бурханы өмнө андгайлахыг уриалдаг юм.

##### **В) Гэр бүл, хүн ам болон сонголтууд**

Дэлхийн хүн амын тоо нь ирээдүйн байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл, түлш, эрчим хүчний хэрэглээ зэрэг асуудлуудыг үүсгэх нь мэдээжийн хэрэг билээ. Хэдийгээр зарим шашны үзэл баримтлалд гэр бүлийн гишүүдийн тоог хязгаарладаг хэдий ч энэ нь маргаантай асуудал хэвээр байна.

Өөрийн орны хүн амын тоог шашны номлол, эдийн засаг болон эрх зүйн зохицуулалтаар хамгийн амжилттай зохицуулж буй орнуудын нэг нь Иран юм. Муслиманы шашны тэргүүнүүд нь “Хүн тэжээж чадаа хэмжээгээрээ хүүхэдтэй байх ёстой” гэсэн Мухаммедийн сургаалийг удиртгал болгохын сацуу жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зөвшөөрлийг олгосон байна. 1986-2001 оны хооронд хүн амын өсөлт нь 3.2-оос 1.2 хувь хүртэлээ буурчээ.

### **Г) Мөргөл хийн бадарчлах газар болон аялал жуулчлал**

Дэлхийд олон сүм хийдүүдийн байрладаг газар нь байгалийн үзэсгэлэн бүрдсэн байдаг ба аялал жуулчлалаар олон хүмүүсийн зорчих газруудын нэг байдаг. Шашны урсгалын хувьд та бүхэн улс орныхоо аялал жуулчлал, мөргөл хийн бадарчлах газарт хэр их үүрэгтэй талаараа бодож үзсэн үү? Уг үйл ажиллагаануудыг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй арга замаар явуулах боломж байна уу? Та урьд өмнө мөргөлчид мөргөл үйлдэн бадарчилах газартаа алхан хүрдэг байсан бол одоо онгоц, машинаар явж ирдэг болсоныг бодолцож үзсэн үү? Энэ бүхний байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулж болох уу?

### **Д) Худалдан авах эрх**

Та болон сүсэгтэн олон хамтаараа байгаль орчноо хамгаалахын тулд худалдан авах эрхээ хэрэгжүүлж болмжтой юу?

Хазон нь Нью Йорк хотноо байрлах Еврейчүүдийн байгаль хамгаалах байгууллага юм. 2004 онд уг байгууллага нь нийгэмлэгт суурилсан “Tuv Ha’Aretz” буюу “Газар дэлхийдээ сайныг, газар дэлхийгээс хамгийн сайныг” гэдэг нэртэй хөдөө аж ахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ. Уг хөтөлбөрийн зорилго нь Еврейчүүдийн шашны нийгэмлэг нутгийн органик фермерүүдтэй хамтран ажиллаж, тэдний ургацын зарим хэсгийг урьдчилан худалдаж авахад оршиж байв. Энэ нь фермерүүдэд баталгаатай зах зээл, харин шашны нийгэмлэгүүдэд хямд үнээр шинэхэн, органик хүнс хэрэглэх боломжийг олгожээ. Илүү өргөн хүрээнд бол энэ нь тариалангийн талбайг хэвээр хадгалан үлдэж, хамт олныг бий болгон, хүрээлэн буй орчны онгон зэрлэг байгаль, усны тогтолцоог хортон шавьж устгах бодисоос хамгаалж байв. 2008 он гэхэд АНУ-д 8, Израйл улсад 1 Tuv Ha’Aretz байгуулагджээ. Хазон нь бас Хүнсний зөвлөгөөн болон Еврейн хөдөө аж ахуйн сургуулийг зохион байгуулдаг байна. Монгол дахь сүм хийдүүд нь нутгийн иргэдээ иймэрхүү байгаль орчиндоо сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй фермийн аж ахуйг дэмжихэд уриалж болох уу? 2000 онд АНУ-ын Нэгдсэн Методист сүмийн эмэгтэйчүүдийн салбар нь сүмийн үйл ажиллагаанд хэрэглэдэг цаасыг үйлдвэрлэхэд хлор ашиглахаа болих тухай санаачлагыг эхлүүлжээ. Хлорын шохой ашиглан цайруулсан цаасыг үйлдвэрлэхэд байгаль орчинд маш хортой хүчил ялгардаг байна. 34 муж дахь (Колумбийн дүүргийг оролцуулан) Нэгдсэн Методист шашинт эмэгтэйчүүд нь Кинкогийн салбар дэлгүүрүүдээр зочилон хлор ашиглаагүй үйлдвэрлэсэн цаас байгаа эсэхийг асууснаар уг цаасны эрэлтийг мэдрүүлжээ. Энэ үед бүх дэлгүүрүүдийн 66 хувьд хлор ашиглаагүй үйлдвэрлэсэн цаас байсан бөгөөд дэлгүүрийн ажилтнууд нь уг цаасны ач холбогдлын талаар муу мэдээлэлтэй, басхүү илүү үнэтэй байсан байна. Хэдэн сарын дараа гэхэд бүх дэлгүүрүүд нь хлор ашиглаагүй үйлдвэрлэсэн цаасыг бусад цаастай ижил үнэтэйгээр худалдаалахыг зөвшөөрчээ.

## **5. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сургалт сурталчилгаа**

### **А) Уг асуудалд хэр анхаарлаа хандуулж байна вэ?**

Танай бүс нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд уг асуудалд хэр анхаарлаа хандуулж байна вэ? Танай сонин сэтгүүл, радио телевизүүд нь экологийн асуудал эрхэлсэн тусгай булан, хэсэгтэй юу? Тэд өөрсдийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан байгаль орчиндоо илүү их анхаарал хандуулж, эгэл жирийнээр амьдрах тухай ард иргэдэд уриалж байна уу? Та бүхэн өөрсдийн найман жилийн төлөвлөгөөг боловсруулах үйл явцаа мэдээлэл, хэлэлцүүлэг, зургийн галлерей зэргээр вэб хуудсандаа байрлуулна уу?

### **Б) Нөлөөлөл**

Та засгийн газрынхаа байгаль орчны талаар гаргадаг шийдвэрт хэр нөлөөтэй вэ? Та хэр зэрэг илүү нөлөөллийг тогтоох боломжтой вэ? Та үндэсний радио телевизээр дамжуулан долоо хоног бүрийн шашны нэвтрүүлэг зэргээр уг асуудалд олон түмний анхаарлыг хандуулах боломжтой юу?

### **В) Сурталчилгаа**

Та одоо өөрөө идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй тул бусдыг ч гэсэн уг асуудалд нухацтай хандах талаар ятгах боломжтой боллоо. Та бүс нутгынхаа эсхүүл улсынхаа томоохон улс төрчид, удирдах хүмүүс, багш сурган хүмүүжүүлэгчид болон шашны тэргүүнүүдээ лоббидон дэлхийн цаг уурын дулаарлыг зогсоож, байгаль орчиноо сүйтгэхээ болиход тэдний анхаарлыг хандуулах арга хэмжээ авч болох уу?

### **В) Зааварчилгаа болон гарын авалгууд**

Та бүхэн аудит болон сургалтын материалууд, зааварчилгаа юм уу гарын авлагуудаараа (цаасан дээр, вэб хуудас, гар утас, аудио болон дүрст бичлэг хэлбэрээр) дамжуулан сүсэгтэн олонтойгоо өөрсдийн амьдралын туршлагыг хуваалцаж, эгэл даруу, байгаль орчиндоо ээлтэй амьдрах аргын тухай мэдээлж болох уу? Энэ бүхнийг та хэвлэх үйлдвэр болон вэб хуудсандаа хэрхэн зохицуулж байрлуулах вэ?

2002 онд Гандан хийдийн лам нар ARC, Дэлхийн байгаль хамгаалах сан болон Дэлхийн банкны тусламжтайгаар эртний судруудыг эмхэтгэн “Монголын онголсон газрууд” гэдэг нэртэйгээр хэвлэжээ. Номын эх нь орчин цагийн монгол хэлнээ бичигдсэн бөгөөд коммунизмын үеэр тахин шүтэхийг хориглож байсан газруудын газар зүйн байршил хийгээд зан үйлийн тухай бичсэн байна. Одоогийн байдлаар Монголын хамгийн чухал зургаан онгологдсон газрын тахилгыг тухайн орон нутгийн сүм хийдүүд нь сэргээсэн бөгөөд уг газраа тэмдэглэхийн тулд суврага босгожээ. Зөвхөн 12 сарын дотор л гэхэд тухайн нутагт амьдардаг тарвага, шувуу зэрэг зэрлэг амьтдын тоо толгой мэдэгдэхүйцээр өссөн байлаа. Хэрвээ байгаль орчинд өөрийн жамаар нөхөн төлжих боломж олговол тэр хавийн ургамал, мод нь ирээдүйд эрт цагийн байдалдаа эргэн очно гэдэгт найдаж байна. Уг төслийн хэрэгжсэн гол шалтгаан нь тухайн орон нутгийнхаа удирдлага болон нүүдэлчин ард түмний дунд нөлөө бүхий лам нар суваргуудыг хөхүүлэн дэмжиж байсан билээ.

### **Д) Ашиглагдах материалууд**

Та бүхэнтэй хамтран ажилладаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох сонин сэтгүүл, радио станцууд, вэб хуудсууд болон сургааль номлол, тараах материалыг тань хэвлэдэг хэвлэх үйлдвэрүүд нь өөрсдийн үйл ажиллагааг явуулахдаа байгаль орчноо хэр хамгаалдаг вэ? Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэггүй цаас, бэх зэргийг ашигладаг уу? Та зарим тохиолдолд цаасан дээр мэдээллийг хэвлэн тараалгүйгээр вэб хуудсанд байршуулах боломжтой юу?

Гандан хийдийн лам нар нь ARC болон Дэлхийн Банктай хамтран ан агнах, мод огтлох зэргийг хориглодог эртний цээрт өдрүүдийг тэмдэглэсэн хуанли гаргахаар ажиллаж байсан билээ. Бенедиктийн сургаалийн дагалдагчид нь Дэлхийгээ сонсохуй нэртэй гарын авлагыг Латин Америк дахь өөрсдийн сүм хийдүүддээ зориулан гаргажээ. Уг гарын авлагад байгаль орчноо хамгаалах тухай сургаалиудыг тайлбарлан, тулгамдаад буй асуудлуудаас гарах арга замуудыг зааж өгсөн байдаг бөгөөд та үүнийг ARC-ийн вэб хуудаснаас англи, португал болон испани хэлнээ олж үзэж болно.

**6. Нөхөрлөл, eco-twinning (ижил төстэй экологийн асуудлуудтай тулгараад буй бүс нутгуудыг хооронд нь холбох), өөрсдийн байгаль хамгаалах албуудыг байгуулах**

**А) Тууштай хамт олон**

Таньд байгаль орчныг хамгаалах талаар үйл ажиллагаа явуулахад туслах тууштай хамт олон бий юу? Хэрвээ үгүй бол та өөрсдийн байгаль хамгаалах албыг байгуулах талаар бодолцож үзнэ үү?

Камбож дахь буддын шашинтнууд нь Байгаль орчныг хамгаалах буддын шашинтнуудын холбоо гэдэг нэртэй өөрсдийн байгаль орчныг хамгаалах байгууллагыг байгуулжээ. Энэхүү байгууллагын үйл ажиллагааг лам нар удирдан явуулдаг бөгөөд янз бүрийн бие даасан агентлагуудтай хамтран дахин ойжуулалт, хүрээлэн байгаа орчны талаарх боловсрол олгох, байгаль орчинд нөлөө үзүүлэхгүй байр сууц барих зэргээр хамтран ажиллаж байна. Эхлээд буддын шашинтнуудад бие даасан албан газар нээнэ гэдэг нь нэлээд үнэтэй туслах мэт санагдаж байсан ч энэ нь залуучуудад хүрч ажиллах хамгийн дөт зам болохыг ойлгоцгоожээ. Уг арга замаар шашны үзэл санаагаа түгээхэд кино хийх, вэб хуудас бүтээх зэрэг шинэ ур чадварууд шаардагдаж байсан ч мод суулган арчлах, байгаль болон хүнийг энэрэх зэрэг хуучин чадварууд ч хэрэг болж байна. Ингэж чадсанаараа ч шашин нь эртний итгэл үнэмшлээ хадгалан шинэ эринд оршин тогтнох боломжтой болдог билээ. Хятадад Лоугуандай хийдэд төвтөй Дао-ийн шашны сүм хийдүүдийн холбоо шинээр байгуулагдсан бөгөөд уг хийдийн харьяа Тайбайшаны бунханд ARC болон Голландын байгаль хамгаалах сан EMF-ийн тусламжтайгаар анхны “эко-сүм”-ээ тэд байгуулжээ.

**Б) Энгийн хүмүүс**

Та байгаль орчны салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг энгийн хүмүүстэй тулгарч буй асуудлуудад экологийн гарц олох тухай хамтарч ажиллахаар оролдож байсан уу? Энгийн хүмүүс нь ихэнхи тохиолдолд туслах сонирхолтой байдаг хэдий ч хэн ч тэднээс асуудаггүй байна. Та өөрийн шашны нийгэмлэгийг гишүүд дотроос эрх зүй, усны менежмент, газрын менежмент, боловсрол, хог хаягдлын менежмент зэрэг өөр өөр байгаль орчны салбарт ажилладаг хүмүүсийг оролцуулан Зөвлөлдөх бүлгэмийг байгуулахыг хичээгээрэй. Энэхүү Зөвлөлдөх бүлгэм нь таньд мэргэжлийн зөвлөгөө өгөөд зогсохгүй танийг орон нутгийн, үндэсний, олон улсын агентлагуудтай болон засгийн газартай холбон өгч болох юм. Ингэснээрээ таны хүчин чармайлт хэд дахин нэмэгдэж, илүү өндөр түвшинд хүрэх болно.

Британийн Еврейн шашинтны удирдах зөвлөл нь байгаль орчны бүлгэм байгуулсанаараа Английн нэгдсэн вант улс дахь хамгийн чадалтай бөгөөд мэргэшсэн байгаль орчин хамгаалагчдыг өөртөө татаж чадсан билээ. Тэд урьд өмнө хэзээ ч тэдний ажилд тэдний шүтлэг нөлөөлөх юм уу, ажил нь шүтлэгт нь нөлөөлнө гэж бодож байсангүй. Монголд лам биш ч гэсэн өөрсдийн шүтлэг нь ажилд нь нөлөөлж болох талаар бодож явдаг буддын шашинтнууд байдаг уу?

**В) Бусад нөхөрлөлүүд**

Та эргэн тойрноо ажиглаад органик аргаар фермийн аж ахуй эрхлэх, нарны болон салхины цахилгаан эрчим хүч ашиглах болон үйлдвэрийн хаягдал дахин ашиглах сонирхолтой хүмүүс таньтай хамтран ажиллах эсэхийг сонирхоорой. Та хүрдийг үргэлж шинээр эргүүлэх шаардлагагүй. Та уг талбарт байгаль орчинд хортой нөлөө үзүүлэхгүйгээр үйл ажиллагаа явуулж буй бие даасан нэгжүүдтэй холбоо тогтоосон уу? Та өөрийн бүс нутагтаа байгаль орчинд нөлөөлөх хортой нөлөөллийг багасгах сонирхолтой өөр бусад шашны байгууллагуудтай холбоо тогтоож байв уу? Бусдын явуулж буй үйл ажиллагаатай давхцалгүйгээр өөрсдийн туршлага, мэдлэгээ солилцож болох хүрээлэл та бүхэнд байна уу?

Та бүхэнтэй хамтран ажилладаг бөгөөд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг арилжааны байгууллагууд байдаг уу? Хэрвээ та тэдний бүтээгдэхүүнүүдэд сайн үнэлгээ өгвөл тэд таньд тодорхой хэмжээний хөнгөлөлт үзүүлэх үү?

## **7. Тэмдэглэлт баяр ёслолууд**

### **А) Уламжлалт баяр ёслолууд**

Та орчлон ертөнцийг магтан дуулах юм уу мод суулгах өдөр гэх мэт байгаль орчинд чиглэгдсэн тодорхой баяр ёслолуудыг онцгойлон авч үзсэн үү?

Еврейн шашинд тэмдэглэгддэг Tu B'Shabat буюу Моддын шинэ жилийн баяр нь шинэ залбирал, шинэ төслүүд зэргээр Еврейн шашныг дэлгэрүүлэхэд чухал тус болдог бөгөөд байгаль орчинд чиглэгдсэн томоохон баяр болжээ. Үүний зэрэгцээгээр Еруслам хотноо байсан эртний хоёр сүм хийдийг устгасанд гашууддаг өдөр болох Tisha B'Av нь зарим еврейн уламжлалд байгаль орчныг устгаж буйд гашуудах өдөр болсон байна.

### **Б) Шинэ баяр ёслолууд**

Хэрвээ та бүхэнд уламжлал болгон тэмдэглэж ирсэн орчлон ертөнцийг магтан дуулах баяр байдаггүй бол хуучин байсан баяр ёслолын зан заншлыг авч шинэ баяр ёслолуудыг тэмдэглэж эхэлсэнээрээ илүү байгаль орчноо хамгаалах мэдээг хүмүүст түгээж болох юм.

### **В) Шинэ уламжлалуудыг нэвтрүүлэх индэр бий болгоё**

Олон шашны урсгалуудын тэргүүнүүд нь уламжлалд ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд шинийг нэвтрүүлэхдээ ч цааргалдаггүй. Та магадгүй орчлон ертөнцөд болоод хүмүүст тустай шинэ заншилыг танилцуулж болох юм. Шашин хүмүүсийг хоорондоо эвлэлдэн нэгтгэдэг чухал хүч болдог бөгөөд тэдний шашны зан үйлээ явуулдаг газрууд нь ихэнх тохиолдолд хэлэлцүүлэг, мэтгэлцээн явуулахад тун тохиромжтой барилга, байгууламжууд байдаг билээ. Та өөрийн шашны зан үйлээ явуулдаг газартаа байгаль орчинд тулгараад байгаа асуудлуудыг хэлэлцэхээр үдэшлэг, найр наадам зохион байгуулж, мэтгэлцээн, хэлэлцүүлгүүдийг өрнүүлэн, өөрийн нийгэмлэгийн гишүүддээ өөрсдийн түүхийг хуваалцахаар ирэхийг уриарай.

Танзанийн Евангеликан Лүферан сүмийн хойд дүүрэгт амьдралын чухал үйл явдлуудыг мод суулгахтай холбосон хөтөлбөр хэрэгжиж байгаа билээ. Жишээлбэл, хүүхдийн адис хүртээх ёслол дээр түүний эцэг эхэд модны суулгац бэлэглэдэг байна. Энэ хүүхдүүд нь үүний хариуд уг шашны урсгалд хүлээн зөвшөөрөгдтөлөө олон тооны мод суулгах хэрэгтэй. 1987 онд Английн нэгдсэн вант улс болон Дэлхийн амьд байгалийг хамгаалах сан нар хамтран ургацын баярыг орчлон ертөнцийг магтан дуулах баяр болгох хүсэлтэй нэгдсэн улсын хэд хэдэн сүм хийдүүдтэй хамтран ажиллажээ. Тэдний ихэнхи нь орон нутгийн супермаркетуудын менежерүүдийг урьж байгаль орчноо хамгаалах талаар ямар үйл ажиллагаа явуулж буйгаа тайлагнахыг хүссэн байна. Бүс нутгийн менежерүүд нь юу ярих ёстой талаараа асуух гэж төврүүгээ байн байн залгацгааж байсан гэсэн мэдээ бий. Дараа жил гэхэд тэд өөр өөрсөндөө тохирсон төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэнээрээ хийж бүтээсэн, ярьж хэлэх зүйлтэй болсон байлаа. 1993 оны байдлаар орон даяар нийт сургуулиудын дөрөвний нэг нь болон 1000 гаруй сүм хийдүүд Ургацын баярыг тэмдэглэдэг болжээ.

### **Г) Үзэсгэлэнт газрууд болон шинэ хөгжлийг ёслон тэмдэглэе**

Дэлхий маань олон асуудалтай тулгараад буй хэдий ч үзэсгэлэн төгөлдөр хэвээрээ байгаа билээ. Заримдаа энэ их уйтгар гуниг, байгаль орчны мөхлийг зөгнөсөн зөгнөлүүдийн дундаас дэлхий дээр байгаа үзэсгэлэнтэй, сайхан, баатарлаг, зоригт зүйлсийн талаар

болоод амьдралын тухай хүмүүст сануулж байх нь шашны үүрэг юм. Шинэ дэвшилттэй хөгжил, унаган байгаль, эко-систэмээ хэвээр авч үлдэх бололцоонуудыг ч гэсэн хамтдаа тэмдэглэн, баярлаж талархсан сэтгэгдлээ хуваалцаж байцгаая.

## **II. Дараагийн алхам юу вэ?**

Монголын буддын шашинт хамт олныг дараагийн найман жилд өөрсдийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлэхийг бид бүхэн урьж байна. Та дээрх сэдвүүдийн бүгдийг нь юм уу хэсгийг нь судалж үзсэнийхээ дараа Үе дамжсан өөрчлөлтөд чиглэсэн найман жилийн төлөвлөгөөгөө боловсруулж эхлэхийг бид та бүхнээс хүсч байгаа билээ. Уг төлөвлөгөөнүүдийг дэлхийн улс орнуудын янз бүрийн нийгэмлэгүүд боловсруулж буй учир өөр өөр хандлага гарч ирэх нь зүйн хэрэг билээ. Хамгийн гол нь уг хандлага таны болоод таны шашны уламжлал, зан заншлыг илтгэж байхыг бид хүсч байна. Бид хамгийн чухал гэж үзсэн долоон хүрээг дээр дурьдсан билээ. Тэдний хоёроос, гурав нь таны асуудлын гол цөмийг агуулж, бусад нь туслах шинж чанартай байж болох юм. Та аз туршсан, зоригтой байх хэрэгтэй ч уг төлөвлөгөөг зөвхөн анхны алхамаа хийхэд зориулах найман жилд бус, дараа дараачийн үр удам тань цаашид өөрсдийн ёс зүйн дээд чанартаа мэдэрч болохоор хэрхэн санхүүжүүлж, удирдан чиглүүлэх ёстойгоо бодолцож үзээрэй. Та бодит байдал дээр ямар хэр хэмжээнд үүнийг ажлын байр, зохион байгуулалттай болгож чадах вэ? Та үүнийг удирдан зохион байгуулахын тулд шинэ хүмүүсийг томилох юм уу элсүүлэх шаардлагатай юу? Бид та бүхнийг өөрсдийн найман жилийн төлөвлөгөөгөө 2009 оны 7 сар гэхэд бидэнд танилцуулахыг хүсч байна. Бидэнд дэлхийн голлох байгаль орчныг хамгаалах байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн чиглүүлэх баг байгаа бөгөөд хэрвээ та бүхэн дургүйцэхгүй бол тэд таны найман жилийн төлөвлөгөө тань байгаль орчныг хамгаалахад ач холбогдолтой эсэх, мөн түүнчлэн амьдралд хэрэгжих боломжтой эсэх талаар зөвлөгөө өгөх болно. Мөн түүнчлэн, уг төлөвлөгөөгөө өөрсдийн нийгэмлэг болоод илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх талаар бололцоог хайхад тань бид туслахыг хүсч байна. 2009 оны 11 сар гэхэд бид бүх төлөвлөгөөнүүдийн тоо болон хэрэгжих хүрээ, зорилго зэргийг олон нийтэд зарлах хүсэлтэй байгаа билээ. Бид таныг уг үйл ажиллагаанд өөрийн зардлаар биечлэн юм уу онлайнээр оролцохыг урьж байна.

## **III. Нөөц боломжууд ба харилцаа холбоо**

The Alliance of Religions and Conservation (ARC)  
The House, Kelston Park, Bath  
BA1 9AE, United Kingdom  
Tel: 01225 758004  
E-mail: [info@arcworld.org](mailto:info@arcworld.org)  
Website: [www.arcworld.org](http://www.arcworld.org)

## **НОМ ЗҮЙ**

Hind, B., (2000). The Revival of Buddhism in Mongolia at <http://www.chezpaul.org.uk/buddhism/mirror/mfn/mongolia/>

Monkhsaikhan, D. (Ed.), (2004). *Sutras for the Worship of Sacred Sites*, Ulaanbaatar: Alliance of Religion and Conservation, World Bank & World Wide Fund for Nature.

Moses, L. W., (1977). *The political role of Mongol Buddhism*, Indiana University Uraliac Altaic series, Vol. 133, Bloomington: Asian Studies Research Institute.

Northern Buddhist Conference on Ecology and Conservation, Ulaanbaatar, (2005). Ulaanbaatar: Alliance for Religions and Conservation

Palmer, M. and V. Finlay (2003). *Faith in Conservation: New Approaches to Religions and the Environment*, Washington, D.C.: World Bank

Sukhbaatar, O. (2002). *Sacred sites of Mongolia*, Ulaanbaatar: World Wide Fund for Nature & Alliance of Religion and Conservation

Thrift, E, & G. Verboom (Eds) (2005). *Northern Buddhist Conference on Ecology and Conservation*, Ulaanbaatar, Ulaanbaatar: Alliance of Religions and Conservation

Verboom, G., *A History of Religion in Mongolia* at [www.mongoluls.net/mongolian-religion/monrelihis.shtml](http://www.mongoluls.net/mongolian-religion/monrelihis.shtml)

World Bank (2006). *Faiths and the Environment: World Bank Support 2000-05*, Washington, D.C.: World Bank

Worden, R. L. & A. M. Savada (eds.) (1989). *Mongolia – A country study*, Washington D.C.: Library of Congress at <http://lcweb2.loc.gov/frd/cs/mntoc.html>

## НОМ БҮТЭЭГЧИД



### **Чимэдсэнгээгийн Уранцацралт:**

ARC-ийн төсөл дээр ажиллаж байхдаа “Уламжлалт байгаль хамгаалах арга” (2006), “Овоо тахилгын ёс” (2006) зэрэг олны талархлыг хүлээсэн 5 номыг бүтээхэд оролцсон бөгөөд Байгаль Экологи, Хөгжил сэдэвт хойд бүсийн бурханы шашинтнуудын бага хурлын нарийн бичгээр ажиллаж байв.




### **Амбер Криппс:**

2004 оноос хойш Энэтхэг, Монгол орнуудад амьдарч байгаа бөгөөд Төвд, Монголын бурханы шашинтнуудад зориулсан байгаль хамгаалал болон нийгмийн төслүүдийг хэрэгжүүлдэг. Шашин шүтэх эрх чөлөө болон байгаль орчин гэсэн сэдвээр судлагаа хийсэн бөгөөд антрапологи, байгаль орчин, хүний эрхийн салбарт туршлагатай. 2006 онд Монголд ирж энэ нутгийн онгон дагшин байгалийг хадгалах, хамгаалах чиглэлээр ажиллаж эхэлсэн.



### **Виктори Финлэй:**

Зохиолч, сэтгүүлч мэргэжилтэй. Англи улсад төвтэй Шашин ба Байгаль Хамгаалах Холбооны (ARC) харилцааны асуудлыг хариуцдаг. ARC болон Дэлхийн Банкнаас ивээн тэтгэн хэвлүүлсэн О. Сүхбаатарын “Монгол орны ариун дагшин газрууд” хэмээх номыг 2002 онд бүтээхэд анх Монголд ирж байсан. Хамгийн сүүлд 2008 онд Гандантэгчэнлин хийд болон ТТФ-аас хамтран зохион байгуулсан “Нигүүлсэл ба Байгаль Орчин” хуралд оролцон Хар Хорины Эрдэнэзуу хийдээс хэрэгжүүлж буй төслүүдтэй биечлэн танилцажээ. Дэлхийн олон шашны урсгалуудтай хамтран ажилладаг бөгөөд тэднийг Найман жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.



### **Гүйдо Вербүүм:**

Монголд 2000 оноос хойш соёлын төслүүд дээр ажиллаж байгаа.



**Батчулууны Мөнхбаатар:**

МБШТөв Гандантэгчэнлин хийдийн гадаад харилцааны лам. 1998-2002, 2003-2004 онуудын хооронд Энэтхэг улсад Төвдийн бурханы шашны гүн ухааны Сэра Жэй дацанд суралцаж байсан. 2006 онд Дээрхийн Гэгээнтэн XIV Далай ламыг Монголд айлчлахад англи хэлний орчуулагчаар ажиллаж байсан бөгөөд “Шашин Байгаль Орчин Хөгжил” номыг англи хэлнээс Монгол хэлрүү хөрвүүлсэн. Гандантэгчэнлин хийдээс явуулж буй байгаль орчны асуудлуудад голлож оролцдог.

**Да Лам Хөнхөрийн Бямбажав:**

МБШТөв Гандантэгчэнлин хийдийн Да Лам бөгөөд Өндөр Гэгээн Занабазарын Нэрэмжит Бурханы Шашны Их Сургуулийн захирал Х. Бямбажав нь энэхүү номны Монгол эхийг хянан шүүсэн бөгөөд 2001 оноос өнөөг хүртэл Гандантэгчэнлин хийдээс байгаль орчны хүрээнд гадаад, дотоодын байгууллагуудтай харилцан ажиллах асуудлыг эрхэлж байна.

**Бурханч н. Дөлгөөн:**

Бурханы Шашны Урлахуйн Ухааны Дээд Сургуулийн төгсөгч тэрээр энэхүү товхимолд орсон Цагаан өвгөн ба Урт наст зургааг зурсан. Тэрээр Бакула Ринбүчэгийн Бэтүв хийдийн шүтээн урлагийн тэнхимд ажилладаг.